


Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудад Дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх суурь судалгаа




Энэхүү тайлангийн агуулга нь “Ази, Номхон далайн орнуудын олон улсын ойлголцлын боловсролын төв” (APCEIU) болон Монгол Улсын Соёл, урлагийн их сургуулийн (СУИС) бодлого, байр суурийг бүрэн илэрхийлэхгүй байж болно.

Тайланг эш татах тохиолдолд эх сурвалж болон зохиогчдыг зохих ёсоор дурдан тэмдэглэх шаардлагатай.

APCEIU–СУИС хамтарсан судалгаа:

Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудад **Дэлхийн иргэний боловсролыг** нэвтрүүлэх суурь судалгаа



ӨМНӨХ ҮГ

APCEIU-ийн Захирлын мэндчилгээ

Дэлхийн иргэний боловсрол (ДИБ)-ыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) болон Боловсрол 2030 хөтөлбөрт тусгаснаас хойш боловсролын олон түвшинд уг чиглэлийг хэрэгжүүлэх нэгэн зэрэг, тасралтгүй хүчин чармайлт өрнөж байна. Олон улсын харилцан ойлголцлын боловсрол болон Дэлхийн иргэний боловсролыг дэмжих гол байгууллагуудын нэг болох Ази, Номхон далайн орнуудын олон улсын ойлголцлын боловсролын төв (APCEIU) нь БНСУ болон Ази-Номхон далайн бүс нутгийн дээд боловсролын байгууллагуудад ДИБ-той холбоотой хөтөлбөр, сургалтын агуулгыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд системтэй, тууштай дэмжлэг үзүүлсээр ирсэн билээ.

2025 онд APCEIU нь Монгол Улсын Соёл, урлагийн их сургууль (СУИС)-тай хамтран Монгол Улсын дээд боловсролын байгууллагуудад Дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх зорилготой судалгааны төслийг хэрэгжүүлэв. Энэхүү санаачилга нь СУИС-ийг жишээнд үндэслэн, Монголын их дээд сургуулиудын ахисан түвшний хөтөлбөрт ДИБ-ыг нэвтрүүлэх загвар, арга зүйн хүрээ боловсруулахыг зорилоо. Монгол Улсын зургаан төрийн өмчийн их сургуулийн нэг болох СУИС нь соёл, урлагийн боловсролын хөтөлбөрүүдэд ДИБ-ын зарчим, үзэл баримтлалыг нэвтрүүлэх загвар байгууллага болох онцгой боломж, давуу талтай юм.

Энэхүү тайлангийн эхний бүлэгт судалгааны зорилго, үндэслэл, арга зүйг танилцуулж, дээд боловсрол дахь Дэлхийн иргэний боловсрол (ДИБ)-ын талаарх тойм ойлголтыг өгсөн болно. Үүний дараагаар СУИС-ийн хэмжээнд ДИБ-ыг нэвтрүүлж болох таван үндсэн хандлагыг тодорхойлж, БНСУ-ын их, дээд сургуулиудад ДИБ-ын агуулгыг хэрэгжүүлсэн кейсүүдийг авч үзсэн. Дараагийн бүлгүүдэд Монголын дээд боловсролын байгууллагуудад тулгамдаж буй сорилт, хандлагыг судалж, СУИС дахь ДИБ-ыг хэрэгжүүлэх өнөөгийн байдалд үнэлгээ дүгнэлт өгсөн. Тайлангийн төгсгөлд СУИС-д ДИБ-ыг нэвтрүүлэх замын зураглал (roadmap)-ыг санал болгож, богино хугацаанд хэрэгжүүлж болох шат дараалсан санаачилгуудыг тодорхойлон, монголын бусад дээд боловсролын байгууллагуудад ч мөн адил хэрэгжүүлэх боломжтой арга зам, зөвлөмжүүдийг санал болгож байна.

Тайлангийн гол зорилго нь СУИС-д байгууллагын түвшинд Дэлхийн иргэний боловсрол (ДИБ)-ыг нэвтрүүлэх үйл явцыг дэмжихэд оршиж байгаа боловч, энэхүү судалгааны үр дүн нь Монголын бусад дээд боловсролын байгууллагуудын хувьд ч ДИБ-ыг тогтвортой, системтэйгээр ашиглаж болох загвар хүрээ болох боломжтой гэж найдаж байна. Түүнчлэн энэхүү тайлан нь оюутан, багш, судлаачдын дунд ДИБ-ын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, дээд боловсрол дахь ДИБ-ын судалгааг урагш ахиулах, улмаар бусад байгууллагуудыг ДИБ-ын хүрээнд харилцан ойлголцол, энх тайван, нийгмийн хариуцлагыг бэхжүүлэх нийтлэг хүчин чармайлтад нэгдэхийг уриалахад хувь нэмэр болно гэж найдаж байна.

Эцэст нь, энэхүү хамтарсан судалгааг удирдан чиглүүлсэн БНСУ-ын талын судалгааны багийн ахлагч, профессор Жу Тэ Хүн болон энэхүү судалгаанд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан зочин профессор И Жи Хян нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн Монголын талын судалгааны багийг ахалж ажилласан СУИС-ийн дэд профессор Дагмидын Одсүрэн болон судалгааны багийн гишүүд болох Балдандоржийн Мандухай, Дашцэдэнгийн Түмэннаст, Мягмарсүрэнгийн Амартүвшин, Чойжилсүрэнгийн Дэлгэрцэцэг, Биндэръяагийн Пунсалдулам нарын үнэтэй хувь нэмэрт чин сэтгэлээсээ талархаж байна.

Цаашид СУИС-тай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж, Монголын дээд боловсролын салбарт төдийгүй бүс нутгийн хэмжээнд Дэлхийн иргэний боловсролыг дэмжих хамтын зорилгодоо улам бүр ахиц дэвшил гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Им Хёнь Мүг
Захирал
APCEIU

СУИС-ийн Ректорын мэндчилгээ

Монгол Улсын Соёл урлагийн их сургууль нь монголчуудын өв, уламжлал, үндэсний урлагийг судлан хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлст олон арван жилийн түүхийг бүтээлцсэн үндэсний тэргүүлэгч их сургууль билээ. Соёл, урлагийн боловсролыг бид тухайн үндэстний соёл, уламжлал болон хүн төрөлхтний хамтын ирээдүйг холбох гүүр гэж үздэг.

Манай сургууль мэргэжлийн уран бүтээлч, судлаачдыг бэлтгэхдээ мэдлэг, ур чадвар олгохоос гадна эх орон, дэлхийн сайн сайхны төлөө сэтгэл зүрх, авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээ, хариуцлагыг эрхэмлэдэг иргэнийг төлөвшүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Ийм учраас манай хамт олон ДИБ-ыг монголын дээд боловсролын салбарт нутагшуулах зорилгоор Ази, Номхон Далайн орнуудын олон улсын ойлголцлын Боловсролын Төв (APCEIU)-тэй хамтран ажиллаж байгаадаа баяртай байна.

Тус төсөл нь богино хугацаанд өнөөгийн нөхцөл байдлыг судалж, ДИБ-ын агуулгыг нутагшуулах замын зураглалыг гаргасан, үр дүнтэй бөгөөд ач холбогдол бүхий ажил боллоо.

Соёл, урлагийн их сургуулийн нэрийн өмнөөс энэхүү төслийг хэрэгжүүлэхэд тууштай дэмжлэг үзүүлсэн APCEIU-ийн Судалгаа, хөгжүүлэлтийн албаны дарга Жи Сонн Ми, төслийн мэргэжилтэн И Жи Хён нар болон хамтран ажилласан профессор, судлаач багш нарын оруулсан үнэтэй хувь нэмрийг онцлон тэмдэглэмээр байна.

Мөн энэхүү судалгаанд оролцсон монгол судлаачдын баг болон судалгаанд идэвхтэй хамтран ажиллаж, санал бодлоо хуваалцсан багш, ажилтнууддаа, төслийн үйл явцад дэмжлэг үзүүлсэн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний хөтөлбөрийн алба, Оюутны хөгжил, үйлчилгээний газарт чин сэтгэлийн талархал илэрхийлье. Бид энэхүү хамтын ажиллагаа нь СУИС-ийн үндэсний үнэт зүйлсийг дэмжих, боловсролд уялдуулах урт хугацааны санаачилгуудтай нийцэж, үндэсний өв соёлыг дэлхийд холбох гүүр болж байгаад баяртай байна.

Бид хамтдаа соёл, урлагийн боловсролоор дамжуулан дэлхийн иргэний боловсролын бат бөх суурийг тавьсан гэж үзэж байна. Цаашид СУИС болон APCEIU-ийн хамтын ажиллагаа улам өргөжиж, энэхүү түншлэл нь ирээдүйн дэлхийн иргэн, уран бүтээлч, багш нарт шинэ урам зориг, боломж нээх болно гэдэгт итгэлтэй байна.

Ч.Бат-Эрдэнэ,

СУИС-ийн ректорын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Агуулга

1. Удиртгал	1.1 Үндэслэл	03
	1.1.1 Дэлхийн иргэний боловсролын (ДИБ) парадигм	03
	1.1.2 Дэлхийн иргэний боловсролын үзэл баримтлалын хүрээ	04
	1.1.2.1 ЮНЕСКО-ийн ДИБ-ын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээ	04
	1.1.2.2 ЮНЕСКО-ийн ДИБ-ын сургалтын зарчмууд	06
	1.2 Судалгааны зорилго ба хүлээгдэж буй үр дүн	07
	1.2.1 Зорилго	07
	1.2.2 Хүлээгдэж буй үр дүн	07
	1.3 Судалгааны арга зүй	08
	1.3.1 Нөхцөл байдлын шинжилгээ	08
	1.3.2 Кейс судалгаа	09
	1.3.3 Дугуй ширээний хэлэлцүүлэг	09
2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь	2.1 Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах таван хандлага	13
	2.1.1 Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах таван хандлага	13
	2.2 Монголын ахисан түвшний сургалтын хөтөлбөрт таван хандлагыг уялдуулах нь	15
	2.3 БНСУ-ын их, дээд сургуулиудын ДИБ-ын жишээнүүд	17
	2.3.1 Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн хөтөлбөр	17
	2.3.2 Иргэний боловсролын чадамжийг сайжруулах хөтөлбөр — Багш бэлтгэх их сургуулиудад зориулсан санаачилга	25
3. СУИС дахь дэлхийн иргэний боловсролын өнөөгийн нөхцөл байдал	3.1 Монгол Улсын Дээд боловсролын салбарын тойм	33
	3.2 ДИБ-ын байгууллагын түвшний хэрэгжилт	34
	3.2.1 СУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс	34
	3.2.2 Оюутны хөгжил ба Хүн төвт боловсрол	34
	3.2.3 Хөтөлбөрийн замнал ба заах арга зүйн хэрэгжилт	36
	3.2.4 Сургалтын хөтөлбөрийг сайжруулах санаачилгууд	39
	3.2.5 Хөтөлбөрөөс гадуурх сургалт	41
	3.3 Дэлхийн иргэний боловсролын талаарх багш нарын мэдлэг ба хандлага	42
	3.3.1 Багш нарын хандлага ба байгууллагын орчин	43
	3.3.2 ДИБ талаарх багш нарын мэдлэг ба хичээлд тусгагдсан байдал	44
	3.3.3 ДИБ-ыг хөтөлбөрт тусгах бэлэн байдал ба хэрэгжүүлэх арга замын төсөөлөл	45
	3.4 СУИС-ийн стратеги ба нөхцөл байдлын үнэлгээ	46
	3.5 Нэгдсэн үр дүн ба хэрэгжилтийн байдал	49

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь	4.1 СУИС-д ДИБ-ыг нэвтрүүлэх замын зураглал	53
	4.1.1 Хандлага 1: Ахисан түвшний ДИБ-ын бие даасан хөтөлбөр нээх боломж, нөхцөл	54
	4.1.2 Хандлага 2: Зэргийн бус хөтөлбөр хэрэгжүүлэх боломж	56
	4.1.3 Хандлага 3: ДИБ-ын шинэ хичээл бий болгох	58
	4.1.4 Хандлага 4: Одоо байгаа хичээлийн агуулгад ДИБ-ыг тусгах	60
	4.1.5 Хандлага 5: ДИБ-ыг хичээлээс гадуурх сургалт, арга хэмжээгээр дамжуулан нэвтрүүлэх	61
	4.2 Зарим хандлагыг хэрэгжүүлэх жишиг хичээлийн төлөвлөгөө	63
	4.2.1 Хандлага 2-ын хичээлийн жишиг төлөвлөгөө: Зэргийн бус хөтөлбөр	64
	4.2.2 Хандлага 4-ийн хичээлийн жишиг төлөвлөгөө: Одоогийн хичээлүүдэд ДИБ-ыг агуулгыг тусгах	65
	4.2.3 Хандлага 5. Жишиг төлөвлөгөө: Хөтөлбөрийн бус үйл ажиллагаа	68
5. Дүгнэлт	5.1 Судалгааны гол үр дүнгүүд	73
	5.2. Бодлогын чиглэл ба зөвлөмж	75
	5.2.1. Байгууллагын засаглал ба стратегийн уялдаа	75
	5.2.2. Хөтөлбөрийн дизайн ба үе шаттай хэрэгжилт	75
	5.2.3. Багшийн хөгжил ба оюутны оролцоо	76
	5.2.4. Тогтвортой байдлыг хангах түншлэл ба харилцаа холбоо	76

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1	ЮНЕСКО-ийн Дэлхийн иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээ	05
Хүснэгт 2.1	Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх таван хандлага	14
Хүснэгт 2.2	APCEIU-ийн Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн төсөл	18
Хүснэгт 3.1	Соёл судлалын магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилго ба үр дүн	37
Хүснэгт 3.2	Академик түвшний суралцахуйн үр дүн ба Дэлхийн иргэний боловсролын чадамжууд	38
Хүснэгт 3.3	Хичээлийн дэлхийн иргэний боловсролын хүрээний агуулгыг үнэлэх рубрик	39
Хүснэгт 3.4	СУИС-ийн оюутны хөгжил ба дэлхийн оролцооны хөтөлбөрүүд	41
Хүснэгт 3.5	СУИС-ийн багш нарын хандлагын судалгаанд оролцсон байдал, сургуулиар	42
Хүснэгт 4.1	Зэргийн бус хөтөлбөрийн хичээлийн төлөвлөгөө	64
Хүснэгт 4.2	ДИБ-ын агуулгыг тусгасан хичээлийн жишиг төлөвлөгөө	66
Хүснэгт 4.3	Хөтөлбөрийн бус сургалт, арга хэмжээний жишиг төлөвлөгөө	68

Зургийн жагсаалт


[Зураг 3.1]	СУИС-ийн “Хүн төвт боловсролын загвар”	35
[Зураг 3.2]	СУИС-ийн “Оюутны бие даасан бүтээлээр дамжуулан Монголын эрхэм үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх нь” төслийн үр дүн	40
[Зураг 3.3]	ДИБ-ын сэдвүүдийн тусгагдсан байдал	45
[Зураг 3.4]	СУИС-ийн багш нарын ДИБ-ыг сургалтад тусгахтай холбоотой хандлага	46
[Зураг 3.5]	СУИС SWOT шинжилгээний гол үр дүн	48
[Зураг 4.1]	СУИС-т Дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх замын зураглал	55
[Зураг 4.2]	Магистрын хөтөлбөр боловсруулах үе шат	55
[Зураг 4.3]	Зэргийн бус хөтөлбөр боловсруулах үе шат	57
[Зураг 4.4]	Одоогийн сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөнд шинэ хичээл оруулах үе шат	59
[Зураг 4.5]	Одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах явц	61
[Зураг 4.6]	ДИБ-ыг хөтөлбөрийн бус сургалт, арга хэмжээгээр дамжуулан нэвтрүүлэх явц	62

1. Удиртгал

1.1 Үндэслэл

1.2 Судалгааны зорилго ба хүлээгдэж буй үр дүн

1.3 Судалгааны арга зүй



1. Удиртгал

Энэхүү бүлэгт судалгааны үндэслэл, зорилго болон арга зүйг танилцуулж, Соёл, урлагийн их сургууль (СУИС)-д Дэлхийн иргэний боловсрол (ДИБ)-ыг байгууллагын түвшинд төлөвшүүлэх үйл явцыг дэмжихэд төслийн судалгаа хэрхэн чиглэж буйг тайлбарлана. Бүлгийн эхэнд ДИБ-ын парадигм болон үзэл баримтлалын хүрээг танилцуулж, судалгааны зорилго болон хүлээгдэж буй үр дүнг тодорхойлохын зэрэгцээ Монголын дээд боловсролын байгууллагуудад ДИБ-ыг нэгтгэн хэрэгжүүлэх бодит стратеги, бодлогын зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ач холбогдол хэрхэн нийцэж буйг онцолж байна. Эцэст нь, судалгаанд ашигласан арга зүйг дэлгэрүүлэн танилцуулна. Үүнд ситуацийн шинжилгээ, кейс судалгаа, дугуй ширээний хэлэлцүүлэг зэрэг олон талын мэдээлэл, оролцогчдын санал бодлыг тусган авч, нотолгоонд суурилсан зөвлөмж боловсруулахад чиглэсэн арга хэрэгслүүд багтана.

1.1. Үндэслэл

1.1.1. Дэлхийн иргэний боловсролын (ДИБ) парадигм

21-р зуунд шилжин орсон үеэс ДИБ нь иргэний боловсролын нэг чухал үзэл баримтлал болж гарч ирсэн. ДИБ-ын Үзэл санаа нь дэлхийн иргэншлийн үзэл эсвэл гараг дэлхийн иргэн гэдэгтэй ижил утгыг илэрхийлдэг дэлхийн иргэншил гэх ойлголтод суурилсан. Дэлхийн иргэншил нь хууль ёсны статус биш боловч дэлхийн иргэн нь эв санааны нэгдэл, харилцааны ур чадвар, хүн төрөлхтний нийтлэг сайн сайхны төлөө үйлчлэх хандлага (APCEIU, 2014; Нан нар, 2015; UNESCO, 2014, 2015) зэргээр тодорхойлогддог. ЮНЕСКО-ийн 2014 оны “Дэлхийн иргэний боловсрол: Суралцагчдыг 21-р зууны сорилтод бэлтгэх нь” тайланд ДИБ-ын хамгийн иж бүрэн, олон улсад өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтуудын нэгийг дэвшүүлсэн байдаг. Уг баримтад дурдсанаар ДИБ нь суралцагчдыг илүү шударга, энх тайванч, хүлээцтэй, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой ертөнцийг цогцлооход шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс, хандлагад сургах зорилготой гэжээ (UNESCO, 2014). ДИБ нь боловсролын шинэ парадигм болон төлөвших, тэлэн хөгжих үйл явцдаа түүх, нийгэм болон байгууллагын олон хүчин зүйлсийн нөлөөллийг тусгасан.

Нэгдүгээрт, ДИБ-ын гол чиглэл болон суурь ойлголтууд нь 20-р зууны хоёрдугаар хагасаас эхлэн цугларсан эрдэм шинжилгээний олон бүтээлд тулгуурлан төлөвшсөн. ДИБ-ын үзэл санааны эх үүсвэрийг дэлхийн боловсрол, олон улсын ойлголцлын боловсрол (Pike & Selby, 1988, 1995; Merryfield, 1991, 1992 зэрэг) болон иргэний боловсролын тухай шүүмжлэлт хандлагатай судалгаанаас (жишээлбэл, Andreotti, 2006; Andreotti and Souza, 2012; Appiah, 2006; Heater, 1996, 1999; Nussbaum, 1996; Pike, 2008; Singer, 2002) харж болно. Эдгээр судалгаанууд нь даяаршил болон олон соёлт нийгмийн түргэссэн үйл явцын хариуд бий болж, нэг улсын хил хязгаарт хүлэгдсэн үндсэрхэг үзэл, эх оронч үзэлд суурилсан иргэний боловсролын загваруудын хязгаарлагдмал байдлыг шүүмжилсэн.

Тэд хамтын хөгжил, энхтайван, дэлхий нийтийн сорилтыг хамтаар даван туулах шинэ иргэншлийн ойлголт шаардлагатайг онцолсон.

Хоёрдугаарт, дэлхийн түвшний олон талт хямрал улам бүр ноцтой болж буй нь ДИБ-ыг байгууллагын хэмжээнд бататгахад чухал түлхэц болсон. Шинжлэх ухаан, технологийн хөгжил хурдтай хөгжиж буй хэдий ч дэлхийн хамтын нийгэмлэг ядуурал, өлсгөлөн (ялангуяа дэлхийн өмнөд хэсэгт), арьс өнгөөр ялгаварлах үзэл ба үзэн ядах соёл, дотоод мөргөлдөөн ба нийгмийн талцал, хэт барууны үзэл эргэн сэргэх, бүс нутгийн дайн болон иргэний мөргөлдөөн, уур амьсгалын өөрчлөлтийн хурдац, дүрвэгсдийн тоо нэмэгдэх, улс орнуудын эдийн засгийн тэгш бус байдал гүнзгийрэх зэрэг асуудлуудтай тулгарсаар байна. Эдгээр нь олон улсын хамтын ажиллагаа, хамтын хүчин чармайлтын зайлшгүй шаардлагатайг харуулж, ДИБ-ыг орчин үеийн сорилтуудыг даван туулах боломжит хувилбар хэмээн өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөхөд нөлөөлсөн.

Эцэст нь, олон улсын байгууллагууд, ялангуяа Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) болон ЮНЕСКО нь ДИБ-ыг дэлхийн түвшний боловсролын хөтөлбөрийн нэг хэсэг болгон төлөвшүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн. 2012 оны “Global Education First Initiative” зэрэг санаачилгууд нь ДИБ-ыг олон улсын бодлогын хэлэлцүүлэгт оруулах суурийг тавьсан. Эдгээр нь 2015 онд болсон Боловсролын Дэлхийн Форумын үеэр баталсан Инчоны тунхаглал, мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70-р чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ыг баталснаар баталснаар улам бүр бэхжсэн. Онцлон тэмдэглэхэд, бараг тавин жилийн дараа, 1974 оны “Олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа ба энхийн боловсрол, хүний эрх, эрх чөлөөний талаарх зөвлөмж”-ийг шинэчлэн баталж, “Энх тайван, хүний эрх, олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, үндсэн эрх, дэлхийн иргэншил ба тогтвортой хөгжлийн боловсролын тухай шинэчилсэн зөвлөмж” нь ДИБ-ын гол байр суурийг дахин баталсан (UNESCO, 2024). Энэхүү шинэчилсэн баримт бичиг нь энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжлийн боловсрол, өөрчлөлтөд суурилсан хүртээмжтэй суралцахуй зэрэг гол зарчмуудыг онцолж, өнөөдөр дэлхийн улс орнуудын боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулахад чухал баримт эх сурвалж болж байна.

1.1.2 Дэлхийн иргэний боловсролын үзэл баримтлалын хүрээ

1.1.2.1 ЮНЕСКО-ийн ДИБ-ын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээ

ЮНЕСКО-оос 2015 онд хэвлүүлсэн “Дэлхийн иргэний боловсрол: Сэдэв ба сургалтын зорилтууд” (UNESCO, 2015) гарын авлагадаа Дэлхийн иргэний боловсролын (ДИБ) иж бүрэн сургалтын хөтөлбөрийн хүрээг санал болгосон. Уг баримтад орсон 1-р хүснэгт нь ДИБ-ыг албан болон албан бус боловсролын орчинд нэгтгэн хэрэгжүүлэхэд чиг баримжаа болох үндсэн сэдэвчилсэн чиглэлүүд болон сургалтын зорилгуудыг харуулдаг. ДИБ-ын сургалтын хөтөлбөрийн энэхүү хүрээ нь гурван харилцан уялдаатай хүрээн дээр суурилсан. Үүнд: танин мэдэхүйн хүрээ (cognitive), нийгэм-сэтгэл зүйн хүрээ (socio-emotional), зан үйлийн хүрээ (behavioural) орно. Эдгээр нь зөвхөн ДИБ-ын боловсролын

зорилгын ерөнхий ангилал төдийгүй, сургалтын агуулга болон суралцагчийн чадамжийг төлөвлөх, зохион байгуулах оновчтой зарчим болж өгдөг. 1-р хүснэгтэд ЮНЕСКО-ийн гарын авлагад тусгагдсан тодорхойлолтууд, гол сургалтын үр дүн, суралцагчийн төлөв байдлыг дахин бүтэцлэн нэгтгэж үзүүлсэн болно. Хүснэгтэд үзүүлснээр, энэхүү хүрээ нь гурван үндсэн хүрээг тодорхой ялган харуулж, улмаар хүрээ тус бүрийн сургалтын зорилт, гол сэдэв, суралцагчаас хүлээгдэж буй тодорхой үр дүнг цааш нь нарийвчлан тодорхойлсон байна.

Хүснэгт 1 ЮНЕСКО-ийн Дэлхийн иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн хүрээ

Ангилал	Танин мэдэхүйн хүрээ	Нийгэм-сэтгэл зүйн хүрээ	Үйл хандлага-зан үйлийн хүрээ
Тодорхойлолт	Дэлхий болон түүний нарийн төвөгтэй байдлыг илүү сайн ойлгоход туслах мэдлэг, сэтгэн бодох чадвар	Суралцагчдыг сэтгэл зүй, нийгэм-сэтгэл зүйн болон бие бялдрын хувьд хөгжүүлэх, бусадтай харилцан хүндэтгэлтэй, энх тайвнаар хамтран амьдрахад туслах үнэт зүйл, хандлага, нийгмийн ур чадвар	Үйлдэл, гүйцэтгэл, практик хэрэглээ болон идэвхтэй оролцоо
Зорилго	Орон нутгийн, үндэсний, бүс нутгийн болон дэлхийн түвшний асуудлууд, улс орнууд болон ард түмнүүдийн хоорондын уялдаа холбоог ойлгох мэдлэг, шүүмжлэлт сэтгэлгээний ур чадвар эзэмших	Ялгаатай ба олон талт байдлыг хүндэтгэх, эв санааны нэгдэл, энэрэнгүй сэтгэл, үнэт зүйл ба хариуцлагаа хуваалцах замаар хүнлэг чанарыг төлөвшүүлэх	Энх тайван, тогтвортой дэлхийн төлөө орон нутаг, улс орон болон дэлхийн түвшинд хариуцлагатай, үр нөлөөтэй үйлдэл хийх
Суралцагчийн гол шинж	Өргөн мэдлэгтэй, мэдээллийг шүүн тунгааж ойлгох чадвартай	Нийгмийн харилцаанд идэвхтэй оролцдог, олон талт байдлыг хүндэтгэдэг	Ёс зүйн хариуцлагатай, санаачилгатай
Гол суралцахуйн үр дүн	- Суралцагч орон нутаг, улс орон ба дэлхийн асуудлуудыг танин мэдэж, дэлхийн хүн ард, улс орнуудын харилцан уялдаа, хамааралтай байдлыг ойлгосон байна. - Суралцагчид шүүмжлэлт сэтгэлгээ болон дүн шинжилгээ хийх чадвараа хөгжүүлнэ.	- Суралцагч хүний эрхийг дээдэлсэн нэгэн цулд нэгдэх мэдрэмжтэй болж, хамтын үнэт зүйлс ба хариуцлагатай хандлагыг төлөвшинө. - Суралцагч энэрэнгүй сэтгэл, эв санааны нэгдэл, ялгаатай болон олон талт байдлыг хүндэтгэх хандлагаа хөгжүүлнэ.	- Суралцагч энх тайван, тогтвортой дэлхийн төлөө орон нутаг, улс орон болон дэлхийн түвшинд хариуцлагатай, үр нөлөөтэй үйлдэл хийнэ - Суралцагч эерэг өөрчлөлтөд чиглэсэн алхам хийх хүсэл зоригтой болно.

(Тэмдэглэл: Хүснэгтийн агуулгыг ЮНЕСКО [2015]-ийн баримт бичигт тулгуурлан боловсруулав.)

Танин мэдэхүйн хүрээний хувьд сургалтын хөтөлбөрт суралцагчдын дэлхийн харилцан хамаарлын талаарх шүүмжлэлтэй ойлголтыг төлөвшүүлэх нэгж хичээлийн сэдвүүдийг тусгах шаардлагатай. Үүнд дэлхийн тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн, дижитал шилжилт, олон улсын засаглал зэрэг сэдвүүд багтана. Эдгээр сэдвүүд нь оюутнуудад дэлхийн асуудлын суурь шалтгаан, түүнийг дагасан системийн бүтэц, шалтгаан, уялдаа холбоог шинжлэх боломжийг олгодог. Нийгэм-сэтгэл зүйн хүрээ нь соёл хоорондын харилцан яриаг дэмжих, ёс зүйн эргэцүүлэл хийх, энэрэх сэтгэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаагаар илэрхийлэгдэх ёстой. Сургалтын хөтөлбөрт нийгмийн үйлчилгээнд суурилсан суралцах арга (service learning), олон соёлын багийн төсөл, хамт олонд суурилсан оролцооны үйл ажиллагаа зэрэг туршлагын элементүүдийг оруулж болно. Ингэснээр суралцагчид хүн төрөлхтний хамтын нийгэмлэгийн нэг хэсэг гэдгээ мэдрэх, соёл болон үндэстний хил хязгаарыг давсан эв нэгдэл, эв санааны нэгдлийг төлөвшүүлэх боломжтой. Зан үйлийн хүрээний хувьд суралцагчид мэдлэг, үнэт зүйлээ бодит үйлдэл болгон хөрвүүлэхийг дэмжих хэрэгтэй. Үүнийг дэлхийн асуудлуудтай холбоотой төсөлд суурилсан сургалт, асуудал шийдвэрлэх даалгавар, энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжлийг дэмжих оюутны удирдсан санаачилгууд зэрэг үйлдэлд чиглэсэн сургалтын аргаар хэрэгжүүлж болно.

1.1.2.2 ЮНЕСКО-ийн ДИБ-ын сургалтын зарчмууд

ДИБ-д тулгуурласан энэхүү арга зүй нь дараах онцлог шинжүүдээр тодорхойлогдоно. Энэ арга зүй нь боловсролыг зөвхөн мэдлэг олгох үйл ажиллагаа бус, харин суралцагчдыг ёс зүйтэй хариуцлагатай, шүүмжлэлтэй сэтгэх чадвартай, идэвхтэй оролцогч дэлхийн иргэн болгон төлөвшүүлэхийг зорьсон эрхэмж олгох (empowerment) үйл явц гэж үздэг бөгөөд ДИБ-ын өргөн хүрээний үзэл баримтлалтай нийцдэг. Үүнд:

- *Суралцагч төвтэй* байж, суралцах үйл явцад суралцагчийн идэвх, оролцоог дэмждэг.
- Суралцагчдыг өөрийгөө, гэр бүл, хамт олон, улс, дэлхий гэсэн түвшний уялдааны үүднээс нийгмийн асуудлыг авч үзэх, шийдвэрлэхэд уриалдаг.
- Салбар хоорондын болон уялдаа холбоотой (interdisciplinary, cross-curricular) хандлагыг ашиглаж, шинжлэх ухааны чиглэл хоорондын ханыг давж, олон төрлийн мэдлэгийг нэгтгэн ашигладаг.
- *Харилцан яриа, харилцан хүндлэл, олон талт байдлыг эрхэмлэсэн хүртээмжтэй суралцах орчныг бүрдүүлдэг.*
- Нийгмийн оролцоонд тулгуурласан *бүхэллэг, цогц сургуулийн хандлагыг чухалчилдаг.*
- Анги доторх сургалтыг иргэний оролцоо болон бодит, утга учиртай *үйлдэл болгон хөрвүүлэхийг дэмжиж, энэ нь сургуулийн дотор болон гадна орчинд хэрэгжинэ.*

Сургалтын хөтөлбөр боловсруулахдаа сургалтын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээний стратегийг босоо (түвшин хоорондын) болон хэвтээ (салбар хоорондын) чиглэлд

уялдуулах нь чухал. ДИБ нь нэг хичээл эсвэл нэг сургалтын нэгжид хязгаарлагдах бус, бүх хөтөлбөрийн хүрээнд салбар хоорондын хэлбэрээр нэвт шингэж, хүртээмж, тогтвортой хөгжил, ёс зүйн хариуцлагыг боловсролын үндсэн үнэт зүйлс болгон баталгаажуулах байгууллагын бодлогоор дэмжигдэх шаардлагатай.

Дүгнэж хэлбэл, ЮНЕСКО-ийн энэхүү хүрээ нь ДИБ-ын хөтөлбөрийг орон нутгийн нөхцөлд суурилсан атлаа дэлхийн хэмжээнд ач холбогдолтой байдлаар боловсруулах суурь лавлагаа болж өгсөн. Монголын ахисан түвшний боловсролын байгууллагын хувьд энэ нь дэлхийд өрсөлдөх чадвартай, нийгмийн хариуцлагатай, үйлдэлд чиглэсэн иргэдийг төлөвшүүлэх стратегийн замын зураглал болдог. Иймд Монголын их дээд сургуулиудад ДИБ-ын сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц нь өөрчлөлтөд суурилсан сургалтын арга зүйн үндсэн зарчмуудыг логик уялдаатай, нөхцөл байдалд нийцсэн боловсролын шийдэл болгон хөрвүүлэхэд чиглэх шаардлагатай. Үүнд сургалтын агуулга, заах арга барил, үнэлгээний аргуудыг ДИБ-ын гурван үндсэн хүрээтэй уялдуулахын зэрэгцээ суралцагчдыг шүүмжлэлтэй сэтгэдэг, энэрэнгүй, үйлдэлд чиглэсэн дэлхийн иргэн болгон хөгжүүлэх цогц зорилгод нийцүүлэх шаардлагатай.

1.2 Судалгааны зорилго ба хүлээгдэж буй үр дүн

1.2.1 Зорилго

Энэхүү судалгааны зорилго гурван чиглэлтэй. Үүнд:

- СУИС-д ахисан түвшний ДИБ-ын хичээл болон сургалтын хөтөлбөр боловсруулах;
- Монголын дээд боловсролын байгууллагуудад ахисан түвшний ДИБ-ын хөтөлбөрийн хүрээ боловсруулахад санал болгох бодлогын зөвлөмж, дүгнэлтийг гаргах;
- Монголын дээд боловсролын байгууллагад ДИБ-ыг түгээн дэлгэрүүлэх, бодлогын түвшинд нутагшуулах үндсийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах.

1.2.2 Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү судалгаанаас дараах үр дүнг хүлээж байна:

- **Монголын дээд боловсролын түвшинд ДИБ-ын үндэсний бодлогын хүрээг тогтоох:** Боловсролын яам болон холбогдох агентлагууд ДИБ-ыг ахисан түвшний сургалтын стратегийн тэргүүлэх чиглэл гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөх шаардлагатай юм. Энэхүү бодлогын хүрээ нь Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого болон Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ), мөн *“Энх тайван, хүний эрх, олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, үндсэн эрх чөлөө, дэлхийн иргэншил болон тогтвортой хөгжилд зориулсан боловсролын зөвлөмж”* (ЮНЕСКО, 2024) зэрэг олон улсын баримт бичгүүдтэй уялдах боломжтой.

- **ДИБ-ыг нэвтрүүлэх олон загварыг турших байгууллагын оролдлогыг дэмжих:** Их сургуулиудыг урамшуулал, тэтгэлэг, бодлогын чиглэлээр дэмжсэн уян хатан орчин бүрдүүлснээр шинэ хөтөлбөр бий болгохоос эхлээд сургалтын агуулгад шингээх хүртэл ДИБ-ын интеграцийн олон төрлийн загварыг турших боломж бүрдэнэ. Ийм орчин нь их сургуулиуд өөрийн хэрэгцээ, нөөц бололцоо, оюутны хэрэгцээнд тохирсон загварыг сонгон хэрэгжүүлэх боломж олгоно.
- **ДИБ-ын үндэсний сургалтын удирдамж ба багшийн хөгжлийн хөтөлбөрүүдийг төлөвшүүлэх:** ЮНЕСКО-ийн ДИБ-ын гурван хүрээ (танин мэдэхүйн, нийгэм-сэтгэлзүйн, зан үйлийн) болон өөрчлөлтөд чиглэсэн сургалтын арга зүйд (transformative pedagogy) тулгуурласан сургалтын удирдамжийг их дээд сургуулиудад санал болгох. Түүнчлэн багшийн чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагаа, ялангуяа салбар хоорондын заах арга, дэлхийн иргэншлийн чадамж, шүүмжлэлт сэтгэлгээний арга зүй нь ДИБ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болно.
- **Олон улсын байгууллага, их сургуулиудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх:** APCEIU, ДИБ-ын Ази-Номхон далайн сүлжээ, ЮНЕСКО-ийн тэнхимтэй их сургуулиуд зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах нь монголын их сургуулиудад техникийн дэмжлэг, сургалтын материал, багш оюутны солилцооны өргөн боломжуудыг олгоно.

1.3 Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны арга зүй нь нөхцөл байдлын шинжилгээ, кейс судалгаа, дугуй ширээний хэлэлцүүлэг гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ.

1.3.1 Нөхцөл байдлын шинжилгээ

Байгууллагын бодлогын баримт бичиг болон сургалтын хөтөлбөрүүдийг шинжилж, ДИБ-ын зарчмууд их сургуулийн бодлого, хөтөлбөрийн бүтэц, суралцахуйн үр дүнд хэрхэн туссан байгааг үнэлсэн. Шинжилгээний нарийвчлалыг нэмэгдүүлэх зорилгоор судалгааны баг “ДИБ-ын хүрээний үнэлгээний рубрик” боловсруулсан бөгөөд уг рубрик нь сонгогдсон ахисан түвшний хичээлүүдийн танин мэдэхүйн, нийгэм-сэтгэлзүйн болон зан үйлийн хэмжээсүүдийг харьцуулан зураглах боломж олгосон. Энэ хэрэгсэл нь ДИБ-ын оршин буй элементүүдийг илрүүлэхийн зэрэгцээ цаашид сайжруулах шаардлагатай талбаруудыг тодорхойлох мета-хүрээ болгон ашиглагдсан.

Хоёрдугаар хэсэгт багш нарын багш нарын ДИБ-ыг хүлээн зөвшөөрөх байдал, ойлголт, хандлага, хэрэгжилтийн бэлэн байдлыг судалгаа, төслийн хэлэлцүүлгийн үр дүнгийн үндсэн дээр шинжилсэн бөгөөд ДИБ-ыг сургалт, судалгаанд хэрхэн хүлээн зөвшөөрч, тайлбарлаж, хэрэгжүүлж буйг илрүүлэв. Эдгээр нэгдсэн дүн шинжилгээг SWOT шинжилгээнд тулгуурлан хийв.

1.3.2 Кэйс судалгаа

Чиглүүлэх зарчмуудаас бусад тохиолдолд, дээд боловсролын түвшинд ДИБ-ын “тусгах загвар”-ын тодорхой жишээ бараг байдаггүй. Иймээс энэхүү судалгааны зорилго нь гол төлөв БНСУ-ын тохиолдлуудаар дамжуулан “тусгах загвар”-ын ойлголтыг тодруулах тухай байв. Судалгааны багийн шинжилсэн тохиолдлууд нь БНСУ-ын их дээд сургуулиуд ДИБ-ыг хэрхэн янз бүрийн түвшний хандлагаар сургалтдаа нэгтгэж буйг харуулна. Урьдчилсан дүн шинжилгээнд тулгуурлан судалгааны баг ДИБ-ын хичээлийг хөгжүүлэх таван хандлагыг санал болгохоор төлөвлөсөн бөгөөд эдгээрийг 2-р бүлэгт дэлгэрэнгүй танилцуулах болно.

1.3.3 Дугуй ширээний хэлэлцүүлэг

Судалгааны эцсийн хэсэг нь дугуй ширээний хэлэлцүүлэг байсан бөгөөд өмнөх хоёр хэсгийн үр дүнг хуваалцахаас гадна СУИС-д тохирсон ДИБ-ын “хөтөлбөрт тусгах загвар”-т чиглэсэн зохистой хандлагыг хэлэлцэх зорилготой байв.

Судалгааны эцсийн шатанд 2025 оны 7 дугаар сарын 10–11-нд СУИС-ийн төв байранд зохион байгуулагдсан ба монгол ба солонгос судлаачдын баг болон APCEIU-ийн мэргэжилтнүүд танхимаар, гол илтгэлүүдийн хэсэгт СУИС-ийн багш, судлаачид цахимаар оролцсон. Эхний түлхүүр илтгэлийг БНСУ-ын Сүншин Эмэгтэйчүүдийн Их Сургуулийн Нийгмийн судлалын боловсролын тэнхимийн профессор Жу Тэ Хүн “ДИБ-д зориулсан өөрчлөлтөд чиглүүлэх сургалтын арга зүй” сэдвээр тавьсан. Тэрээр өөрчлөлтөд чиглүүлэх сургалтын арга зүй болон соёл, урлагийн боловсрол нь утгаараа харилцан биесээ дэмжих шинжтэй бөгөөд СУИС-ийн эрхэм зорилго, сургалтын хөтөлбөрүүд нь ДИБ-ыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх онцгой боломжтойг онцолсон. Соёл, урлаг нь дэлхийн иргэншлийг илэрхийлэх хүчирхэг хэрэгсэл бөгөөд ДИБ-ыг урлаг, соёлын хөтөлбөрүүдэд нэгтгэснээр оюутнуудын шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлч байдал, нийгмийн өөрчлөлтөд хувь нэмрээ оруулах чадварыг дээшлүүлэх боломжтой. СУИС-ийн ДИБ-ын хичээл хөгжүүлэх санаачилга нь оюутнуудын уран бүтээл, соёлын мэргэжлийн онцлогт тулгуурласан дэлхийн иргэний үнэт зүйлсийг ойлгох, хэрэгжүүлэх чадамжийг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ их сургуулийг ТХЗ-ийн 4.7 зорилт болон ЮНЕСКО-ийн боловсролын үзэл санааг хэрэгжүүлэгч байгууллага гэдгээр олон нийтэд илүү танигдуулах ач холбогдолтой гэж тэмдэглэв.

Дараагийн гол илтгэлийг БНСУ-ын Кёнхи Их Сургуулийн Глобал засаглалын тэнхимийн туслах профессор И Жи Хян “Дээд боловсролд дэлхийн иргэний боловсролыг нэгтгэх нь: Солонгосын их сургуулиудын туршлага” сэдвээр тавьсан. Тэрээр Солонгосын их сургуулиудад ДИБ-ыг бакалавр болон магистрын түвшинд хэрхэн нэвтрүүлж буй бодит жишээнүүдийг танилцуулж, ДИБ-ыг төсөлд суурилсан сургалт, дадлагын ажил, бүтээлч заах аргуудаар дамжуулан олон салбарт холбох боломжтойг харуулсан.


Үүний дараа СУИС-ийн дэд профессор Д.Одсүрэн болон Б.Мандухай нар монголын дээд боловсролын байгууллагуудын нөхцөл байдал, чиг хандлага, тулгамдсан асуудлуудыг

танилцуулж, мөн СУИС-ийн боловсруулж буй стратеги төлөвлөгөөний SWOT шинжилгээг танилцуулав. Тэдгээр илтгэлдээ их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хэрэгжүүлж буй санаачилгууд, хичээлийн хөтөлбөрүүдийн ДИБ-тай холбогдох байдал, ач холбогдлыг авч үзсэн бөгөөд СУИС-ийн сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх тодорхой стратегийн төслийн ноорог хувилбарыг хуваалцсан юм.



2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

- 2.1 Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах таван хандлага
- 2.2 Монголын ахисан түвшний сургалтын хөтөлбөрт таван хандлагыг уялдуулах нь
- 2.3 БНСУ-ын их, дээд сургуулиудын ДИБ-ын жишээнүүд



2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

Энэ бүлэгт их, дээд сургуулиуд ДИБ-ын сэдвийг сургалтын хөтөлбөртөө хэрхэн нэгтгэж буйг харуулсан үндсэн загварууд болон хандлагуудыг тайлбарлана. Дүгнэж хэлбэл, судалгааны баг нь солонгосын их дээд сургуулиудад ДИБ-ыг нэвтрүүлсэн туршлагаудаас сонгон, дээд боловсролын түвшинд ДИБ-ын зарчмаар сургалтын хөтөлбөр хөгжүүлэх таван загвар/хандлагыг санал болгож байна. Эдгээр загвар, хандлагыг монголын дээд боловсролын байгууллагын онцлог нөхцөл, хэрэгцээ, боломжид нийцүүлэн хувирган хэрэглэх боломжтой юм.

2.1 Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах таван хандлага

2.1.1 Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах таван хандлага

Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг тусгах үйл явцыг таван ерөнхий хандлага болгон ангилж болох бөгөөд сургалтын агуулгын цар хүрээ, байгууллагаас шаардагдах удирдлага зохион байгуулалтын оролцоогоороо ялгаатай. (Хүснэгт 2.1):

- **Хандлага 1:** ДИБ-д төвлөрсөн, шинжлэх ухааны салбаруудын огтлолцолд суурилсан бие даасан хөтөлбөрийг зэргийн түвшинд бий болгох
- **Хандлага 2:** Сургуулийн дотоод хамтын ажиллагаанд тулгуурласан зэргийн бус (micro-degree) хөтөлбөр хэрэгжүүлэх
- **Хандлага 3:** Тэнхимүүдийн хүрээнд ДИБ-ын хичээлийг шинээр хөгжүүлэх
- **Хандлага 4:** Одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусган шинэчлэх
- **Хандлага 5:** Их сургуулийн хэмжээнд ДИБ-ын хичээлээс гадуурх лекц, семинар, сургалтыг зохион байгуулах

Эдгээр хандлагууд тус бүрдээ давуу тал, сорилттой бөгөөд тухайн байгууллага өөрийн сургалтын тэргүүлэх чиглэл, нөөц бололцоо, байгууллагын соёлд нийцүүлэн хослуулан сонгож хэрэгжүүлэх боломжтой. Хосолсон стратеги нь албан болон албан бус сургалтын хэлбэрүүдийг хослуулан, өөрчлөлтийг түчээлэх дэлхийн иргэнийг төлөвшүүлэхэд онцгой үр дүнтэй байж болох юм.

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

Хүснэгт 2.1 Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх таван хандлага

Загвар / Хандлага	Тайлбар	Нэгдлийн түвшин	
1. ДИБ-д төвлөрсөн, шинжлэх ухааны салбаруудын огтлолцолд суурилсан бие даасан хөтөлбөрийг зэргийн түвшинд бий болгох	Дэлхийн иргэншил, тогтвортой хөгжил, олон улс судлал зэрэг олон салбар судлалын огтлолцуулсан ДИБ-ын зарчмыг баримтлан бие даасан ахисан түвшний хөтөлбөрийг боловсруулах, санал болгох	Хамгийн их	Их ↑ ↓ Бага
2. Сургуулийн дотоод хамтын ажиллагаанд тулгуурласан зэргийн бус (micro-degree) хөтөлбөр хэрэгжүүлэх	Суралцагчид дэлхийн иргэншилтэй холбоотой чадамжид мэргэших боломж олгох хичээлүүдийг холбох замаар ДИБ-д тулгуурласан зэргийн бус, сертификатын хөтөлбөрийг тэнхим хоорондын хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх	Дундажаас их	
3. Тэнхимүүдийн хүрээнд ДИБ-ын хичээлийг шинээр хөгжүүлэх	Тэнхимүүд бие даан энх тайван, хүний эрх, ёс зүй зэрэг ДИБ-ын үндсэн сэдвийг тусгасан шинэ хичээл боловсруулах, санал болгох	Дундаж	
4. Одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусган шинэчлэх	Одоо байгаа хичээлүүдийн агуулгад ДИБ-ын агуулгыг бүрэн эсвэл хэсэгчлэн тусгах замаар оюутнуудад дэлхийн иргэншлийн асуудлыг өргөн хүрээнд танилцуулах	Дундажаас бага	
5. Их сургуулийн хэмжээнд ДИБ-ын хичээлээс гадуурх лекц, семинар, сургалтыг зохион байгуулах	ДИБ-ын үнэт зүйлсийг бодит туршлагаар суралцах боломж олгох сургалт-семинар, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зэрэг хичээлээс гадуурх хөтөлбөр	Бага	

2.2 Монголын ахисан түвшний сургалтын хөтөлбөрт таван хандлагыг тусгах нь

Дээрх таван хандлагыг ахисан түвшний сургалтын хөтөлбөрт уялдуулахдаа Монгол Улсын дээд боловсролын байгууллагууд өөрсдийн онцлог нөхцөл, хэрэгцээ, боломжид нийцүүлэх нь зүйтэй. СУИС-ийн хувьд ДИБ-ын үзэл баримтлалыг авч үзэхдээ урлаг, соёл, өв уламжлалд суурилсан сургалтын хөтөлбөрийн онцлог, давуу талаа харгалзах нь чухал. Дээр дурдсан таван хандлагыг СУИС-д дараах байдлаар тохируулан хэрэгжүүлж болно. Үүнд:

- 1. ДИБ-д төвлөрсөн, шинжлэх ухааны салбаруудын огтлолцолд суурилсан бие даасан хөтөлбөрийг зэргийн түвшинд бий болгох.** СУИС нь “Дэлхийн соёл урлаг ба Иргэншил” гэх зэрэг ДИБ-т төвлөрсөн бие даасан, салбар дундын ахисан түвшний хөтөлбөр шинээр нээж болно. Энэхүү хөтөлбөрт глобал ёс зүй, соёлын дипломат ажиллагаа, хүний эрх, тогтвортой хөгжлийн онолыг уламжлалт болон орчин үеийн урлагийн хэлбэрүүдэд тулгуурлан дадлагажуулах сургалттай уялдуулна. Ийм хөтөлбөр нь оюутнуудад урлагийн илэрхийлэл нь соёл хоорондын ойлголцол, дэлхийн эв нэгдэл, нийгмийн өөрчлөлтөд хэрхэн хувь нэмэр оруулж болохыг судлах боломж олгоно. Энэ нь ирээдүйн урлагийн багш, мэргэжилтэн, бодлого боловсруулагчдыг бэлтгэхэд онцгой ач холбогдолтой.
- 2. Сургуулийн дотоод хамтын ажиллагаанд тулгуурласан зэргийн бус (micro-degree) хөтөлбөр хэрэгжүүлэх.** ДИБ-ыг тэнхим хоорондын хамтын ажиллагаанд үндэслэн зэргийн бус эсвэл сертификатын сургалт хэлбэрээр нэвтрүүлэх боломжтой. Жишээлбэл, “Тогтвортой ирээдүйд хөтлөх урлаг” гэх зэргээр нэрлэсэн дүрслэх урлаг, тайзны урлаг, медиа урлагийн боловсролын чиглэлийн холбогдох хичээлүүдийг нэгтгэн сертификатын хөтөлбөр боловсруулж болно. Энэ төрлийн хөтөлбөр нь оюутнуудад НҮБ-ын ТХЗ, энх тайван ба зөрчил шийдвэрлэх, соёлын олон янз байдал зэрэг дэлхийн иргэний сэдвийн хүрээнд мэдлэг, чадвараа гүнзгийрүүлэх боломжийг олгоно. Бие даасан ахисан түвшний хөтөлбөр нээхэд бэлэн бус байгууллагуудад энэ нь тохиромжтой хувилбар байх бөгөөд ажил эрхэлж буй багш нар, ТББ-ын мэргэжилтнүүд болон хоёр дахь чиглэл судлахыг хүссэн ахисан түвшний оюутнуудад зориулж болно.
- 3. Тэнхимүүдийн хүрээнд ДИБ-ын хичээлийг шинээр хөгжүүлэх.** Тэнхим тус бүр өөрийн мэргэжлийн чиглэлтэй уялдуулан ДИБ-ын сэдвийг хамарсан шинээр заавал үзэх эсвэл сонгох хичээл боловсруулж болно. Жишээлбэл, “Энхийг бүтээх урлаг: Зөрчил шийдвэрлэх урлагт суурилсан арга замууд”, “Соёлын өгүүлэмж ба хүний эрх”, эсвэл “Уламжлалт ба орчин үеийн урлаг дахь дэлхийн ёс зүй” гэх мэт хичээлүүдийг төлөвлөн оюутнуудад урлаг, соёлын салбартай шууд холбогдсон хэлбэрээр ДИБ-ын агуулгыг судлах, шүүмжлэлтэй эргэцүүлэх, практикт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж өгч болно.

- 4. Одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусган шинэчлэх.** Шинэ хичээл бий болгохоос илүүтэйгээр байгаа хичээлүүдийнхээ агуулгыг шинэчилж, ДИБ-ын сэдвийг тусгах нь илүү бодитой арга юм. Жишээлбэл, угсаатны хөгжмийн хичээлд уугуул мэдлэг ба байгаль хамгааллын сэдвийг; урлагийн түүхийн хичээлд зөрчилдөөнт нөхцөлд соёлын өвийг хамгаалах асуудлыг; театр ба тайзны урлагийн хичээлд шилжилт хөдөлгөөн, үндэсний ухамсар (identity)-ын асуудлыг багтааж болно. Энэ нь сургалтын зохион байгуулалтад том өөрчлөлт оруулахгүйгээр оюутнуудад ДИБ-ын сэдвүүдийг илүү өргөн хүрээнд хүрэх боломж бүрдүүлнэ. Үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд багш нарт зориулсан сургалтын хөтөлбөр, семинар зохион байгуулах шаардлагатай.
- 5. Их сургуулийн хэмжээнд ДИБ-ын хичээлээс гадуурх лекц, семинар, сургалтыг зохион байгуулах.** Ахисан түвшний бүх оюутнуудад чиглэсэн кредит тооцогдохгүй ДИБ-ын лекц, семинар, эсвэл оюутны удирдсан нийгмийн оролцооны төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Жишээлбэл, “Дэлхийн шударга ёсны төлөө урлагийн долоо хоног”, урлагт суурилсан хамтын ажиллагааны төсөл, эсвэл соёл хоорондын тайзны урлагийн сургалт зэрэг нь оюутнуудад энэрэх сэтгэл, хүртээмжтэй оролцоо, дэлхийн иргэний хариуцлагыг төлөвшүүлэх сургалтын орон зай бий болгоно. Эдгээр санаачилгыг орон нутгийн ТББ, олон улсын байгууллага, эсвэл сонирхлын бүлгүүдтэй хамтран хэрэгжүүлж болно.

Эдгээр хандлагуудыг уян хатнаар хослуулан хэрэгжүүлснээр монголын дээд боловсролын байгууллагуудад ДИБ-ыг албан болон албан бус сургалтад үр дүнтэйгээр тусгаж чадна. Эдгээр хандлагуудаас сонгохдоо тухайн сургуулийн бэлэн байдал, багш нарын чадавх, оюутны хэрэгцээ, үндэсний боловсролын тэргүүлэх чиглэл (ялангуяа ТХЗ, хүртээмжтэй боловсрол, соёлын олон янз байдалтай холбоорой конвенцүүдэд Монгол Улсын хүлээсэн үүрэг, амлалтууд)-тэй уялдуулах шаардлагатай. СУИС эдгээр хандлагуудыг хослуулсан стратегиар урлагийн илэрхийллийн хүч болон соёлын оролцооны өөрчлөлтөд чиглүүлэх нөөц бололцоонд тулгуурласан ДИБ-ын өвөрмөц загварыг бүрэлдүүлэх боломжтой.

2.3 БНСУ-ын их, дээд сургуулиудын ДИБ-ын жишээнүүд

ЮНЕСКО (2022)-оос дээд боловсролын салбарт ДИБ нь онцгой ач холбогдолтой болохыг дурдсан байдаг. Учир нь их, дээд сургуулиуд бол залуусыг идэвхтэй дэлхийн иргэн болон төлөвших чухал орчин юм. Оюутан нас нь хувь хүний, нийгмийн болон мэргэжлийн чиг баримжаа тогтох үе тул шүүмжлэлтэй сэтгэх, энэрэх сэтгэл, асуудал шийдвэрлэх зэрэг үндсэн чадамжийг хөгжүүлэхэд хамгийн тохиромжтой үе гэж үздэг. Дээд боловсролын байгууллагууд нь соёл хоорондын солилцоо, хамтын ажиллагаа, иргэний оролцоог дэмждэг олон талт, хүртээмжтэй орчныг бүрдүүлснээр оюутнуудад тогтвортой хөгжил, энх тайван, хүний эрх зэрэг дэлхийн сорилтуудыг бодитойгоор ойлгож, шийдвэрлэх боломж олгодог. Үүнээс гадна их, дээд сургуулиуд судалгаа, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаагаар дамжуулан анги танхимын хүрээнээс давж, ДИБ-ын нөлөөллийг тэлдэг бөгөөд насан туршийн суралцахуйн болон нийгмийн өөрчлөлтийн хөшүүрэг болж чаддаг. ДИБ-ыг сургалтын хөтөлбөр болон сургуулийн орчинд ойртуулах нь оюутнуудыг дэлхийн үнэт зүйлсийг өөрийн амьдрал, ажил мэргэжилдээ хэрэгжүүлэх чадвартай болгохын зэрэгцээ орон нутгийн бүлгүүдэд дэлхий нийтлэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох урам зориг өгдөг.

Дээд боловсролын салбарт дэлхийн хэмжээнд өрнөж буй энэхүү чиг хандлагатай уялдан БНСУ-ын Боловсролын яам ДИБ-ыг их, дээд сургуулиудад дэмжих хэд хэдэн санаачилгыг хэрэгжүүлж байна. Тэдгээрийн хоёр гол санаачилгыг дор танилцуулна.

2.3.1 Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн хөтөлбөр

2016 онд APCEIU нь БНСУ-ын Боловсролын яамны дэмжлэгтэйгээр “Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төсөл нь ДИБ-ыг дээд боловсролд нэвтрүүлэх, оюутнуудын дэлхийн иргэний боловсролын талаарх ойлголт, судалгааны оролцоог бэхжүүлэх зорилготой байв.

Хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан хичээлүүд нь олон салбарыг хамарч, ДИБ-ыг судалгааны чиглэл болгон хөгжүүлэх өргөн боломжтойг харуулсан. 2016–2021 онд уг төсөл нь бакалаврын түвшний хичээлүүдийг онцолж байсан бол 2022 оноос ахисан түвшний сургалтыг хамарч өргөжсөн. 2024 он гэхэд нийт 68 бакалаврын болон 14 ахисан түвшний хичээл хэрэгжсэн байна (Хүснэгт 2.2).

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

Хүснэгт 2.2 APCEIU-ийн Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн төсөл

Он	Бакалаврын хөтөлбөр	Ахисан түвшин хөтөлбөр
2016	9	-
2017	6	-
2018	8	-
2019	10	-
2020	9	-
2021	6	-
2022	5	5 • Хүн экологи судлалын ахисан түвшний сургууль • Ёс зүйн боловсролын хөтөлбөр • Ёс зүйн боловсролын хөтөлбөр • Сургуулийн өмнөх боловсрол • Хөгжмийн боловсролын хөтөлбөр
2023	7	4 • Хүн экологи судлалын ахисан түвшний сургууль • Эмэгтэйчүүд судлалын тэнхим • Олон улсын судлалын судлалын ахисан түвшний сургууль • Дэлхийн боловсролын хөтөлбөр
2024	8	5 • Сургуулийн өмнөх боловсрол • Боловсрол судлалын тэнхим • Дэлхийн боловсролын хөтөлбөр • Олон улс судлалын ахисан түвшний сургууль • Дэлхийн соёл ба контентын тэнхим

Эх сурвалж: APCEIU-ийн Дээд боловсролын байгууллагуудад зориулсан ДИБ-ын хичээл хөгжүүлэх дэмжлэгийн төсөл (2016-2024)-ийн эцсийн тайлангууд

Энэхүү төслийн хүрээнд оролцогч их, дээд сургуулиуд нэг улирал (6 сар)-ын хугацаанд 8 сая вон хүртэлх дүнтэй санхүүгийн дэмжлэг авсан. Энэхүү санхүүжилт нь долоо хоногт 3 цагийн хичээл (3 кредит)-ийн хүрээнд хэрэгжих сургалтад шаардлагатай зардлууд болох оюутны судалгаа, бүтээлч үйл ажиллагаа, уулзалт, сургалтын материал худалдан авах, гаргах зэрэгт зориулдаг. Хичээл нь дараах шалгуурыг хангах ёстой:

- » ДИБ-ын үндсэн ойлголт, агуулга, арга зүй, мөн танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл зүйн, зан үйлийн хүрээн дэх онцлогийг хамарсан суурь мэдлэг олгох;
- » Энх тайван, глобалчлал, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцол, хүний эрх зэрэг ДИБ-ын сэдвүүдийг багтаах;
- » Оюутнуудын ДИБ-ын талаарх мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлж, “хариуцлагатай дэлхийн иргэн” төлөвшүүлэхэд чиглэх.

Ахисан түвшний хичээлүүд нь оюутнуудыг эрдэм шинжилгээний хуралд оролцох, эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэл хэвлүүлэхийг дэмждэг. Хичээлийн төгсгөлд суралцагчдын сэтгэл ханамж, сургалтын хөтөлбөрийн үр ашиг, хэрэгцээг үнэлэхийн зэрэгцээ, сургалтын өмнөх ба дараах ДИБ-ын талаарх ойлголтын өөрчлөлтийг хэмжих өөрийн үнэлгээ (self-evaluation) хийгддэг.

APCEIU-ийн дэмжлэгтэйгээр жил бүр төслийн дараах хэлэлцүүлэг семинарыг зохион байгуулж, хэрэгжүүлсэн төслийн үр дүнг солилцох, сургалтын үйл явцыг сайжруулах стратеги, заах арга зүй зэргийг хэлэлцдэг. Энэ нь ДИБ-ын хичээл боловсруулж хэрэгжүүлсэн БНСУ-ын их, дээд сургуулийн багш нарт туршлагаа хуваалцах, хамтран суралцах чухал боломж олгодог.

Нийт 82 хичээл боловсруулагдсанаас гурван ахисан түвшний болон нэг бакалаврын хичээлийг төлөөлөл болгон сонгон танилцуулж байна. Эдгээр жишээ нь соёл урлагаар дамжуулан ДИБ-ыг үр дүнтэйгээр түгээн дэлгэрүүлэх боломжтойг харуулна гэж найдаж байна. Хичээлийн шинэчилсэн хөтөлбөрүүдээс соёл урлаг нь зөвхөн илэрхийлэх бүтээлч хэлбэр бус соёл хоорондын ойлголцол, шүүмжлэлт сэтгэлгээ, нийгмийн оролцоог хөгжүүлэх бодит хэрэгсэл болдог гэдгийг харж болно. Сонгосон хичээлүүд нь ДИБ-ыг олон нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлэх боломжийг харуулж, сургалтын агуулга болон оюутны суралцах туршлагыг баяжуулах ихээхэн чадамжтайг нотолж байна.

Жишээ 1 “ДИБ-ын заах арга зүй ба суралцахуй”, Эва эмэгтэйчүүдийн их сургуулийн Боловсрол судлалын ахисан түвшний сургууль, Боловсрол судлалын тэнхим (2022)

Хичээлийн нэр	ДИБ-ын заах арга зүй ба суралцахуй
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү хичээлийн зорилго нь хөгжмийн багш болохоор суралцаж буй болон ажиллаж буй багш нарын ДИБ-ын чадамжийг дээшлүүлэхэд оршино. ДИБ-ын ач холбогдол боловсролын байгууллагуудад улам бүр өсөж буй энэ үед багш нар дэлхийн иргэнийг төлөвшүүлэхэд шаардлагатай мэдлэг, сургалтын арга зүйн ур чадварыг эзэмших нь нэн чухал юм. Хөгжим нь дэлхий нийтийн харилцааны хэл болон хүн төрөлхтний иргэншил, соёлын ялгааг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс хөгжмийн боловсрол нь оюутнуудын дэлхийн иргэний ухамсрыг төлөвшүүлэх хүчирхэг хэрэгсэл болж чадна. Уг хичээл нь сургуулийн хөгжмийн хөтөлбөрт ДИБ-ын зарчмыг шингээсэн сургалтын чиглэл, агуулга, арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оролцогчдод дэмжлэг үзүүлэх зорилготой. Үүний тулд уг хичээл нь олон соёлт болон соёл хоорондын боловсролын онол, туршлагыг судалгааны ажил, уншлага, дотоод ба олон улсын жишээгээр баяжуулсан тусгай лекцийн хэлбэрээр судлах боломж олгоно. Оролцогчид өөр өөр орны хөгжмийг ашиглан, үндэсний хөгжмийн сурах бичгийн агуулгыг хамруулж, ДИБ-ын хандлагыг шингээсэн хичээлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Ингэснээр тэд хичээлийн үзүүлэх сургалт, уралдаан, академик илтгэл зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх болно.

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

Сургалтын үйл ажиллагаа	
1	Хичээлд танилцах ба ДИБ дахь хөгжмийн боловсролын үүрэг, ач холбогдол – Танилцуулга – Олон соёлын хөгжмийн боловсролоор дамжуулан ДИБ-ыг ойлгох
2	Олон соёлын хөгжмийн боловсрол I: Хөгжим ба соёлын олон янз байдал, Эллиоттын онол – Хөгжмийн олон янз байдлыг ойлгох – Эллиоттын онол болон ДИБ-д түүний хэрэглээний талаар хэлэлцэх
3	Олон соёлын хөгжмийн боловсрол II: Идальго, Бэнкс, Кэмпбэлл, Хесс нарын онолууд – Олон соёлын хөгжмийн боловсролын онолын үндэс – ДИБ-д хөгжмийн боловсролын үүргийг ойлгох
4	Хөгжмөөр бусдыг ойлгох: “Ялгаа” ба “олон янз байдлыг” хүлээн зөвшөөрөх – Өөр өөр хөгжмийн соёлыг ойлгох – Хөгжмөөр дамжуулан олон янз байдлыг үнэлэх, илэрхийлэх арга замыг судлах
5	Дэлхийн хөгжим ба ДИБ: Пансори ба нэгдэл хөгжимд төвлөрөх нь – Дэлхийн хөгжмийн ойлголт, утга – Нэгдэл хөгжим (fusion music)-өөр соёлын холимог байдлыг ойлгох
6	Олон соёл ба хөгжмийн боловсрол: АНУ дахь нийгмийн өөрчлөлтөд чиглэсэн хөгжмийн боловсрол – АНУ дахь олон соёлын хөгжмийн боловсролын нийгмийн орчныг ойлгох – Хөгжмөөр дамжуулан өөрчлөлтийн жишээг судлах
7	Хөгжмийн боловсрол дахь жендер ба хүүхдийн иргэншил: Судалгааны үүднээс – Хөгжмийн боловсрол нь хүүхдийн иргэншил ба жендерийн мэдрэмжид хэрхэн нөлөөлдөг талаар судлах
8	Соёл хоорондын боловсролыг ойлгох – Тодорхойлолт, зорилго, онцлог – Соёл хоорондын боловсролын зургаан үе шат
9	Олон нийтийн хөгжим ба ДИБ – Поп хөгжмийн төрөл, шинж чанар, нийгэм соёлын суурь орчин – ДИБ-д поп хөгжмийн үүрэг
10	Нэгдсэн Солонгосын хөгжим: Хойд, Өмнөд Солонгосын хөгжим ба гадаад дахь солонгос хөгжмийн уламжлал – Хойд Солонгосын хөгжим – Өмнөд ба Хойд Солонгосын хөгжмийн ижил, ялгаатай талууд – Жишээ судалгаа: сургуулийн дуу, нэгдэлд зориулсан хөгжим, диаспорагийн хөгжим
11	ДИБ-ын хөгжмийн хичээл төлөвлөлт ба заах төсөл I: Хөгжмийн сурах бичгийн ДИБ-ын шинжилгээ – Хөгжмийн сурах бичгийг ДИБ-ын үүднээс шинжлэх – Хөгжмийн сурах бичигт ДИБ-ын агуулга хэрхэн шингэсэн байдлыг үнэлэх
12	ДИБ-ын хөгжмийн хичээлийн төлөвлөгөө боловсруулах ба заах төсөл 2: Агуулга болон хичээлийн төлөвлөгөө боловсруулах – Бүлгийн ажил: ДИБ-ын хөгжмийн хичээлийн агуулга, төлөвлөгөө боловсруулах
13	ДИБ-ын хөгжмийн хичээлийн төлөвлөгөө боловсруулах ба заах төсөл 3: Хичээлийн агуулга боловсруулах ба багшийн санал хүсэлт – Бүлгийн ажил: Хичээлийн агуулга боловсруулах, сургалтын материалд харилцан санал өгч сайжруулах

14	ДИБ-ын хөгжмийн хичээл төлөвлөлт ба заах төсөл IV: Талбар дээрх хичээлийн санал, зөвлөгөө – Хичээлийн төлөвлөгөөг талбар дээр турших, зөвлөгөө өгөх
15	ДИБ-ын хөгжмийн хичээл төлөвлөлт ба заах төсөл V: Төслийн танилцуулга ба санал солилцох – Эцсийн төсөл танилцуулах ба хамтран хэлэлцэх – Олон соёлын хөгжмийн туршлага ба хичээлийн эргэцүүлэл
16	ДИБ-ын хөгжмийн хичээлийн уралдаан

Эва эмэгтэйчүүдийн их сургуулийн энэхүү хичээл нь хөгжмийн боловсролоор дэлхийн иргэний төлөвшилийг дэмжих хэрэгсэл болгон ашиглахыг зорьсон. Хичээл нь багш нарыг дэлхийн иргэний боловсролыг сургалтдаа нэвтрүүлэхэд бэлтгэхийн тулд олон төрлийн хөгжмийн материал, арга барил ашиглахын ач холбогдлыг таниулахад чиглэгдсэн. Ахисан түвшний оюутнуудын хувьд ийм төрлийн хичээл нь ирээдүйн багш, судлаачийн хувьд дэлхийн болон соёлын асуудлыг шүүмжлэлтэйгээр судлах, мэргэжлийн чадамжаа өргөжүүлэх, онол ба практикийг уялдуулсан заах арга зүй хөгжүүлэх боломжийг олгодог. Ингэснээр оюутнууд зөвхөн академик мэдлэгээр хязгаарлагдахгүй, харин дэлхийн иргэний боловсролыг олон талт боловсролын орчинд хэрэгжүүлэхэд шаардлагатай бодит ур чадварыг эзэмшдэг.

Жишээ 2 “Дижитал эрин дэх ДИБ” Силла их сургуулийн Боловсрол судлалын ахисан түвшний сургууль, Боловсрол судлалын тэнхим (2024)

Хичээлийн нэр	Дижитал эрин дэх ДИБ
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү хичээл нь Боловсролын ахисан түвшний сургуулийн бүх магистрын оюутнуудад зориулсан оюутнуудад зориулсан ерөнхий сонголт (general elective) хичээл юм. Хичээл нь дижитал технологийн эринд үүсч буй сорилтуудыг даван туулахад шаардлагатай ирээдүйд чиглэсэн үндсэн чадамжуудыг хөгжүүлэхэд чиглэнэ. Ялангуяа Дижитал иргэншил болон Дэлхийн боловсролын чиглэлээр заахад шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхийг зорино. Хичээлийн үр дүнг үнэлэхийн тулд багш дараах хоёр хэрэгслийг ашиглан сургалтын өмнөх ба дараах судалгаа явуулна. “Багш болох оюутны иргэний үнэлгээний хэрэгсэл” (Citizenship Measurement Tool for Pre-service Teachers) болон “Их сургуулийн оюутны дижитал иргэншлийн үнэлгээний шкал” (Digital Citizenship Scale for University Students)-ыг ашиглан сургалтын өмнөх ба дараах судалгаа явуулна. Судалгааны дүнд шинжилгээ хийж, оюутнуудын боловсролын ахиц дэвшлийг тодорхойлохын зэрэгцээ дараагийн хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах санал гаргана. Ингэснээр хичээлийн үр нөлөө, чанарыг нэмэгдүүлэхээс гадна сургалтын эргэх холбоог сайжруулах зорилготой.
Сургалтын үйл ажиллагаа	
1	Хичээлийн танилцуулга ба урьдчилсан түвшин тодорхойлох үнэлгээ
2	Дижитал иргэншил ба дижитал хэрэглээний чадамж
3	Дижитал иргэншлийн боловсролыг ойлгох нь
4	Дижитал аюулгүй байдал ба сэргээн сэргээлт
5	Дижитал мэдээллийг хуваалцах ба хэрэглээ

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь

6	Дижитал эринд боловсролын ажилтны зүг чиг
7	Дижитал орчин дахь бэлгийн гэмт хэргийн ноцтой байдал ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ
8	Дижитал оролцоо: Онлайн харилцаа ба хамтын ажиллагаа
9	Дундах шалгалт
10	Дижитал шилжилт ба бүтээлч асуудал шийдвэрлэхүй: “Nearpod” програмын хэрэглээний танилцуулга
11	Дижитал иргэншлийн сургалтын модулийн төсөл (1)
12	Дижитал иргэншлийн боловсролын кейс судалгаа
13	Дижитал иргэншлийн сургалтын модулийн төсөл (2): Практик хэрэгжилт
14	Дижитал иргэншлийн сургалтын модулийн төсөл (3): Хуваалцах ба санал солилцох
15	Дижитал иргэншлийн сургалтын модулийн төсөл (4): Хэрэгжүүлэлт ба түгээх

Силла их сургуулийн энэхүү хичээл нь ахисан түвшний оюутнуудад дэлхийн асуудлууд болон соёлын үнэт зүйлийг шүүмжлэлтэйгээр задлан шинжлэх, түүнчлэн академик суралцах үйл явцыг бодит амьдралын хэрэглээтэй холбох чадварыг олгоход чиглэсэн байв. Хичээлийн 10 дахь долоо хоногт нэгэн сургуулийн багшийг урьж, тасралтгүй үнэлгээ (formative assessment) болон динамик медиа хэрэгслийг хослуулан, синхрон болон асинхрон сургалтын орчинд ашиглах боломжтой сургалтын платформыг танилцуулсан. Энэ нь технологид суурилсан сургалтын арга зүйн бодит жишээг харуулсан бөгөөд оюутнуудыг боловсролын технологийг ашиглан сургалтын модулийг боловсруулах боломжийг олгосон юм.

Жишээ 3 “Хүн ба орчны судлал дахь ДИБ”, Кореа их сургуулийн Хүн ба орчин судлалын ахисан түвшний сургууль (2022)

Хичээлийн нэр	Хүн ба орчны судлал дахь ДИБ
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү хичээл нь ДИБ-ын чиглэлээр мэргэшсэн багш, судлаачдын лекц, аялал, төсөлд суурилсан суралцахуй (project-based learning)-г хослуулсан бүтэцтэй. Хичээлийн явцад оюутнууд өөрсдийн ДИБ-ын талаарх ойлголт, байр суурийг хуваалцаж, хамт суралцагчидтай хэлэлцүүлэг өрнүүлдэг. Хичээлийн төслийн хэсэгт оюутнууд хүн ба орчны судлалын хүрээнд ДИБ-ын сэдвийг тусгасан төсөл боловсруулж, хэрэгжүүлэн, тайлагнаж, танилцуулна. Эдгээр төслүүд нь байгаль орчин, тогтвортой амьдрал, соёлын олон янз байдал, ядуурал, тэгш бус байдал зэрэг гол асуудлуудыг хамарна. Хичээлийн гол зорилго нь оюутнуудад дэлхийн иргэний тухай цогц ойлголт олгохын зэрэгцээ, мөн хүн ба орчны судлалын нөхцөлд ДИБ-ын зарчмыг судлах, хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааны ур чадварыг олгох явдал юм.

Сургалтын үйл ажиллагаа	
1	Хичээлийн танилцуулга
2	ДИБ-ын шаардлага ба өнөөгийн байдал — ДИБ-ын төслийн танилцуулга
3	'Real Lives' хөтөлбөрөөр дамжуулан дэлхийн иргэдийн амьдралыг ойлгох нь — Дунд сургуулийн Өрхийн эдийн засгийн хичээлд зориулсан ДИБ-ын хөтөлбөр боловсруулах
4	Байгаль орчин ба тогтвортой амьдрал (хоол хүнс ба гэрийн орчин): Хооллолтын дадал ба орчны менежмент нь уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчинд хэрхэн нөлөөлдгийг судлах
5	Байгаль орчин ба тогтвортой амьдрал (хувцас ба хэрэглээний орчин): Хувцас үйлдвэрлэл, хэрэглээ нь уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж буйг судлах
6	Хээрийн аялал (Zero-waste ба иргэний нийгмийн оролцоо)
7	Соёлын олон янз байдал ба соёл хоорондын ойлголцол: Дэлхийн улс орнуудын соёлын ялгааг ойлгох, соёлын үүсэл, төлөвшилийн үйл явцыг судлан соёлын олон янз байдлыг үнэлэх
8	Хүнсний аюулгүй байдал ба үнэ цэнтэй хэрэглээ — MZ үеийн үнэ цэнд суурилсан хэрэглээ, компанийн нийгмийн хариуцлага (CSR, CSV), шударга худалдаа (fair trade) ба хоршооны зарчим — Хөгжиж буй орнуудын хүнсний аюулгүй байдал, өвчний асуудлыг судлах
9	Факттай байдал (Factfulness) — Семестрийн хагас дахь илтгэл — Оюутнуудын дунд хугацааны төслийн танилцуулга ба харилцан санал солилцох
10	Жендерийн тэгш байдал ба хүний эрх: Хүний эрх, жендерийн мэдрэмжийн сэдвийг хэлэлцэх
11	Дайн, дүрвэгсэд ба энх тайван: Дэлхийн дүрвэгсдийн чиг хандлага, амьдралын өөрчлөлт — Иргэний нийгэмтэй уялдсан дүрвэгсдийн боловсролын кейс судалгаа хуваалцах
12	"Та ямар ирээдүйг хүсэж байна вэ?" — 'Reallives'-ийн тусламжтайгаар улс орон бүрийн ТХЗ-ыг харьцуулах — Мегатренд ба эсрэг трендийн (countertrend) шинжилгээ
13	Судалгаа ба ChatGPT (Хиймэл оюуны судалгааны ёс зүй) — ТХЗ-4: Чанартай боловсрол ба Тогтвортой хөгжлийн боловсролын уялдаа
14	Ядуурал ба тэгш бус байдал — Дэлхийн асуудлууд ба олон улсын хүчин чармайлт, хариу арга хэмжээг судлах
15	Төслийн төгсгөлийн танилцуулга: Төслийн тайлан, хэлэлцүүлэг ба асуулт хариулт (Q & A)

Кореа их сургуулийн “Хүн ба орчны судлал дахь ДИБ” хичээл нь оюутнуудад өдөр тутмын амьдралын хэв маяг болон дэлхийн иргэншлийн ойлголтын хоорондын уялдаа холбоог ойлгуулж, академик мэдлэгийг бодит амьдралын туршлагатай холбох зорилготой байв. Хичээл нь оюутнуудад дэлхийн түвшний асуудлуудыг шүүмжлэлтэйгээр задлан шинжлэх, олж авсан мэдлэгээ өдөр тутмын нөхцөлд хэрэгжүүлэх чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн. Ингэснээр оюутнууд дэлхийн иргэний хувьд хариуцлагатай хандлага төлөвшүүлж, шүүмжлэлт сэтгэлгээ, нийгмийн оролцоо, бодит асуудал шийдвэрлэх ур чадвараа хөгжүүлэх боломжтой болсон. Ийм төрлийн хичээлүүд нь оюутнуудын академик мэдлэгийг өргөжүүлэхээс гадна сурсан мэдлэгээ бодит амьдралын сорилтод ашиглах чадварыг нэмэгдүүлдгээрээ ач холбогдолтой юм.

Жишээ 4 “Таны шүүгээн дэх хувцас ба ДИБ”, Чоннамын үндэсний их сургуулийн Боловсролын инновацийн төв (2022)

Хичээлийн нэр	Таны шүүгээн дэх хувцас ба ДИБ
Хичээлийн тодорхойлолт	“Таны шүүгээн дэх хувцас ба ДИБ” нэртэй энэхүү хүмүүнлэгийн суурь хичээл нь хүний эрх, энх тайван, тэгш байдал, ядуурал, олон соёлт байдал, байгаль орчны тогтвортой байдал зэрэг дэлхийн асуудлуудыг ойлгох, ухамсарлах, бодитоор оролцох чадварыг хөгжүүлэх замаар дэлхийн иргэний ухамсрыг төлөвшүүлэхэд чиглэнэ. Хичээл нь лекц, хэлэлцүүлэг, мэргэжилтний илтгэл, хээрийн дадлага, туршилт-практик үйл ажиллагааг хослуулан бүтэцтэй. Хичээлийн эхэнд оюутнууд ДИБ-ын ойлголт, ач холбогдолтой танилцсан. Хүний эрхийн сэдвийн хүрээнд түргэн хувцасны үйлдвэрлэлийн хөдөлмөрийн нөхцөл зэрэг асуудлыг авч үзэж, хүний эрх ба нийгмийн шударга ёсны талаарх тусгай мэргэжилтний лекцийг зохион байгуулсан. Хичээлийн дараагийн хэсэгт тогтвортой хэрэглээг дэмжих дадлуудыг төлөвшүүлэх зорилгоор хувцасны шүүгээг цэгцлэх (closet) зохион байгуулах, уриа бүхий цамц футболк хийх, саван үйлдвэрлэх зэрэг практик үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Мөн “Хоёр дахь гарын өдөр” арга хэмжээ, хувцасны хаягдлын бохирдлын тухай баримтат кино үзэх, “Дэлхийн экосистем, хувцас ба би” зэрэг тусгай лекцүүдэд хамруулснаар хувцасны хэрэглээ дэлхийн байгаль орчинд хэрхэн нөлөөлж буйг эргэцүүлэх боломжтой болсон. Эцэст нь, соёлын олон янз байдал, ялгаварлалын асуудлыг хэлэлцсэн хичээлийн хэсгүүдээр дамжуулан оюутнууд хувцаслалттай холбоотой нийгмийн хэвшмэл ойлголт, соёлын ойлголцлыг судалж, гендер, арьс өнгө, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлтэй холбоотой ялгаварлалын асуудлыг хэлэлцсэн. Мөн бусдад хандсан энэрэл, халамж, ойлголцлыг төлөвшүүлэх зорилгоор хандивын үйл ажиллагааг зохион байгуулсан.
Сургалтын үйл ажиллагаа	
1	Танилцуулга: “Хувцасны шүүгээнд буй дэлхийн иргэн гэж юу вэ?” – Хичээлийн танилцуулга, хувцас дахь дэлхийн иргэний тодорхойлолт, зорилго, арга зүй
2	ДИБ-ын шаардлага – ДИБ-ын түүх, суурь ойлголт, зорилго ба чиглэл
3	Асуудал ба дадлага 1: Хүний эрх – Хувцас үйлдвэрлэл дэх хөдөлмөр эрхлэлт ба ялгаварлалтын асуудлууд
4	Тусгай лекц 1: Хүний эрх ба нийгмийн шударга ёс – Хүний эрх ба дэлхийн иргэний ойлголт – Хүний эрхийн үндсэн ойлголтууд ба ДИБ-ын чиглэлүүд
5	Асуудал ба дадлага 2: Байгаль орчин – Хувцас үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх нөлөө ба хариу арга хэмжээ
6	Хувцас ба байгаль орчин: Хаяж чаддаггүй хувцас – Сэтгэлд үлдсэн хувцас ба тогтвортой загварын тухай эргэцүүлэл
7	Хувцас дахин боловсруулах ба апсайклинг – Хувцас дахин боловсруулах семинар –Ашигласаа хувцас ба апсайклингийн утга, ач холбогдлыг ойлгох

8	Өөрийн уриатай цамц хийх [Үйл ажиллагаа] Цамц хийх бүтээлч семинар
9	Асуудал ба дадлага 3: Өөрийн иргэншил ба дүр төрх – Баримтат кино үзэх: “Би өмсөж байсан хувцас алга болдоггүй” – Хувцаслалт ба өөрийн дүр төрхийн талаарх хэлэлцүүлэг
10	Тусгай лекц 2: Дэлхийн экосистем ба хувцас – Глобал хүрээлэн буй орчны хямрал ба хувцас – “Slow Fashion” ба тогтвортой загварын дадлууд
11	Асуудал ба дадлага 4: Хувцас ба ялгаварлал (1) – Хувцсаар ялгаварлан гадуурхах үзлийг ойлгох [Хэлэлцүүлэг] Хувцасны ялгаварлалтын кейс судалгаа
12	Ялгаа ба ялгаварлалын тухай эргэцүүлэл (жендер, арьс өнгө) [Үйл ажиллагаа] Киноор дамжуулан ялгаа ба ялгаварлалыг эргэцүүлэх
13	Энэрэнгүй сэтгэлийг төлөвшүүлэх сайн дурын ажил [Үйл ажиллагаа] Ахмад настнуудад зориулан малгай нэхэх сайн дурын үйл ажиллагаанд оролцох
14	Тусгай лекц 3: Солонгосын уламжлалт хувцас ба үсний загвар [Үйл ажиллагаа] Олон соёлыг мэдрэх – хөрш орнуудын хоол ба хооллох ёс жаяг танилцуулах
15	Төгсгөлийн шалгалт

Чоннаммын үндэсний их сургуулийн “Таны шүүгээн дэх хувцас ба ДИБ” хичээл нь оюутнуудын өдөр тутмын туршлага, хувийн сонголтыг дэлхийн иргэний үнэт зүйлстэй холбох зорилготой байв. Хичээл нь хувь хүний зан төлөв, хэрэглээний хэв маяг, нийгмийн тогтолцоо нь дэлхийн асуудлуудыг хэрхэн бүрдүүлдгийг эргэцүүлэн ойлгох боломж олгосон. Хичээлийн явцад оюутнууд хөдөлмөрийн нөхцөл, байгаль орчны доройтол, тогтвортой хэрэглээ зэрэг дэлхийн асуудлуудыг өөрийн өдөр тутмын амьдрал болон хэрэглэгчийн туршлагатай уялдуулан шүүмжлэлт сэтгэлгээний чадвараа хөгжүүлсэн. Мөн хэлэлцүүлэг, кейс судалгаа, төслийн суурьт суралцах үйл ажиллагаагаар дамжуулан харилцааны чадвар, хамтын ажиллагаа, асуудал шийдвэрлэх ур чадвараа дээшлүүлсэн.

2.3.2 Иргэний боловсролын чадамжийг сайжруулах хөтөлбөр — Багш бэлтгэх их сургуулиудад зориулсан санаачилга

2017 онд БНСУ-ын Засгийн газар ардчилсан иргэний боловсролыг дэмжихийг үндэсний бодлогын тэргүүлэх чиглэл болгон зарласан. Үүний дагуу 2018 онд Боловсролын яам улс орон даяар ардчилсан иргэний боловсролыг шинэчлэн идэвхжүүлэх цогц төлөвлөгөө боловсруулсан.

Солонгос дахь иргэний боловсрол нь ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэдэг, бие даасан, шүүмжлэлтэй сэтгэх чадвартай, хамтын оршихуйг эрхэмлэдэг чадварлаг ардчилсан иргэдийг төлөвшүүлэхийг зорьдог. Энэ нь хүний эрх, тэгш байдал, энх тайван, хүрээлэн буй орчин, цахим хэрэглээний чадамж зэрэг тодорхой сэдвийн хүрээнд мэдлэг олгохоос

гадна, идэвхтэй оролцоо, практик үйл ажиллагаагаар дамжуулан иргэний үнэт зүйл, хандлага, чадамжийг цогцоор нь хөгжүүлэх хандлагыг баримталдаг.

Энэ хүрээний гол санаачилгын нэг бол “Багш бэлтгэх их сургуулиудад зориулсан иргэний боловсролын чадамжийг сайжруулах хөтөлбөр” бөгөөд уг хөтөлбөрийг БНСУ-ын Боловсролын яам санаачлан, багшийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын иргэний боловсролын чадамжийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөр нь багш бэлтгэх байгууллагуудад сургалтын хөтөлбөрийг сайжруулах, мөн ардчилсан иргэншил, хүний эрх, олон соёлын ойлголцол, тогтвортой хөгжлийн боловсрол (ESD) зэрэг чиглэлээр сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

2019 онд БНСУ-ын Боловсролын яам уг хөтөлбөрийн суурь төлөвлөгөөг баталж, анхны шат (2019–2022)-ны хүрээнд 12 багшийн сургууль (6 Үндэсний боловсролын их сургууль, 6 Боловсролын коллеж) нийт 12 төслийг эхлүүлсэн. Хөтөлбөр нь хоёр үе шаттайгаар (2 жил + 2 жил) хэрэгжсэн. Энэ хугацаанд нийт 172 хичээл шинээр боловсруулж, 1,723 хичээлийг шинэчилснээр иргэний боловсролын элементүүдийг сургалтын хөтөлбөрт системтэйгээр нэгтгэж, дадлагажигч багш нарын иргэний боловсролын чадамжийг дээшлүүлжээ.

Хөтөлбөрт оролцогч их, дээд сургуулиудыг сонгох шалгуурт байгууллагын чадавх ба боловсролын чанарыг илтгэх дараах хүчин зүйлсийг харгалзан үзсэн:

- » Иргэний боловсролыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны төлөвлөгөө, алсын харааны бодит байдал;
- » Төслийн боловсруулалт болон байгууллагын дэмжлэг, хэрэгжилтийн төлөвлөгөөний чанар;
- » Төслийн багийн бүрэлдэхүүн болон сургалт-хөгжлийн чадамжууд;
- » Иргэний боловсролын мэргэшүүлэх ба ахисан шатны хөгжлийн стратегийн тодорхой байдал, хэрэгжих боломж;
- » Иргэний боловсролын хичээл ба сургуулийн түвшний сургалтын арга зүй хоорондын уялдаа холбоо;
- » Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, үр дүнг түгээх, нэвтрүүлэх бодлогын бодитой байдал зэрэг хүчин зүйлс багтсан.

Багшийн өмнөх шатны оюутнуудын иргэний боловсролын талаарх ойлголт болон мэдрэмжийг нэмэгдүүлэхийн тулд, оролцогч их, дээд сургуулиуд дараах оюутан төвтэй сургалт, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн. Үүнд, хэлэлцүүлэгт суурилсан хууль тогтоомжийн боловсрол ба менторшип, сургалтын хөтөлбөрт тусгагдсан ардчиллын хөдөлгөөний туршлагад үндэслэсэн дадлагын үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх ойлголт нэмэгдүүлэх санаачилга, энэрэх сэтгэл төлөвшүүлэх хөтөлбөрүүд, болон нийгэмд суурилсан боловсролын сайн дурын клубууд багтсан.

Хөтөлбөрийн үр дүнд нийт 111 онлайн хичээл шинээр боловсруулагдаж, иргэний боловсролын талаар 39 ном болон 13 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэгдсэн байна.

Гэсэн хэдий ч, төслийн эцсийн үнэлгээний тайланд сайжруулах шаардлагатай хэд хэдэн асуудлыг дараах байдлаар онцолжээ. Үүнд:

- Хөтөлбөр нь ерөнхий болон дунд боловсролын орчны хэрэгцээнд нийцсэн сургалтын чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нь чухал боловч, хэрэгжсэн 12 төслийн ихэнх нь их сургуулийн хүрээнд төвлөрсөн иргэний боловсролд илүү анхаарсан байна. Иймээс цаашдын санаачилгууд нь ажиллаж буй болон багшийн өмнөх шатны оюутнуудыг хамарсан, практик ба оролцоонд суурилсан хөтөлбөрүүдийг өргөжүүлэх шаардлагатай.
- Шинээр боловсруулсан иргэний боловсролын хичээлүүд нь оролцогч их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг мэдэгдэхүйц сайжруулсан боловч, эдгээр үр дүнг бусад дээд боловсролын байгууллага болон өргөн хүрээний боловсролын хамт олонд түгээн дэлгэрүүлэхэд тодорхой хязгаарлалтууд байсаар байна.

Доорх хэсгүүдэд Боловсролын яам (2022)-ны мэдээллээр уг хөтөлбөрт хамрагдсан нэг боловсролын коллеж болон нэг багшийн боловсролын их сургуулийн хэрэгжүүлсэн төслийн жишээг танилцуулна.


Жишээ 1 Солонгосын үндэсний боловсролын их сургууль

Төслийн тодорхойлолт	• Төслийн зорилго Энэхүү төсөл нь дадлагажигч багш нарын “сургуулийн иргэншил”, “үндэсний иргэншил”, “дэлхийн иргэншил”, “дигитал иргэншил” зэрэг чиглэл дэх чадамжийг сайжруулахад чиглэнэ. Мөн иргэний боловсролыг багшийн боловсролын сургалтын хөтөлбөрт бодит байдалд хэрэгжихүйц, бүтээлч, шинэлэг хэлбэрээр хөгжүүлэх замаар иргэний боловсролын чадамжийг төлөвшүүлэх зорилготой. • Хэрэгжүүлэх стратеги 1. Суралцах (Learning): Иргэний боловсролын чадамжийг хөгжүүлэхийн тулд мэргэжлийн суурь, ерөнхий боловсрол, багшийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд хичээлүүдийг шинээр боловсруулах, одоо байгаа хөтөлбөрүүдийг сайжруулах. 2. Оролцох (Participation): Орон нутгийн боловсролын газрууд болон хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран орон нутгийн сургалцах боломжуудыг бүрдүүлж, ардчилалтай холбоотой аяллаар туршлагын сургалтыг зохион байгуулах 3. Дадлагажих (Practice): Магистрын түвшинд суралцаж буй ажиллаж буй багш нартай хамтарсан заах арга, хамтын сургалт хэрэгжүүлэх. Мөн ерөнхий ба хичээлээс гадуурх сургалтуудыг ерөнхий боловсролын сургууль, ажиллаж буй багш нарын хамтын ажиллагаа, багшийн өмнөх шатны оюутнуудын хамтран заах арга (peer teaching), сургалтын болон сургалтаас гадуурх хөтөлбөрүүдийг уялдуулах замаар хэрэгжүүлэх. • Гол үйл ажиллагаа 1. 42 сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах 2. “Сургуулийн ардчилал ба иргэний боловсрол”, “Хиймэл оюуны ёс зүй ба ёс суртахууны боловсрол” зэрэг 6 шинэ хичээл боловсруулах 3. Дадлагажигч багш нарт зориулсан үндэсний хэмжээний иргэний боловсролын заах аргын уралдаан
----------------------	--

Төслийн тодорхойлолт	4. Иргэний боловсролын сайн дурын зуслан 5. Бусад бүсийн их, дээд сургуулиудтай хамтран ардчиллын чиглэлээр аялал зохион байгуулах 6. Бага, дунд түвшний багшийн өмнөх оюутнуудын боловсруулсан иргэний боловсролын сэдэвт үлгэрийн ном бүтээх
------------------------------------	---

Гол үр дүнгүүд

Иргэний боловсролын үлгэрийн ном бүтээх санаачилгын хүрээнд нийт таван сэдвээр “Иргэний боловсролын үлгэрийн ном” хэвлэгдэн, заах болон суралцахуйн үйл ажиллагаанд ашиглах материал болгон гаргасан. Эдгээр номонд тулгуурлан “Аз жаргалтай амьдрал”, “Ёс суртахууны боловсрол”, “Эх хэл” зэрэг бага ангийн хичээлийн хөтөлбөртэй уялдуулсан хичээлийн төлөвлөгөө боловсруулагдсан бөгөөд хэрэгжилтийг дэмжих зорилгоор сургалтын видео бичлэгүүд мөн бүтээжээ. Цаашид хүртээмж, түгээн дэлгэрүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн өөрийн удирдлагын үйл ажиллагаатай (self-governance activities) холбон хэрэгжүүлэх иргэний боловсролын өгүүлэмжит (storytelling) анимейшнүүдийг бүтээж, YouTube сувгаар дамжуулан нийтэд хүргэсэн. Эдгээр үр дүнд суурилан “Үлгэрээр дамжуулан заах иргэний боловсрол” нэртэй шинэ ерөнхий боловсролын хичээлийг боловсруулж, хэрэгжүүлээд байна.



Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын яам (2022)

Шинээр боловсруулсан иргэний боловсролын сургалтын хөтөлбөрүүдийг төслийн зорилготой уялдуулан идэвхтэй хэрэгжүүлсний үр дүнд, эдгээр хичээлүүдэд суралцагчдын сэтгэл ханамж мэдэгдэхүйц нэмэгдсэн бөгөөд төслийн хэрэгжилт нь дадлагажигч багш нарын иргэний боловсролын чадамжийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.

Ялангуяа “Иргэний боловсролын үлгэрийн ном” бүтээх үйл ажиллагаа нь иргэний боловсролыг олон янз байдал, дижитал хэрэглээний чадамж зэрэг нийгмийн хэрэгцээтэй холбож, бодит заах ба суралцахуйн материалуудыг бий болгосон. Дадлагажигч болон

үндсэн багш нар хамтран таван үлгэрийн ном боловсруулж, сургуулийн орчинд ашиглах өгүүлэмжит анимейшн хэлбэрт оруулсан бол оюутнууд эдгээр үр дүнг семинар, сайн дурын ажил, менторшип зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан түгээн дэлгэрүүлжээ.

Энэхүү санаачилга нь бүтээлч ба тогтвортой загвар хэмээн үнэлэгдэж, үүний үр дүнд “Үлгэрээр дамжуулсан иргэний боловсрол” нэртэй хичээл албан ёсны сургалтын хөтөлбөрт нэвтэрснээр иргэний боловсролыг багш бэлтгэх боловсролын түвшинд нэвтрүүлж, тогтмолжуулах, цаашид өргөжүүлэх чухал алхам болсон юм.

Жишээ 2 Сүншин эмэгтэйчүүдийн их сургуулийн Боловсролын Коллеж

Төслийн тодорхойлолт

• Төслийн зорилго

21 дүгээр зууны орон нутгийн, үндэсний болон дэлхийн хэмжээнд хамтдаа оршихуй, асуудал шийдвэрлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулах чадвартай иргэний боловсролын мэргэжлийн багш нарыг бэлтгэх, мөн дадлагажигч багш нарын нийгэмд суурилсан ДИБ-ын чадамжийг бэхжүүлэхэд чиглэнэ.

• Суралцахуйн нийгэмлэгийг бэхжүүлэх ба ДИБ-ыг амьдралын хэв маяг болгон төлөвшүүлэх стратегиуд

1. Бие даасан суралцах нийгэмлэгийг байгуулах, тэ дний үйл ажиллагааг дэмжих
2. Сургуулийн дотоод ардчилсан шийдвэр гаргах тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэхийг дэмжих
3. Дадлагажигч багш нараар удирдуулсан сургалтын орон зай дахь ардчиллын санаачилгуудыг хэрэгжүүлэхийг дэмжих
4. Их сургуулийн өдөр тутмын орчинд ардчилсан иргэний ур чадваруудыг төлөвшүүлэх боломжийг бүрдүүлэх.

• Гол үйл ажиллагаа

1. 37 хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах
2. Шинэ 6 хичээл боловсруулах
3. “Дэлхийн ба Ардчилсан Иргэний Боловсрол I ба II” хичээлүүдийг хамтран боловсруулж, сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх
4. Иргэний болон ДИБ-ын чадамжийг хөгжүүлэх дадлагын (practicum) хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх

Гол үр дүнгүүд

Оюутнууд нь нийгмийн тодорхой бүлэгт чиглэсэн, орон нутгийн иргэдэд хүртээмжтэй, нийгмийн асуудалд суурилсан иргэний боловсролын онол ба арга зүйд тулгуурласан практик болон идэвхтэй сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан.

Боловсролын газрын гол бодлогын санаачилга болох “Нийгмийн асуудалд суурилсан суралцах төслийн хөтөлбөр”-т хамрагдсан дунд сургуулийн багш нартай хамтран ажилласнаар, оюутнууд иргэний боловсролыг бодит сургуулийн орчинд хэрхэн хэрэгжүүлдэг талаарх туршлагыг шууд олж авсан.

- Оюутнууд тухайн орон нутаг болон нийгмийн хүрээнд асуудлыг сонгон авч, анги дотор ашиглах сургалтын үйл ажиллагаанд нэгтгэхийн зэрэгцээ, багийн хэлбэрээр заах, суралцах материал боловсруулснаар харилцаа, хамтын ажиллагааны ур чадвараа дээшлүүлсэн.
- Мөн ментор багш нар энэ үйл явцад оролцсоноор багшийн мэргэжлийн ур чадвараа бататгахын зэрэгцээ дадлагажигч багш нарт чиглэл болж, заах арга зүйн туршлагаа нэмэгдүүлсэн.

Үүнээс гадна “Иргэний боловсролын дадлагын сүлжээ (Civic Education Practice Network)” байгуулснаар иргэний боловсролын хүрээнд тогтвортой хамтын ажиллагаа, харилцан суралцахуйн суурь тавигдсан.

Эх сурвалж: БНСУ-ын Боловсролын яам (2022)

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг нэгтгэх нь




Төслийн хүрээнд Сүншин эмэгтэйчүүдийн их сургууль “Дэлхийн ба Ардчилсан иргэний боловсрол I” болон “Дэлхийн ба Ардчилсан иргэний боловсрол II” хэмээх хоёр сонгон суралцах хичээлийг боловсруулж хэрэгжүүлсэн бөгөөд сургуулиас гадуурх сургалтын үйл ажиллагааг Сөүл хотын Боловсролын газартай хамтран хэрэгжүүлжээ. Орон нутгийн сургуулиуд ба иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран дадлагажигч багш нар ажиллаж буй багш нартай хамтран ангидаа тухайн нийгмийн асуудлуудыг тодорхойлж, тэдгээрт тохирсон сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулсан. Эдгээр үйл ажиллагаа нь дадлагажигч багш нарын хамтын ажиллагаа, харилцааны ур чадварыг сайжруулж, олон талт оролцогчдыг хамарсан иргэний боловсролын дадлагын сүлжээг бий болгоход хувь нэмэр оруулжээ.

Эдгээр хоёр төслийн жишээ нь бага болон дунд боловсролын багш бэлтгэдэг дээд боловсролын байгууллагууд иргэний боловсролын чадамжтай мэргэжилтэн бэлтгэхэд гүйцэтгэх онцгой үүргийг тодотгож өгсөн. Ялангуяа, дадлагажигч багш нарын иргэний боловсролын чадамжийг бэхжүүлэх нь тэдний сайн дурын оролцоонд ихээхэн хамааралтай бөгөөд дээд боловсролын байгууллагууд ийм оролцоог дэмжсэн орчин, соёлыг бүрдүүлэхэд манлайлах шаардлагатайг онцолсон байна. Хамгийн гол нь эдгээр жишээнүүд иргэний боловсролд тулгуурласан хөтөлбөрүүдийг туршлага дээр суурилсан, оролцоонд чиглэсэн сургалтын арга зүйгээр боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатайг харуулсан бөгөөд үүгээр дадлагажигч багш нар сургуулийн орчинд хэрэглэж болох дадал, ур чадварыг эзэмшиж, бодит орчинд туршлагажих боломжийг бүрдүүлсэн.

3. СУИС дахь дэлхийн иргэний боловсролын өнөөгийн нөхцөл байдал

- 3.1 Монгол Улсын Дээд боловсролын салбарын тойм
- 3.2 ДИБ-ын байгууллагын түвшний хэрэгжилт
- 3.3 Дэлхийн иргэний боловсролын талаарх багш нарын мэдлэг ба хандлага
- 3.4 СУИС-ийн стратеги ба нөхцөл байдлын үнэлгээ
- 3.5 Нэгдсэн үр дүн ба хэрэгжилтийн байдал



3. СУИС дахь дэлхийн иргэний боловсролын өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ

Энэхүү бүлэг нь СУИС-д ДИБ-ын үзэл баримтлал ямар түвшинд хэрхэн нэвтэрсэн байгаа өнөөгийн нөхцөл байдлыг том зураглалаар харахад чиглэнэ. Монголын дээд боловсролын салбар, СУИС-ийн үндэсний боловсролын салбарт эзлэх байр суурийг авч үзэхээс эхлэнэ. Үүний дараа ДИБ-ын агуулга СУИС-ийн бодлого, үйл ажиллагаанд хэрхэн туссаныг их сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс болон оюутны хөгжил, сургалтын бодлого, хөтөлбөрийн жишээнээс эрэлхийлнэ. Түүнчлэн СУИС-ын багш нарын ДИБ-ын талаарх ойлголт, хандлага, бэлэн байдлыг судлан, байгууллагын дэмжлэгийн түвшин болон хэрэгжих боломжтой чиглэл, арга зам зэргийг тодорхойлно.

3.1 Монгол Улсын Дээд боловсролын салбарын тойм

Монгол Улсын дээд боловсролын тогтолцоог зохицуулдаг тулгуур эрх зүйн баримт бичиг бол Боловсролын ерөнхий хууль (2023а) юм. Тус хуульд боловсролыг хүний эрхийг хүндэтгэдэг, бүтээлч, ёс суртахуунтай иргэнийг төлөвшүүлэх үйл явц гэж тодорхойлсон байдаг (4, 5 дугаар зүйл). Харин Дээд боловсролын тухай хууль (2023b)-иар их, дээд сургуулийн бие даасан байдал, чанартай сургалт, судалгаанд суурилсан сургалтаар олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэх зорилгыг дэвшүүлсэн.

Бодлогын түвшинд, “Алсын хараа 2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” (2020) баримт бичигт боловсрол ба хүний хөгжлийг үндэсний хөгжил дэвшлийн тулгуур багана гээд стратегийн нэгдүгээр чиглэл, “Хүний хөгжил” хэсэгт боловсролтой, ёс суртахуунтай, бүтээлч, тогтвортой хөгжлийн төлөө хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх тухай заасан. Эндээс дээд боловсролын салбар нь нийгэмд шударга ёс, инновац, бүтээлч иргэн төлөвших гол хөдөлгөгч хүч гэж хэлж болохоор байна. Мөн түүнчлэн, эдгээр хууль, бодлогын баримт бичгүүд нь Тогтвортой хөгжлийн зорилго 4.7 (ТХЗ 4.7)-той нийцсэн бөгөөд энх тайван, хүний эрх, жендерийн тэгш байдал, тогтвортой хөгжил болон дэлхийн иргэншлийг дэмжих боловсрол (UNESCO, 2015)-ыг дэмжих эрх зүйн суурь болж байна.

2025 оны байдлаар Монгол улсад нийт 65 дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрт 11,403 багш, ажилтан ажиллаж байгаагаас 5,151 нь үндсэн багш нар байгаа ба нийт 150,282 оюутан суралцаж байна. Ахисан түвшний боловсролын хувьд 24,830 магистр, 5,488 докторын хөтөлбөрийн оюутнууд суралцаж байгаа ба нийт суралцагчдын 20.2 хувийг бүрдүүлж байна (БШУЯ, 2025).

Өнөөдөр монголын дээд боловсролын салбар хэд хэдэн сорилттой тулгарч байна.

Элсэлтийн эрэлт өндөр ч дээд боловсролын байгууллагуудын 90 гаруй хувь нь Улаанбаатар хотод төвлөрсөн. Багш, ажилтны 60 гаруй хувь (үндсэн багш нарын 65%) нийслэлд ажиллаж байна. Хотын төвлөрөл ахисан түвшинд бүр илүү тод илэрч байгаа бөгөөд магистрын оюутнуудын 59 хувь, докторын оюутнуудын 64 хувь нь нийслэлд суралцдаг. Ийнхүү байгууллага болон хүний нөөцийн хэт төвлөрөл нь бүс нутгийн боловсролын тэгш бус байдлыг үүсгэж, дээд боловсролыг бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих хэрэгсэл болгон ашиглах боломжийг хязгаарлаж байгаа юм. Үүнээс гадна, тэтгэлэгтэй суралцах боломж бага, дотуур байрны хүрэлцээгүй байдал зэрэг нь орон нутгийн оюутнуудын боловсролд хамрагдах бололцоог бууруулж, удирдлагын сул тогтолцоо, судалгааны чадавх дутмаг, мэдээллийн хүртээмжгүй байдал зэрэг нь бодлого төлөвлөлт болон чанарын баталгаажуулалтад саад болж байна (БШУЯ, 2025а; БШУСЯ, 2020).

3.2 ДИБ-ын байгууллагын түвшний хэрэгжилт

3.2.1 СУИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс

СУИС-ийн 2025-2030 оны стратегийн төлөвлөгөөний төсөл (СУИС, 2024)-д *“Соёл урлагийн сургалт, судалгаа эрхэлдэг нээлттэй их сургууль болно”* гэж заасан нь хүртээмжтэй байдал, мэдлэг хуваалцах соёл, олон улсын орчинд төвлөрч ажиллахыг зорьсныг харуулж байна. Эрхэм зорилгыг *соёл урлагаар дамжуулан нийгмийг гэгээрүүлэх, хамтын оролцоонд суурилсан үйл ажиллагааг дэмжих, боловсрол, судалгаа, бүтээлч үйл ажиллагаа болон инновацыг уялдуулахад чиглүүлнэ* гэж тодорхойлсон. Эндээс СУИС-ийн стратегийн чиг баримжаа нь ЮНЕСКО-ын баримт бичгүүд (UNESCO, 2015; UNESCO, 2021)-д тодорхойлсон ДИБ-ын гол утга санаа, ялангуяа энх тайван ба хүний эрх, тогтвортой хөгжил, соёл хоорондын харилцан ойлголцол, нийгмийн хариуцлага зэрэгтэй уялдаж байна. Мөн түүнчлэн, СУИС-ийн суурь үнэт зүйлс нь монголчуудын соёлын өвийг хамгаалах, бүтээлч сэтгэлгээг дэмжих, тогтвортой хөгжлийг эрхэмлэх болохын хувьд ДИБ-ыг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх таатай хөрс болж чадахаар байна.


СУИС-ийн 2025-2030 оны стратегийн төлөвлөгөөний төсөлд заасан (1) чанартай боловсрол; (2) нийгмийн сайн сайханд чиглэсэн судалгаа; (3) хөгжлийн төлөөх нийгмийн хариуцлага; (4) сайн засаглал болон дижитал шилжилт гэсэн стратегийн үндсэн чиглэлүүдэд суралцагч төвтэй сургалтын арга зүй, ёс зүйтэй судалгаа, иргэний оролцоо, хүртээмжтэй засаглалыг дэмжих замаар ДИБ-ын боловсролын зорилгыг бодитоор хэрэгжүүлэх суурь тавигдсан гэж үзэх боломжтой юм.

3.2.2 Оюутны хөгжил ба Хүн төвт боловсрол

Аливаа дээд боловсролын байгууллагад олон улсад өрсөлдөхүйц чадвартай мэргэжилтэн бэлтгэх нь нэн чухал зорилт байдаг. Үүний тулд олон улсын жишиг шаардлага болон орон

нутгийн соёлын онцлог, давуу талуудыг хослуулсан хөтөлбөр боловсруулах шаардлагатай болдог. СУИС нь дэлхийн иргэний чадамжуудыг сургуулийн хүн төвтэй боловсролын философитой системтэйгээр уялдуулах бүрэн боломжтой.

ЮНЕСКО-оос эрхлэн гаргасан гурван тулгуур баримт бичиг болох Жак Делорийн “Боловсрол - Түүнд нуугдсан эрдэнэс” (1996), “Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь: Хамтын сайн сайхны төлөө боловсрол” (2015), болон “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” (2021) зэрэг бүтээлүүд нь өнөөгийн харилцан хамааралтай дэлхийд боловсрол нь хүмүүнлэгийн үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ үзэл санаа нь СУИС-ийн сургалтын онцлог нь оюун санаа, сэтгэл хөдлөл болон ёс зүйн хөгжлийг холбосон хүн төвтэй боловсролын загварт тусгалаа олсон. М.Амартүвшин (2024)-н боловсруулсан энэхүү загвар нь өөрийгөө төлөвшүүлэх, бусадтай зохицон хамтран ажиллах, нийгэмд бүтээлч хувь нэмэр оруулах гэсэн соёл, урлагийн сургуулийн оюутны хөгжлийг гурван хэмжээсээр тодорхойлсон (Зураг 3.1). Эдгээр нь ДИБ-ын танин мэдэхүйн, сэтгэл-зүйн болон зан үйлийн хүрээнүүдтэй шууд дүйж байгаа ба СУИС-ийн боловсролын философи угтаа ДИБ-ын зорилготой нийцэж буйг илтгэж байна.



Зураг 3.1 СУИС-ийн “Хүн төвт боловсролын загвар”

Дээрх загвар нь 2025-2030 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд албан ёсоор баталгаажих шатандаа үргэлжилж байгаа ба сургалтын үндсэн зарчмуудын уялдаа, хөтөлбөрийн нэгдсэн чиг хандлагыг бүрдүүлэх ажилд аль хэдийн тусгалаа олж эхлээд байна. Оюутны хөгжлийн санаачилгуудыг сургалтын академик агуулга, бүтээлч үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагатай уялдуулсан системтэй болгох, өөрөөр хэлбэл “хүн төвт боловсролын загвар”-ын дагуу бүх түвшний сургалтын үйл ажиллагааг нэгдсэн философид нийцүүлэх юм.

3.2.3 Хөтөлбөрийн замнал ба заах арга зүйн хэрэгжилт

СУИС-ийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл явц нь хөтөлбөрийн суралцахуйн зорилго (Programme Educational Objectives – PEOs) болон хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (Programme Learning Outcomes – PLOs) -г тодорхойлж, системтэйгээр хэрэгждэг. PEO нь төгсөгчид хөтөлбөрөө дүүргэснээс хойш 3-5 жилийн хугацаанд ямар мэдлэг, чадвар, хандлагад хүрэхийг тодорхойлдог бол PLO нь оюутнууд суралцах хугацаандаа эзэмших ур чадвар, чадамжийг илэрхийлдэг. Энэхүү бүтэц нь Монгол улсын дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн үндэсний хүрээтэй уялддаг. СУИС-д сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг Ректорын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хэрэгжүүлдэг. Уг ажлын хэсэгт тухайн хөтөлбөрийн багш нар, тэнхимийн эрхлэгчид болон Чанарын баталгаажуулалтын албаны ажилтнуудаас бүрддэг бөгөөд энэ нь сургалтын агуулгын мэргэжлийн онцлогийг хадгалах, байгууллагын болон улсын боловсролын стандарттай нийцүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Энд жишээ болгосон СУИС-ийн “Соёл судлал” магистрын хөтөлбөр нь ДИБ-ын үнэт зүйлс болон суралцахуйн хүрээтэй хэрхэн уялдаж буйг авч үзэв. Энэ хөтөлбөр нь тус сургуулийн хамгийн сайн нийгэмд чиглэсэн, салбар хоорондын уялдаа бүхий хөтөлбөрүүдийн нэг тул харилцан ойлголцол, энх тайван, тогтвортой хөгжил, ёс зүй зэрэг ДИБ-ын ойлголтуудыг сургалтын хөтөлбөр боловсруулах болон суралцахуйн үр дүнгийн түвшинд хэрхэн тусгасан, цаашид хэрхэн сайжруулах талаар төсөөлөл авахад тохиромжтой жишээ болно (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1 Соёл судлалын магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилго ба үр дүн

Товчлол	Тайлбар
PEO 1	Соёлын өв, онол, арга зүйн талаар мэдлэг эзэмшинэ.
PEO 2	Ёс зүйтэй, нийгмийн хариуцлагатай соёлын мэргэжилтэн болно.
PEO 3	Шүүмжлэлт сэтгэлгээ болон академик бие даасан байдлыг төлөвшүүлнэ.
PLO 1.1	Соёлын олон янз байдал болон дэлхийн харилцан уялдааг ойлгоно.
PLO 1.2	Соёлын үзэгдлийг судлахдаа салбар хоорондын арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийж чадна.
PLO 1.3	Судалгааны ба дүн шинжилгээний хэрэгслүүдийг ашиглан соёлын үйл явц, үзэгдлийг шинжилж чадна.
PLO 2.1	Нийгэм ба нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллаж соёлын тогтвортой байдлыг дэмжиж чадна.
PLO 2.2	Соёл хоорондын харилцааны ур чадварыг эзэмшинэ.
PLO 2.3	Хамтын ажиллагааг удирдах, багийн ажлыг зохион байгуулах, төвөгтэй эсвэл тодорхой бус нөхцөлд дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах чадварыг эзэмшинэ.
PLO 3.1	Ёс зүйд тулгуурлан сэтгэж, шийдвэр гаргаж чадна.
PLO 3.2	Бие даан, нотолгоонд суурилсан соёлын судалгаа хийж чадна.
PLO 3.3	Хамтын судалгаа, бодлого боловсруулах эсвэл олон нийтийн төсөл хэрэгжүүлэх чиглэлээр манлайлна.
PLO 4.1	Соёл урлагийн салбарт мэдлэгээ бүтээлчээр ашиглана.
PLO 4.2	Судалгааны үр дүнд тулгуурлан эрдэм шинжилгээний бүтээл, инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ, соёлын бүтээгдэхүүн боловсруулна.
PLO 4.3	Судалгаа, сургалт, бүтээл туурвилд бүтээлч байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, арга зүйн шинэлэг хандлагыг хэрэгжүүлнэ.

СУИС-ийн “Соёл судлал” магистрын сургалтын хөтөлбөрийн эмхэтгэл (х. 11–16)-т үндэслэн боловсруулав.

Соёл судлалын хөтөлбөрийн академик түвшин (бакалавр, магистр, доктор) дэх суралцахуйн үр дүн ба ДИБ-ын чадамжийг авч үзэн доорх хүснэгтэд нэгтгэв. Ингэхдээ ДИБ-ын гурван хүрээ (танин мэдэхүйн, нийгэм-сэтэл зүйн, зан үйлийн) болон соёлын олон янз байдал, ёс зүй, тогтвортой хөгжил, дэлхийн асуудалд оролцоотой байх гэсэн чадамжууд нь СУИС-ийн сургалтын хөтөлбөрийн агуулгатай хэрхэн уялдаж байгааг онцолсон (Хүснэгт 3.2).

Хүснэгт 3.2 Академик түвшний суралцахуйн үр дүн ба Дэлхийн иргэний боловсролын чадамжууд

Түвшин	Дэлхийн иргэний боловсролын чадамжууд	Холбогдох PEO / PLO
Бакалавр	Үндэсний соёлын өвийг эрхэмлэж, бусдын соёлыг хүндэтгэдэг	PEO 2, PLO 2.1, 2.2, 2.3
	Харилцан ойлголцол, энх тайван, хамтын ажиллагааг эрхэмлэдэг	PEO 3, PLO 3.2, 3.3
	Монголын өв соёлыг хамгаалах болон олон улсад сурталчлах үйлсэд хувь нэмэр оруулдаг	PLO 1.3, 1.4, 4.1, 4.3
	Соёлын үүднээс тогтвортой хөгжлийн үндсийг ойлгуулан харилцан мэдээлэл солилцдог	PLO 4.1, 4.2
Магистр	Дэлхийн иргэний ухамсар, соёл хоорондын ойлголцлыг харуулдаг	PLO 3.2, 3.3
	Ёс зүйг баримталж, судлаачийн хувьд нийгмийн хариуцлага хүлээдэг	PEO 2, PLO 2.1, 2.2
	Шүүмжлэлтэй сэтгэж, соёлын ялгааны талаар харьцуулсан судалгаа хийдэг	PLO 1.1, 1.2, 1.3
	Тогтвортой хөгжил ба инновацийн асуудалд идэвхтэй оролцдог	PLO 4.1, 4.2, 4.3
Доктор	Шинэ мэдлэг бүтээж, дэлхийн асуудлыг тунгаан боддог	PLO 1.1, 1.2
	Ёс зүй болон нийгмийн хариуцлагаа ухамсарлан хэрэгжүүлдэг	PLO 2.1, 2.2
	Олон улсын орчинд мэргэжлийн болон хамтын ажиллагааг өрнүүлдэг	PLO 3.1, 3.2
	Судалгаа хийж, үр дүнг нь инновацийн шийдэл ба тогтвортой хөгжилтэй уялдуулан практикт хэрэгжүүлдэг	PLO 4.1, 4.2, 4.3

Уг хөтөлбөрийн баримт бичигт ДИБ гэсэн нэр томъёог шууд ашиглаагүй боловч соёлын олон янз байдал, ёс зүйн хариуцлага, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцол зэрэг үндсэн ойлголтууд нь сургалтын хөтөлбөрийн агуулгад шингэсэн байна. Харин суралцахуйн үр дүнгүүд нь ДИБ-ын танин мэдэхүйн, нийгэм-сэтгэл зүйн, зан үйлийн хүрээнүүдтэй уялдан, оюутнуудыг эргэцүүлэн боддог, хариуцлагатай, дэлхийд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн болгон төлөвшүүлэх зорилготой нийцэж байна.

ДИБ-ын хүрээтэй уялдуулан судалгааны баг хичээлийн агуулгыг үнэлэх туршилтын шинжтэй рубрик загварыг (Хүснэгт 3.3) боловсруулав. Туршилтын загвар боловч сургалтын хөтөлбөрийг шинжлэх, сайжруулахад ашиглах боломжтой үнэлгээний хэрэгсэл болж чадна. Үүнийг “Соёл хоорондын харилцаа”, “Соёлын өв ба иргэншил”, “Даяаршил ба орон нутгийн соёл” зэрэг хичээлүүдэд туршин ашиглахад, ДИБ-ын гурван үндсэн хүрээний агуулгатай зохистой уялдаж буй нь харагдаж байна. Энэ нь соёл, урлагийн боловсрол нь бүтээлч судалгаа, соёл хоорондын харилцаа, хэлэлцэл (диалог), хэрэглээний судалгаа зэргээр дамжуулан ДИБ-той уялдуулах таатай орон зай, боломж болохыг нотолж байна.

Хүснэгт 3.3 Хичээлийн дэлхийн иргэний боловсролын хүрээний агуулгыг үнэлэх рубрик

ДИБ-ын хүрээ	Бүрэн хамарсан: 2 оноо	Хэсэгчлэн хамарсан: 1 оноо	Хамаараагүй: 0 оноо
Танин мэдэхүйн хүрээ	Хичээл нь дэлхийн асуудал, харилцан хамаарал, эсвэл соёлын олон янз байдлын талаар агуулгын хувьд өргөн хамарсан байна	Хичээлд эдгээртэй холбоотой сэдэв, жишээ бага боловч багтсан байна	Холбогдох агуулга байхгүй
Нийгэм-сэтгэл зүйн хүрээ	Хичээл нь суралцах үйл ажиллагаагаар дамжуулан энэрэх сэтгэл, харилцан яриа, соёл хоорондын ойлголцлыг төлөвшүүлдэг	Хичээлд эргэцүүлэл эсвэл үнэт зүйлд суурилсан элементүүд зарим талаар тусгагдсан	Нийгэм-сэтгэл хөдлөлийн элемент илрээгүй
Зан үйлийн хүрээ	Хичээлд туршлагад суурилсан, оролцоотой, үйлдэлд чиглэсэн (жишээ нь: бүлгийн төсөл, нийгэмд суурилсан оролцоо) үйл ажиллагаа багтсан	Хичээл нь зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн боловч практик оролцоо дутмаг	Хэрэглээний сургалтын боломж байхгүй

(Тайлбар: Энэхүү хүснэгтийн агуулгыг ЮНЕСКО [2015] эх сурвалжаас авч боловсруулав.)

Энэхүү үнэлгээний рубрик загвар нь ДИБ ба сургалтын хөтөлбөрийн уялдааг хэлэлцэхэд багш болон оролцогч талуудад асуудал, шийдлийг илүү оновчтой тодорхойлоход туслах ба цаашид хичээл, хөтөлбөрийн үнэлгээ болон хөтөлбөрийг хөгжүүлэх үйл явцад ДИБ-ыг системтэй уялдуулах суурь нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

3.2.4 Сургалтын хөтөлбөрийг сайжруулах санаачилгууд

2021-2022 оны хичээлийн жилд Хүмүүнлэг, боловсрол судлалын тэнхим “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг бие даалтын ажлаар түгээн дэлгэрүүлэх нь” нэртэй төслийг хэрэгжүүлж, заавал судлах долоон хичээлийн хүрээнд нийт 2,480 бакалаврын оюутныг хамруулсан. Энэхүү санаачилга нь СУИС-ийн Багшийн санаачилгыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж, “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс” (2013-2020) төслийн үр дүн, судалгаанд тулгуурласан байна. Тус төсөл нь Монгол улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 149 дүгээр зарлигт заасан Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүргийг хэрэгжүүлэхийг зорьж, оюутнуудын эргэцүүлэл бодох, бүтээлч сэтгэлгээ, соёлын илэрхийллээр дамжуулан үндэсний ухамсрыг бэхжүүлэхэд чиглэжээ. Хэдийгээр уг төсөл нь албан ёсоор ДИБ нэрийн дор хэрэгжээгүй боловч ёс зүй, соёл хоорондын харилцан яриа, бүтээлч илэрхийллийг дэмжсэнээр ДИБ-ын үндсэн зарчмуудыг бодитоор хэрэгжүүлсэн гэх үзэж болохоор байна. Оюутнууд эсээ, богино хэмжээний видео, уран бичлэг, дижитал бүтээлүүдийг туурвих замаар монгол хүн, гэр бүл, төрт ёс, эх нутаг, эх хэл, өв соёл, нүүдлийн ухаан, эрдэм боловсрол, ёс суртахуун зэрэг монголчуудын эрхэмлэн дээдлэх есөн үнэт зүйлийг бүтээлчээр тусган харуулсан бөгөөд ингэснээр

үндэсний өв соёлоо дээдлэх ба дэлхийн соёлын ухамсрыг холбох гүүрийг бий болгосон (Зураг 3.2). Багш нарын өгсөн дүгнэлтээр, энэхүү санаачилга нь оюутнуудын суралцах үйл явцад урам зориг өгч, бүтээлчээр сэтгэх чадварыг хөгжүүлж, үндэсний бахархлыг нэмэгдүүлсэн бөгөөд эдгээр нь ДИБ-ын нийгэм-сэтгэл зүйн чадамжийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг харуулсан байна.



Зураг 3.2 СУИС-ийн “Оюутны бие даасан бүтээлээр дамжуулан Монголын эрхэм үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх нь” төслийн үр дүн

Энэхүү санаачилга нь хичээл сургалтад үзүүлсэн эерэг үр нөлөөнөөс гадна, байгууллагын түвшинд урт хугацаандаа чухал ач холбогдолтой ажил болсон бөгөөд ДИБ-ыг сургалтад тусгах сайн жишээ гэж харж байна. Төслийн хүрээнд боловсруулсан багшийн гарын авлага нь СУИС-ийн цахим сургалтын платформд байршиж багш, оюутнуудад нээлттэй цахим эх сурвалж хэлбэрээр ашиглагдах боломжтой болсон. Энэ алхам нь төслийн үр нөлөөг цааш тэлж, соёл хоорондын харилцаанд суурилсан сургалтын тогтвортой лавлах материал болсон байна.

Үүнтэй зэрэгцэн СУИС нь НҮБ-ын Хүн амын сан (UNFPA) болон Швейцарын Хөгжлийн агентлаг (SDC)-ийн дэмжлэгтэйгээр “СУИС-ийн ерөнхий суурь зарим хичээлийн агуулгыг жендерийн мэдрэмжтэй болгох нь” (2020) сургалтын гарын авлагыг сургалтад нэвтрүүлсэн. Уг гарын авлага нь соёл судлал, эдийн засаг, түүх, философи, монгол хэлний найруулга зүй зэрэг зургаан ерөнхий суурь хичээлд жендерийн тэгш байдлын сэдвийг тусгасан загвар хичээлүүдийг багтаасан ба тэгш оролцоо болон хүний эрхийн боловсролыг дэмжих чухал ажил болсон байна. Багш нартай хийсэн ярилцлагаас зарим нэг асуудлуудыг тодруулахад дээрх арын авлагыг хэвлэн тараасан нь урт хугацаандаа багш оюутнуудад хүртээмж хязгаарлагдмал, сургалтдаа идэвхтэй ашигласан ч багш нарийн хичээл зүтгэлийг үнэлэх, урамшуулах тогтолцоо байгаагүй бөгөөд байгууллагын түвшний хяналт, үнэлгээ хангалтгүй байсан байна. Өөрөөр хэлбэл төслийн хэрэгжилтийг хувь хүний итгэл үнэмшилд л найдах, тогтворгүй байдлыг үүсгэсэн. Эдгээр туршлагууд нь ДИБ-ын үзэл баримтлалтай уялдсан сургалтын шинэчлэлийг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд системтэй дэмжлэг шаардлагатайг харуулж байна.

3.2.5 Хөтөлбөрөөс гадуурх сургалт

СУИС-ийн хөтөлбөрөөс гадуурх болон хөгжүүлэх сургалтууд нь тус сургуулийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг юм. Оюутны хөгжил, үйлчилгээний газар эдгээр сургалтуудыг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг хариуцдаг бөгөөд хичээлээс гадуур хөгжих орчныг бий болгож, нийгмийн хариуцлагатай, соёл урлагийн мэдрэмжтэй болгон төлөвшүүлэхийг зорьдог. Ректорын баталсан “Оюутны хөгжлийн хөтөлбөр”-ний хүрээнд тус газар нь оюутныг бүх талаар хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, манлайлал, оролцоог уялдуулах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Доорх хүснэгт (Хүснэгт 3.4)-д СУИС-д одоогоор хэрэгжиж буй оюутны хөгжил ба гадаад харилцааны үйл ажилагаатай холбоотой хөтөлбөрүүдийг нэгтгэж үзүүлэв. Эдгээр үйл ажиллагаа нь академик сургалт болон бусад үйл ажиллагаанууд хэрхэн уялдан, оюутнуудад энэрэх сэтгэл, соёл хоорондын ойлголцол, иргэний хариуцлагыг төлөвшүүлж байгаа талаас нь дүгнэв.

Хүснэгт 3.4 СУИС-ийн оюутны хөгжил ба дэлхийн оролцооны хөтөлбөрүүд

Ангилал	Гол үйл ажиллагаа ба үр дүн
Оюутны чадавхжуулах	Оюутны зөвлөлийн бие даасан үйл ажиллагаа, менторшип болон чиглүүлэх хөтөлбөрүүд нь оюутны өөртөө итгэх итгэл, оролцоог нэмэгдүүлдэг.
Хувь хүний цогц хөгжил	Оюутны амьдралын чанарыг дэмжих хөтөлбөрүүд, жил бүр тогтмол зохион байгуулагддаг спортын наадам ба урлагийн үйл ажиллагаанууд, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг дэмжих, ёс зүй ба соёлын үнэт зүйл, мэргэжлийн сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээг багтаасан санаачилгууд нь оюутны бүх талын хөгжлийг дэмжиж байна.
Нийгмийн хариуцлага ба шударга ёс	Эрүүл мэнд ба аюулгүй байдлын мэдлэг; хүний эрх, хүйсийн тэгш байдлын сургалтууд; санхүүгийн боловсрол болон нийгмийн хариуцлагын талаарх сургалт, семинаруудыг календарчилсан төлөвлөгөөнд тусган зохион байгуулдаг.
Идэвхтэй бүтээлч иргэн	Оюутны санаачилгатай төсөлд олгодог грантууд, сайн дурын үйл ажиллагаанд оролцсон оролцоог үнэлэх тогтолцоо, нийгмийн инновацад чиглэсэн оюутны бүтээлч төслүүдэд дэмжлэг үзүүлдэг.
Соёл хоорондын ба глобал оролцоо	Олон улсын хамтарсан тоглолт, үзэсгэлэн, солилцооны хөтөлбөрүүд, мөн гадаад улс орнуудын соёлын болон хэлний олон янз байдлыг тэмдэглэх “Соёлын өдөр” зэрэг үйл ажиллагаанууд.

Эдгээр үйл ажиллагаанууд нь СУИС-ийн академик зорилго болон үнэт зүйлд тулгуурласан практик сургалтыг холбох гүүр болдог. Тэдгээр нь хүн төвт боловсролын зарчмуудыг бодит туршлага болгон хувиргаж, ДИБ-тэй холбоотой чадамжуудыг хөгжүүлэхийн зэрэгцээ хичээл болон хичээлээс гадуурх сургалтын уялдааг бэхжүүлэх боломжийг харуулж байна.

Мөн тус газар нь бодлогын түвшний улсын хэмжээний хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санал хүсэлтээ тогтмол илгээдэг. Тухайлбал, 2025 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан

“Оюутны цогц хөгжил: асуудал ба шийдэл” үндэсний форумд залуусын төлөвшлийн талаарх үндэсний нэгдсэн үзэл баримтлалыг тодорхойлох хэлэлцүүлгийг дурдаж болно. Энэ нь “дэлхийн Монгол иргэн” буюу мэдлэгтэй, ёс зүйтэй, бүтээлч, үндэсний соёл болон дэлхийн соёл, нийгэмд бодитой хувь нэмэр оруулах чадвартай иргэнийг төлөвшүүлэх боловсролыг хөгжүүлэх зорилгодоо үнэнч байгаагийн илэрхийлэл юм.

3.3 Дэлхийн иргэний боловсролын талаарх багш нарын мэдлэг ба хандлага

СУИС-ийн хэмжээнд ДИБ-ын ойлголт ямар түвшинд байгааг тодорхойлох зорилгоор багш нарын хандлагын судалгааг 2025 оны 5 дугаар сарын 5-наас 9 дүгээр сарын 12-ны хооронд зохион байгуулав. Судалгааны зорилго нь багш нарын ДИБ-ын талаарх мэдлэг, ойлголт болон СУИС-ийн хөтөлбөрт нэвтрүүлэхэд тулгарч болох бэрхшээл, хязгаарлалтыг тодорхойлох байв. Судалгааны үр дүнд үндэслэн байгууллагын бэлэн байдлын суурь хэмжүүрийг гаргах ба багшийн чадавх хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах стратеги боловсруулахад хэрэглэнэ.

Судалгаа нь 3 хэсэг, 15 асуултаас бүрдсэн ба Google Forms ашигласан. СУИС-д үндсэн болон гэрээт багшаар ажиллаж буй 212 багш нарыг хамруулснаас 120 нь дүн шинжилгээнд ашиглаж болохуйц хариулт байсан нь нийт олонлогийн 56.6% болж байна. Бүтцийн сургуулиудын багш нарын оролцоог Хүснэгт 3.5-т үзүүлэв. Энэхүү судалгаанд хамрагдсан түүвэр нь 95%-ийн итгэлцлийн түвшинд $\pm 6.6\%$ -ийн алдааны магадлалтайгаар СУИС-ийн нийт багш нарын төлөөллийг хангаж байгаа буюу судалгааны үр дүнг нийт багш нарын түвшинд ерөнхийлөн авч үзэх боломжтой байна. Найдвартай байдлын коэффициент (Cronbach α) 0.86 гарсан нь судалгааны асуулга дотоод нийцэлтэй, найдвартай байдал өндөр, хэмжилтийн үзүүлэлтүүд нь үнэн зөв болохыг харуулж байна.

Хүснэгт 3.5 СУИС-ийн багш нарын хандлагын судалгаанд оролцсон байдал, сургуулиар

Но.	Бүтцийн сургууль	Нийт багшийн тоо	Оролцогчийн тоо	Оролцооны хувь
1	Бүжгийн урлагийн сургууль	18	12	66.7%
2	Дүрслэх урлагийн академи	24	9	37.5%
3	Театрын урлагийн сургууль	34	32	91.2%
4	Хөгжмийн урлагийн сургууль	84	39	46.4%
5	Кино, телевиз медиа урлагийн сургууль	22	14	63.6%
6	Соёлын сургууль	30	14	46.7%
	Нийт	212	120	56.6%

Ихэнх оролцогчид олон жил ажилласан туршлагатай буюу 87.2% нь 10 ба түүнээс дээш жил багшилсан гэж хариулжээ. Хичээл ордог түвшнээр эрэмбэлбэл бакалавр (59.8%), магистр (31.8%), доктор (8.4%) байгаа нь СУИС-ийн хөтөлбөрийн бүх түвшний багш нарыг хамарсныг харуулж байна. Харин хичээлийн хувьд ерөнхий суурь хичээл (42.9%) болон мэргэжлийн хичээл (45.7%)-заадаг багш нар хамрагдсан нь тэнцвэртэй хамруулсан нь судалгааны найдвартай байдлыг нэмэгдүүлж байна.

Судалгааны үр дүнг тайлбарлахад статистик шинжилгээнээс гадна багш нартай хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн үр дүнг ашигласан. Энэ нь багш нарын ДИБ-ыг хүлээн ойлгох ойлголт, сэтгэлзүйн бэлэн байдал болон байгууллагын орчны бэлэн байдлыг ойлгох боломжийг бүрдүүлсэн.

3.3.1 Багш нарын хандлага ба байгууллагын орчин

Судалгааны төсөл эхлэхээс өмнө буюу санал боловсруулах явцад СУИС-ийн хамт олонд энэхүү төслийн саналыг танилцуулж, төслийн багт нэгдэхийг уриалсан. Энэ үед хамгийн түгээмэл гарсан асуулт нь “Энэ яг юунд хэрэгтэй вэ? Манай бакалаврын хөтөлбөрүүдэд иргэний боловсролын агуулга аль хэдийн орсон байдаг шүү дээ” гэсэн утгатай байсан.

Энэхүү хариу үйлдэл нь хоёр чухал ойлголтыг илэрхийлсэн. Нэгдүгээрт, дэлхийн иргэний боловсролын ойлголтыг бакалаврын түвшинд олгодог уламжлалт иргэний эсвэл ёс зүйн боловсролтой андуурч ойлгох хандлага түгээмэл байна. Хоёрдугаарт, дэлхийн харилцан хамаарал, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцол, энх тайвныг бэхжүүлэх зэрэг уламжлалт иргэний боловсролоос илүү өргөн хүрээтэй сэдвийг хамардаг дэлхийн иргэний боловсролын үзэл баримтлалыг танин мэдэх түвшин хангалтгүй байгаа байдал байв. Мөн гадаад хэлний бэрхшээл болон ажлын ачааллын хуваарилалт нь багш, ажилтны оролцоог хязгаарлах гол хүчин зүйл байв. Багш нарын олонх нь англи хэл дээр зохион байгуулагдсан уулзалт, семинарт оролцоход бэрхшээлтэй байсан бөгөөд зарим нь хичээлийн ачааллаасаа шалтгаалан шинэ санаачилгад хамрагдах боломжгүйгээ илэрхийлсэн. Үүний үр дүнд төслийн талаар мэдээлэл түгсэн ч идэвх оролцооны хүрээ хязгаарлагдмал, голчлон олон улсын хамтын ажиллагаа болон хөтөлбөрийн хөгжүүлэлтэд оролцдог, гадаад хэлний мэдлэгтэй цөөн тооны багш, ажилтнуудын идэвх илүү өндөр байв.

Хандлагын судалгааны үр дүнгээс ч эдгээр хязгаарлагдмал ойлголт нийтлэг байгаа нь ажиглагдсан. Сүүлийн таван жилд олон улсын төсөлд оролцсон багш нарын хувь 71.7% байсан бөгөөд үүнээс урлагийн хамтын ажиллагаа (43.3%) хамгийн түгээмэл хэлбэр байв. Нөгөөтэйгүүр, судалгаанд оролцогчдын 28.3% нь “Олон улсын төсөлд оролцож байгаагүй” гэсэн багш нарын идэвх, оролцооны түвшинд хуваагдал байгааг харуулж байна. Үр дүнгээс харахад 75.8% нь санхүү болон материаллаг дэмжлэг, 50% нь гадаад хэлний эсвэл орчуулагчийн туслалцаа үр дүнтэй хамтын ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл гэж үзжээ. Харин 28.9% нь уян хатан ажлын цагийн зохицуулалт, 27.3%

нь байгууллагын дэмжих бодлого гэж хариулсан нь байгууллагын үйл ажиллагааны зохицуулалт хоёрт буюу зайлшгүй шаардлагатай хүчин зүйлийн нэг болохыг илтгэж байна.

Эдгээр үр дүнгээс үзэхэд СУИС-ийн багш нар дэлхийн иргэний боловсрол болон олон улсын хамтын ажиллагааг үзэл санааны хувьд дэмждэг боловч тэдний бэлэн байдлыг байгууллагын дэмжлэгийн тогтолцоо тодорхой хэмжээгээр хязгаарлаж байна. Иймээс чадавх бэхжүүлэх арга хэмжээг зөвхөн агуулгын хүрээнд бус, мөн багш нарын оролцоог хангах тогтвортой дэмжлэг бүхий ажлын орчныг бүрдүүлэхэд чиглүүлэх шаардлагатай гэж судалгааны үр дүнг дүгнэж болохоор байна.


3.3.2 ДИБ талаарх багш нарын мэдлэг ба хичээлд тусгагдсан байдал

ДИБ-ыг дээд боловсролын хөтөлбөрт оновчтой тусгах үйл явцад багш нарын бэлэн байдал онцгой ач холбогдолтой. Тогтвортой хэрэгжилт нь зөвхөн сургалтын хөтөлбөрт туссанаар хязгаарлагдахгүй бөгөөд багш нарыг өөрчлөлтийн хамтран бүтээгч болгон аль болох эртнээс оролцуулах явдал нэн чухал юм. Багш нар нь өөрчлөлтөд чиглэсэн сургалтын (transformative pedagogy) арга зүйг хэрэгжүүлэгч гол дамжуулагчийн үүргийг гүйцэтгэдэг. Тэдний үнэт зүйл, ойлголт, итгэл үнэмшил нь ДИБ-ыг түр зуурын туршилтын санаачилга биш, харин сургалтын тогтвортой соёл болгон төлөвшүүлэх эсэхийг тодорхойлно.

Судалгааны үр дүнгээс харахад багш нар ДИБ-ын зарчмуудыг ихээр дэмжсэн бөгөөд дундаж оноо нь 5 шатлалт хэмжүүрээр 4.2–4.6 хооронд хэлбэлзэж байв. Энэ нь багш нар дээд боловсролыг нийгмийн хариуцлага, соёл хоорондын ойлголцол, энэрэнгүй байдал, ёс зүйн ухамсар төлөвшүүлэх хэрэгсэл гэж үздэгийг харуулж байна.

Нийт оролцогчдын 91.5% нь ДИБ-ын талаар тодорхой түвшний мэдлэгтэй, тэдний талаас илүү хувь нь үндсэн зарчмуудыг сайн буюу маш сайн мэддэг гэжээ. Гэсэн хэдий ч ДИБ-ыг иргэний эсвэл ёс суртахууны боловсролын нэг хэлбэр гэж нарийн хүрээнд ойлгох хандлага заримд нь хэвээр байна. Одоогийн сургалтын агуулгад ДИБ-той холбоотой агуулга дундаж түвшинд туссан байгаа ч энэ нь сэдвээсээ хамааран жигд бус түвшинд байна.

Зураг 3.3 нь СУИС-д зааж буй хичээлүүдэд ДИБ-ын сэдвүүд хэр хэмжээнд тусгагдсаныг харуулна. Үүнээс хүний эрх ба соёлын олон янз байдал хамгийн өндөр давтамжтай ($M = 3.74$) байхад, жендерийн тэгш байдал ($M = 3.16$) болон ядуурал ба нийгмийн тэгш бус байдал ($M = 3.10$) сэдвүүд хамгийн бага давтамжтай байна. Нийт есөн сэдвийн дундаж $M = 3.40$ байсан нь ДИБ-ын уялдаа дундаж түвшинд байгаа ч эерэг хандлагатайг харуулж байна.



Зураг 3.3 ДИБ-ын сэдвүүдийн тусгагдсан байдал

Корреляцийн шинжилгээний үр дүн багш нарын ДИБ-ын сэдвүүдэд хандах хандлага болон тэдгээрийг хичээлдээ тусгаж буй байдал хоёрын хооронд эерэг боловч сул хамаарал ажиглагдсан (Pearson's $r \approx 0.10-0.35$, $p < 0.05$). Хэдий хамаарлын шинжилгээнд төдийлөн ач холбогдолтой биш ч боловсрол судлалын олон улсын судалгаанд $0.10 \leq r \leq 0.30$ байх багаас дундын хамаарал нь хандлага ба зан үйл хоорондын уялдааг тодорхойлох боломжтой гэж үздэг (Cohen, 1988). Иймд ДИБ-ын үнэт зүйлд илүү итгэл үнэмшилтэй ханддаг багш нар нь холбогдох сэдвүүдийг хичээлдээ илүү тусгах хандлагатай болохыг энэхүү үр дүн харуулж байна.


Хэдийгээр багш нарын ДИБ-ын талаарх ойлголт, мэдлэг өндөр байгаа боловч хэрэгжүүлэх явцад нийтлэг бэрхшээлүүд тулгарч байна. Хамгийн түгээмэл дурдагдсан хүндрэлүүд нь ДИБ-тэй холбоотой заах арга зүйн туршлагын дутмаг байдал (60.8%), цаг хугацааны хомсдол (44.2%), болон байгууллагын стратеги, бодлогын уялдаа дутмаг (34.2%) зэрэг байв. Эдгээр үр дүн нь соёл, урлагийн боловсролын онцлогт тохирсон, хүртээмжтэй, хос хэл дээрх сургалтын материал, багшийн хөгжлийн системтэй бодлого, хөтөлбөрийг сайжруулах хамтын оролцоо шаардлагатайг илтгэж байна.

3.3.3 ДИБ-ыг хөтөлбөрт тусгах бэлэн байдал ба хэрэгжүүлэх арга замын төсөөлөл

ДИБ-ыг хөтөлбөрт нэвтрүүлэхэд тохиромжтой арга замын талаар асуухад, багш нар шат дараатай, хамтын ажиллагаанд суурилсан хэлбэрийг дэмжих хандлагатай байв. Олонх нь багшийн хөгжлийн сургалт (66.4%), холбогдох сургалтын материалуудын бэлэн байдал

3. Нөхцөл байдлын шинжилгээ: СУИС дахь ДИБ-ыг хэрэгжүүлэх өнөөгийн байдал

(69.7%), мөн төсөлд суурилсан эсвэл лекцийн хичээлийн хэлбэрээр хэрэгжүүлэх (68%) зэргийг чухалчилсан байна. Үүнээс гадна, 61.8% нь ДИБ-ыг бүх хөтөлбөрт үе шаттайгаар тусган хэрэгжүүлэх нь байгууллагын урт хугацааны зорилт байх ёстой гэж үзжээ (Зураг 3.4).



Зураг 3.4 СУИС-ийн багш нарын ДИБ-ыг сургалтад тусгахтай холбоотой хандлага

Дүгнэн хэлбэл, СУИС-ийн багш нар дэлхийн иргэний боловсролын (ДИБ) агуулгыг сургалтад нэвтрүүлэх үзэл санааны хувьд бэлэн, идэвхтэй оролцох сонирхолтой байгааг судалгаа харуулсан боловч нөөцийн хомсдол, бодлогын тодорхой бус байдал, гадаад хэлний чадамж зэрэг хүчин зүйлс хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа бол зорилтот сургалтын хөтөлбөрөөр эхлэх, сонгох болон төсөлд суурилсан хичээлүүдээр үе шаттайгаар хэрэгжүүлэх нь хамгийн тохиромжтой стратеги болох нь тодорхой байна. Ийнхүү шат дараатай хэрэгжүүлэх арга зам нь СУИС-д ДИБ-ыг нэвтрүүлэх дараагийн үе шатыг хэрэгжүүлэх суурийг тавьж, багшийн хөгжил, сургалтын шинэчлэл, байгууллагын бодлогын уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

3.4 СУИС-ийн стратеги ба нөхцөл байдлын үнэлгээ

СУИС-ийн ДИБ-ын үзэл баримтлалыг хөтөлбөрийн агуулгад нэвтрүүлэхтэй холбоотой бэлэн байдлыг SWOT шинжилгээний аргаар үнэлэв.

СУИС-ийн ирэх таван жилд хэрэгжүүлэхээр дэвшүүлээд буй стратегийн чиглэлүүд нь дэлхийн иргэнийг бэлтгэхэд чиглэсэн гэж хэлж болохоор байна. Дэвшүүлээд буй стратегийн үндсэн дөрвөн чиглэл болох (1) Чанартай боловсрол, (2) Нийгмийн сайн сайхны төлөөх судалгаа, (3) Хөгжлийн төлөөх нийгмийн хариуцлага, (4) Сайн засаглал ба дижитал шилжилт нь хүн төвтэй, нийгмийн оролцоотой, дэлхийн асуудлыг шийдвэрлэх боловсролын агуулгатай тохирч байна. Эдгээр стратегийн чиглэл бүр нь ДИБ-ыг байгууллагын болон хөтөлбөрийн түвшинд нэвтрүүлэх таатай нөхцөл байдлыг бүрдүүлж байна. Жишээлбэл, чанартай боловсрол нь суралцагч төвтэй сургалт ба хүртээмжтэй байдлыг, нийгмийн сайн сайхны төлөөх судалгаа нь нийгмийн хэрэгцээг шийдвэрлэхэд

чиглэсэн салбар дундын судалгааг, хөгжлийн төлөөх нийгмийн хариуцлага нь хамтын ажиллагаа болон ёс зүйн дадлыг, сайн засаглал ба дижитал шилжилт нь их сургуулийн удирдлага ба сургалтын тогтолцооны ил тод байдал, оролцоо ба инновацыг хөгжүүлэхэд түлхэц өгөхөөр байна.

Хөтөлбөрийг шинжилгээнээс харахад ДИБ-ын үзэл баримтлал СУИС-ийн өнөөгийн хөтөлбөрт тодорхой хэмжээнд туссан байна. Гэвч эдгээрийг тогтвортой, өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд байгууллагын бодлого, бүтэц, чадавхын түвшин чухал нөлөө үзүүлнэ. Иймд дараах хэсэгт СУИС-ийн дотоод давуу болон сул талууд, мөн дэлхийн иргэний боловсролыг хөгжүүлэхэд нөлөөлж буй гадаад орчны нөлөөллийг SWOT шинжилгээний хүрээнд нэгтгэн харуулав.

- **Давуу тал (Strengths).** СУИС-ийн хүн төвтэй боловсролын философи нь ДИБ-ын суурь зарчмуудтай онолын хувьд нийцэж, танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүй болон зан үйлийн чиглэлээр сургалтын үр дүнг цогцоор нь нэвтрүүлэх үндэс болж чадаж байна. Үндэсний үнэт зүйлсийг сургалтад тусган хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд, тэр дундаа “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс” төсөл (2013-2020) нь үзэл санааг сургалтанд хөрвүүлэх байгууллагын чадамж байгааг нотолж байна. Багш нарын хандлагын судалгааны дүнгээс харахад оролцогчдын 90%-иас дээш хувь нь ДИБ-тэй холбоотой чадваруудыг чухал хэмээн үзэж, энэрэх сэтгэл, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцол зэргийг төгсөгчдөд шаардлагатай тэргүүлэх чадварууд гэж тодорхойлсон байна. Мөн түүнчлэн, СУИС нь APCEIU, ЮНЕСКО-ийн харьяа Ази, Номхон далайн бүсийн Биет бус соёлын өвийн мэдээлэл, сүлжээний төв (ICHCAP) болон ЮНЕСКО-гийн бусад байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж буй нь ДИБ-ыг дэмжих гадаад сүлжээ, хамтын ажиллагаа сайн байгааг харуулж байна.
- **Сул тал (Weaknesses).** ДИБ-ын талаарх суурь ойлголт болон хөтөлбөрт нэвтрүүлэх асуудалд нээлттэй, эерэг хандлагатай байгаа хэдий ч ДИБ-ыг тодорхой илэрхийлсэн бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэх хүрээ, удирдлагын баримт бичиг хараахан бүрдээгүй байгаа нь хэрэгжилтийг тасалдуулах, ангид авч үзэх, богино хугацааны төслөөр хязгаарлагдахад хүргэх магадлалтай. Олон улсын сургалт болон чадавхжуулах үйл ажиллагаанд багш нарын оролцоо хязгаарлагдмал бөгөөд судалгаанд оролцогчдын ердөө 5.8% нь л ДИБ-тай холбоотой чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан, ДИБ-ын агуулгыг заах чадамжтай байна. Мөн гадаад хэлний бэрхшээл болон цахим сургалтын орчны дутмаг байдал нь багш, судлаачдыг олон улсын хамтын судалгаанд өргөнөөр оролцох боломжийг хумиж байна.
- **Боломжууд (Opportunities).** Монгол Улсын бодлогын баримт бичгүүд нь ДИБ-ыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд таатай нөхцөлийг бүрдүүлж байна. “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого нь дэлхийд өрсөлдөх чадвар, тогтвортой хөгжил, иргэний оролцоог боловсролын гол үр дүн гэж тодорхойлсон нь ДИБ-ын зарчимтай бүрэн нийцэж байна. ЮНЕСКО, APCEIU болон бусад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх нь багшийн чадавх, хөрөнгө оруулалтыг татах

3. Нөхцөл байдлын шинжилгээ: СУИС дахь ДИБ-ыг хэрэгжүүлэх өнөөгийн байдал

болон байгууллагын нэр хүндийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна. СУИС-ийн цахим шилжилтийн үйл явц нь ДИБ-ын агуулгыг цахим сургалтын хөтөлбөр, онлайн платформд байршуулж хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, орон нутгийн суралцагчдад хүртээмжийг нэмэгдүүлэх урьдач нөхцөл болж байна. Мөн оюутны идэвхтэй оролцоо болон бүтээлч, нийгэмд чиглэсэн, энх тайвны төлөөх санаачилгууд, байгаль орчны чиглэлийн сайн дурын ажил зэрэг төслүүд нь дэлхийн асуудлыг орон нутгийн нөхцөлтэй холбосон сургалтын эрэлт хэрэгцээ байгааг илтгэж байна.

- **Аюул, эрсдэл (Threats).**

- Дэлхийн иргэний боловсролыг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд саад болж болох хэд хэдэн нөхцөл байдал байна. Захиргааны түвшинд хариуцах чиг үүрэг болон санхүүгийн асуудал нь ДИБ-тай холбоотой санаачилгуудыг салангид, бүрэн бус хэрэгжих эсвэл удаашрах эрсдэлийг бий болгож болно. Багш, төгсөгчдийн гадагш чиглэсэн хөдөлгөөн (“тархи урсах”) нь байгууллагын дотоод чадавхыг бэхжүүлэх, залгамж чанарт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Үүнээс гадна, улсын боловсролын бодлого шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик (STEM) чиглэлд давамгайл төвлөрч байгаа нь соёл урлагт суурилсан боловсролын ач холбогдол болон дэлхийн иргэний үнэт зүйлсэд оруулах хувь нэмрийг орхигдуулах эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн, геополитикийн хуваагдал, худал мэдээллийн тархалт нь харилцан ойлголцол, яриа хэлэлцээр, энэрэх сэтгэл зэрэг ДИБ-ын тулгуур үнэт зүйлсийг сулруулах аюултай.

СУИС-д ДИБ-ын үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд нөлөөлөх эерэг ба сөрөг хүчин зүйлсийг нэгтгэн харвал дараах байдалтай болно (**Зураг 3.5**).

Давуу тал	Сул тал
• Хүн төвтэй боловсролын философи • Багш нар ДИБ талаар тодорхой хэмжээнд мэддэг, мотивац өндөр • Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс төслийн өв • Олон улсын идэвхтэй хамтын ажиллагаа	• ДИБ-ыг хэрэгжүүлэх тодорхой механизм дутдаг • ДИБ-ын агуулгыг сургалтдаа хэрэглэхэд • Хичээлүүдэд ДИБ-ын сэдвүүд туссан байдал жигд бус • Сургалтын материал болон гадаад хэлний мэдлэг дутмаг
Боломж	Аюул занал
• Монгол улсын урт хугацааны стратегийн баримт бичиг “Алсын хараа-2050”-тай уялдсан • UNESCO/APCEIU зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа • Дижитал шилжилт ба цахим сургалт • Оюутны иргэний болон бүтээлч оролцоо	• Бодлогоор дэмжих тэргүүлэх чиглэлийн өрсөлдөөн их • Санхүүгийн тогтвортой байдлын эрсдэл • Хүний нөөцийн хомсдол, багш нарын чадавхын хязгаарлалт • ШУТ (STEM)-д төвлөрсөн бодлогын орчин

Зураг 3.5 СУИС SWOT шинжилгээний гол үр дүн

SWOT шинжилгээний дүнгээс харахад СУИС нь дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэхэд үзэл санааны болон стратегийн хувьд таатай байр суурьтай байгаа ч бодит хэрэгжилтийн түвшинд байгууллагын тогтвортой төлөвлөлт, шийдлүүд шаардлагатай хэвээр байна. Тус сургуулийн үнэт зүйлс болон хамтын ажиллагааны суурь боломж нь чухал суурь болж байгаа боловч эдгээр чиг баримжааг бодлогын баримт бичиг, багшийн хөгжлийн хөтөлбөр, бүтцийн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах санаачилгуудыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

3.5 Нэгдсэн үр дүн ба хэрэгжилтийн байдал

Байгууллагын бодлого, бүтэц, сургалтын хөтөлбөрийн шинжилгээг багш нарын судалгааны дүнтэй уялдуулан хийсэн энэхүү нөхцөл байдлын шинжилгээ нь СУИС-ийн ДИБ-ыг хэрэгжүүлэх өнөөгийн бэлэн байдал болон цаашдын боломжийг бүх талаас нь авч үзсэн. Энэ бүлгийн гол үр дүнг үзэл санаа, зохион байгуулалт болон бодит хэрэгжилтийн хүрээнд дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна. Үүнд:

● Үзэл санааны болон үнэт зүйлийн хувьд нийцэл өндөр

СУИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн тэргүүлэх чиглэлүүд нь ДИБ-ын ёс суртахуун, хүмүүнлэг үнэт зүйлстэй нягт уялдаатай байна. Багш нар дэлхийн иргэний үнэт зүйл, зарчмыг өргөн хүрээнд ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа нь ДИБ-ыг хөтөлбөрийн түвшинд нэвтрүүлэх хамгийн чухал бодит байдал юм. Байгууллагын үнэт зүйл болон байгууллагын соёлын хэм хэмжээтэй уялдаж байгаа нь ДИБ-ыг академик болон хөтөлбөрөөс гадуурх бүх түвшний үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд тохиромжтой орчин бүрдсэн байгааг илтгэж байна.

● Бүтэц, зохион байгуулалтын бэлэн байдал дунд зэрэг

СУИС нь дэлхийн иргэний боловсролыг хэрэгжүүлэх байгууллагын суурийг бүрдүүлэх чиглэлд бодитой ахиц гаргаад байна. Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийн судалгаа ба үр дүнг түгээн дэлгэрүүлэх зэрэг амжилттай хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд нь ДИБ-ын зарчмуудыг сургалт, судалгаанд хэрхэн үр дүнтэй тусгаж болохыг харуулсан тод жишээ болж байна. Эдгээрт тулгуурлан СУИС нь ДИБ-тай холбоотой бодлогоо албан ёсны баримт бичгээр баталгаажуулах, хөтөлбөрийн уялдааг хангах механизмыг сайжруулах, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур тогтоох замаар байгууллагын тогтолцоогоо илүү боловсронгуй болгох шаардлагатай байна. Байгууллагын бүтцийн нэгжүүд, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог бэхжүүлж, хэрэгжилтийн тодорхой заавар, удирдамжуудыг гаргаснаар өмнөх санаачилгуудыг системийн хэмжээнд нэгтгэх боломж бүрдэнэ.

● Чадавхжуулах хэрэгцээ өндөр

Судалгааны үр дүнгээс үзэхэд, багш нар үзэл санааны хувьд ДИБ-ыг дэмжиж байгаа ч заах арга зүй болон байгууллагын түвшний дэмжлэгийн хувьд тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Иймээс ДИБ-ын сургалтын арга зүй, соёл хоорондын харилцаа, дэлхийн иргэний ур чадвар зэрэг чиглэлээр багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийг, ялангуяа сургагч багш бэлтгэх сургалтыг багшийн хөгжлийн тогтолцооны салшгүй хэсэг болгон хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнтэй зэрэгцэн хоёр хэлээр, Монголын нөхцөлд тохирсон сургалтын материалуудыг боловсруулах нь гадаад хэлний бэрхшээл, орчуулах дамжлагыг багасгаж, илүү олон багшийн идэвхтэй оролцоог дэмжих чухал алхам болно.

● Үе шаттай, уян хатан хэрэгжүүлэх замын зураглал


Одоогийн чадавх болон байгууллагын нөхцөл байдлыг харгалзан үзэхэд, дэлхийн иргэний боловсролыг үе шаттайгаар нэвтрүүлэх нь хамгийн оновчтой стратеги юм. Сонгон судлах хичээл, зэргийн бус хөтөлбөр, хөтөлбөрөөс гадуурх бүтээлч төслүүд зэрэг санаачилгуудыг шинэ арга зүйгээр турших лаборатори болгон ашиглаж болно. Үр дүнг тогтмол хянах болон оролцогч талуудын санал сэтгэгдлийг авах тогтолцоог бүрдүүлснээр эдгээр санаачилгуудын үр дүнг сургалтын үйл ажиллагаа болон байгууллагын соёлд аажмаар нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

● Нийгмийн ач холбогдол болон олон улсын нэр хүндийг нэмэгдүүлэх

ДИБ-ыг сургалт, судалгаандаа нэвтрүүлэх нь зөвхөн оюутнуудыг чадавхжуулаад зогсохгүй, СУИС нийгэмд болон олон улсын түвшинд манлайлах байр сууриа бататгах боломтой. ДИБ-д суурилсан хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар монголын соёл урлагийн боловсролын үр дүнг дэлхийд таниулах боломжийг бүрдүүлэн, энх тайван, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцлыг дэмжиж ирсэн монголын соёлын “зөөлөн хүч”-ийг бэхжүүлэх чухал алхам юм.

СУИС нь дэлхийн иргэний боловсролыг дэмжих эрмэлзэл болон хэрэгжүүлэх чадавхтай байна гэж дүгнэж болохоор байна. Харин байгууллагын хувьд тулгарч буй олон сорилт нь энэхүү үзэл санааны нийцлийг бодитоор хэрэгжүүлэхэд бодлогын түвшинд тусгах явдал билээ. Иймд, дараагийн бүлэгт олон улсын туршлага болон нөхцөл байдлын шинжилгээний үр дүнд үндэслэсэн СУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрүүд болон академик орчинд дэлхийн иргэний боловсролыг шат дараатайгаар хэрэгжүүлэх бодит арга зам, стратегийг танилцуулах болно.

4.2 Зарим хандлагыг хэрэгжүүлэх жишиг хичээлийн төлөвлөгөө



4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

Энэ бүлэгт СУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрт ДИБ-ын үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд байгууллагын нөхцөл байдал болон хүний нөөцийн чадавхад нийцсэн замын зураглалыг танилцуулна. Эхний хэсэгт ДИБ-ыг нэвтрүүлэх таван хандлагыг дэс дараалан авч үзсэн бөгөөд бие даасан магистрын хөтөлбөр шинээр нээх гэсэн том өөрчлөлтөөс илүү хэрэгжиж байгаа хөтөлбөр, хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаанууддаа ДИБ-ын агуулгыг тусгах гэх мэт жижиг алхамд төвлөрч байна. Таван хандлага тус бүрийг хууль эрх зүй, байгууллагын нөөц болон тогтвортой хэрэгжүүлэх боломж зэрэг өнцгөөс судалж үзэв. Хоёр дахь хэсэгт СУИС-ийн алсын хараатай уялдсан сургалтын агуулга, зорилго, үр дүнг тусгасан сургалтын хөтөлбөрүүдийн тодорхой жишээг санал болгосон. Эдгээр нь СУИС-д ахисан түвшний хөтөлбөрийн хүрээнд ДИБ-ыг үе шаттай, аажмаар, бодит нөхцөлд суурилсан загвараар хөгжүүлэхэд чиглэж байна.

4.1 СУИС-д ДИБ-ыг нэвтрүүлэх замын зураглал


СУИС дэлхийн иргэний боловсролыг түр зуурын төсөл бус, харин байгууллагын урт хугацааны зорилт гэж үзэж байна. 2-р бүлэгт танилцуулсан ДИБ-ыг нэвтрүүлэх таван хандлагыг нэгдлийн түвшин багаас их рүү чиглүүлсэн, үе шаттайгаар хэрэгжүүлэх цогц стратеги гэж хэлж болно. Нөгөө талаар энэ нь СУИС-ийн өнөөгийн чадавх болон 2025-2030 оны стратегийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаатай нийцэх юм. Замын зураглал пирамид хэлбэрийн бүтэцтэй бөгөөд олон тооны богино хугацааны санаачилгуудын суурин дээр илүү өргөн цар хүрээтэй шинэчлэл болж шат ахисаар бие даасан шинэ хөтөлбөр бий болгох зорилт руу чиглэнэ.

Хандлага тус бүрийг дэлгэрэнгүй тайлбарлахаас өмнө, энэхүү замын зураглал нь шугаман бус, харин үе шат бүрдээ ахиж өргөжих үйл явц гэдгийг онцлох нь зүйтэй. Богино хугацааны ажлууд нь суурь бэлтгэлийг хангаж, багш болон оюутнуудын сонирхлыг татах баримтуудыг бүрдүүлэхэд анхаарна. Дунд хугацааны ажлууд нь байгууллага дахь бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн уялдаа холбоог шийдвэрлэж, хамрах хүрээг өргөтгөнө. Харин урт хугацаандаа монголын соёл, нүүдэлчдийн өв уламжлалд тулгуурласан хөтөлбөрийг олон улсад санал болгох хүсэл эрмэлзлэл, итгэл үнэмшлийг бий болгоно.

СУИС-д ДИБ-ыг нэвтрүүлэх замын зураглал (Хүснэгт 4.1) нь шууд хэрэгжүүлэх боломжтой төслөөр эхэлнэ. Үүнд хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаа болох семинар, нийгмийн оролцоог дэмжих арга хэмжээ, оюутны клубуудыг багтаах бөгөөд эдгээр нь “суралцагчийн сонирхлын бүлэг”-ийг бүрдүүлж, хичээлийн чанарыг алдагдуулахгүйгээр ДИБ-ын агуулгыг одоо байгаа сургалтын төлөвлөгөөнд нэгтгэх бодит шийдэл гэж хэлж болно. Дунд

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

хугацаанд сургуулийн хэмжээнд “Нүүдэлчин өв ба дэлхийн ирээдүй” зэрэг нэртэй, ДИБ-д төвлөрсөн бие даасан хичээлийг туршиж үзэх боломжтой бөгөөд ингэснээр монголчуудын ертөнцийг үзэх үзэл ба дэлхийн иргэний боловсролын сэдвийг холбож, уян хатан суралцах боломж бүхий зэргийн бус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, алслагдсан бүсийн суралцагчдыг хамруулах нөхцөл бүрдэнэ. Урт хугацаанд СУИС, монголчуудын байгальтай зохицон амьдрах уламжлалд тулгуурласан “Урлаг, өв соёл, дэлхийн ирээдүй” гэх зэрэг урлаг, соёлын чиглэлийн магистрын шинэ хөтөлбөрийг олон улсын түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Гэхдээ энэ нь одоогоор санал төдий байгаа ч, өмнөх бүх алхмуудын зорьж буй гол чиглэл, алсын зорилгын илэрхийлэл юм.



Зураг 4.1 СУИС-т Дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх замын зураглал

Хандлага 1: Ахисан түвшний ДИБ-ын бие даасан хөтөлбөр нээх боломж, нөхцөл

СУИС-ийн ахисан түвшний сургалтын хөтөлбөрт бие даасан магистрын хөтөлбөр нээх хувилбар нь ДИБ-ыг нэгтгэх таван хандлага дундаас стратегийн хувьд хамгийн үр дүнтэй ч маш их зүйлийг шаардана. Олон улсын түвшинд ч ийм жишээ тун цөөн байдаг бөгөөд тэдгээрийн нэг нь Сөүлийн Үндэсний Их Сургуулийн ДИБ-ын тусгайлсан магистрын хөтөлбөр юм. Уг хөтөлбөр нь англи хэлээр заагддаг, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байдлаараа ялгардаг бөгөөд энэ нь олон улсын хамтын ажиллагаа ба нэр хүндийн үнэлэмжээрээ хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангаж байгаа жишээ гэж хэлж болно. СУИС-ийн хувьд, ийм хөтөлбөр нь хүний нөөцийн хөгжлийн үндэсний тэргүүлэх чиглэлүүдэд нийцэхийн зэрэгцээ, монголын соёл, урлагийн боловсролыг олон улсын

дээд боловсролын сүлжээнд холбох замаар сургуулийн академик нэр хүндийг дэлхийд нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой алхам болох юм.

- **Үндэсний бодлого ба хууль эрх зүйн орчин.** ДИБ-ын магистрын хөтөлбөрийг шинээр байгуулах нь Монгол улсын дээд боловсролын эрх зүйн зохицуулалттай нийцэх шаардлагатай. 2024 оны 3 дугаар сарын 20-ны А/146 дугаар тушаал болон 2025 оны 6 дугаар сарын 2-ны А/287 дугаар тушаалаар батлагдсан ахисан түвшний сургалтын чиглэл, хөтөлбөрийн нэр, индексийн жагсаалтыг батлах журмуудыг мөрдөнө. Одоогоор ДИБ нь албан ёсны хөтөлбөрийн бүртгэлд ороогүй тул СУИС шинэ хөтөлбөрийг бүртгүүлэх санал, тодорхойлолтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор мэдүүлэх шаардлагатай. Энэ нь Боловсролын ерөнхий хууль (2023)-д нийцүүлэн хөтөлбөрийг боловсруулах, чанарын баталгаажуулалтыг хангах ба Зөвшөөрлийн тухай хууль (2022)-ын дагуу байгууллага нь хүний нөөц, дэд бүтэц, санхүүжилт, сургалтын хөтөлбөрийн шаардлагыг хангаж, урьдчилан магадлан итгэмжлэгдэх ёстой.
- **СУИС-ийн чиг үүрэгт нийцэх.** СУИС-ийн нөхцөл байдлын шинжилгээ нь соёл судлал, олон улсын харилцаа, тогтвортой хөгжил болон соёл урлагийг хослуулсан салбар хоорондын сургалтын эрэлт өсөн нэмэгдэж буйг дурдсан. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрүүдэд Соёл судлалын орчин үеийн асуудлууд (C.CS704), Соёл хоорондын харилцааны онол ба арга зүй (C.CS704), Олон улсын харилцаа (C.CL708), Шинжлэх ухааны судалгааны арга зүй (S.RS701) зэрэг хичээлүүд төлөвлөгдсөн байдаг. Мөн ахисан түвшний оюутнуудтай хийсэн ярилцлагаас тэд олон улсын соёлын харилцаа, ёс зүйн төлөвшил, асуудал шийдвэрлэх чадвар зэрэг чадамжийг онцгой чухалчилдаг нь илэрсэн. Хэдийгээр эдгээрийг албан ёсоор ДИБ-ын хичээл гэж нэрлэдэггүй ч, тэдгээрийн агуулга ДИБ-ын суралцахуйн үр дүнтэй өндөр түвшинд давхцаж байна. Эндээс дэлхийд өрсөлдөх чадвар бүхий өргөн хүрээний боловсролын хэрэгцээ байна гэж хэлж болохоор байна.
- **Хөтөлбөр хөгжүүлэх ба магадлан итгэмжлүүлэх үе шат.** Шинэ хөтөлбөрийг нээх үйл явцыг таван үе шаттайгаар тоймлон харуулсан (Зураг 4.2).



Зураг 4.2 Магистрын хөтөлбөр боловсруулах үе шат

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

- **Бэлтгэл үе шат:** Хэрэгцээний судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, олон улсын туршлагын харьцуулалт (жишээлбэл, Сөүлийн Үндэсний Их Сургууль, ЮНЕСКО-ийн дэмжлэгт тэнхимийн хөтөлбөрүүд) болон байгууллагын чадварын үнэлгээ хийх.
- **Батлуулах үе шат:** Хөтөлбөрийн санал боловсруулах, салбарын хэлэлцүүлэг зохион байгуулах, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт илгээж, үндэсний индекс хөтөлбөрийн бүртгэлд оруулах.
- **Хууль эрх зүйн орчин бүрдэх:** “Дэлхийн иргэний боловсрол” нэршилтэй хөтөлбөрийн индексийг албан ёсны хөтөлбөрийн жагсаалтад батлуулах.
- **Зөвшөөрөл авах үе шат:** Боловсролын ерөнхий хууль болон Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагуудыг биелүүлж, урьдчилсан магадлан итгэмжлэлд хамрагдах.
- **Хэрэгжилтийн үе шат:** Олон улсын хамтын ажиллагааг (хамтарсан зэрэг олгох, хамтарсан судалгаа, оюутан солилцоо) өргөжүүлэх, нээлттэй цахим сургалтын (МООС) хэлбэрээр түгээх замаар хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх.

Энэхүү хандлагыг хэрэгжүүлэх нь Монгол Улсад хэрэгжих анхны ДИБ-ын ахисан түвшний бие даасан хөтөлбөр бий болохоос гадна дэлхийн хэмжээнд цөөн тооны жишээний нэг болно. Энэ нь “Энх тайван, хүний эрх, дэлхийн иргэншил болон тогтвортой хөгжлийн боловсролын тухай ЮНЕСКО-ийн 2023 оны зөвлөмж”-ийн хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэгтэй нийцэж, дэлхийд өрсөлдөх чадвартай иргэдийг бэлтгэхэд чиглэсэн үндэсний боловсролын шинэчлэлийг бэхжүүлэх ач холбогдолтой юм. СУИС-ийн хувьд, уг хөтөлбөр нь тус сургуулийг соёл, урлагийн боловсролын шинийг санаачлагч байгууллага болгон тодотгох бөгөөд оюутнуудад монголын нүүдэлчин соёлын өв ба дэлхийн иргэний үнэт зүйлсийг холбох, соёл хоорондын манлайлал, тогтвортой хөгжил, дэлхийн ёс зүйд мэргэшсэн төгсөгчдийг бэлтгэх шинэ боломжийг нээнэ.

4.1.2 Хандлага 2: Зэргийн бус хөтөлбөр хэрэгжүүлэх боломж

Микро-кредийн буюу зэргийн бус богино хугацааны хөтөлбөрүүд нь хэрэгжүүлэгч байгууллага болон суралцагч тэдгээрийн суралцахуйн уян хатан байдал, мэргэжлийн түвшинд ахиц дэвшил гарахад үнэ цэнэтэй ололт гэж хүлээн зөвшөөрсөн нөхцөлд л бодит ач холбогдлоо бий болгодог (OECD, 2021; UNESCO, 2021). СУИС-ийн бүтцийн сургуулиуд ДИБ-ын зэргийн бус хөтөлбөрүүдийг турших хамгийн тохиромжтой орчин гэж харж байна. Богино хугацааны мэргэжлийн сургалтуудыг хэрэгжүүлдэг туршлагадаа тулгуурлан уян хатан, шаталсан (stackable) сургалтын хөтөлбөр боловсруулах чадамж бүрэлдсэн. Суралцагч жишээ нь, “Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс ба дэлхийн иргэний чадамжууд” гэх мэт хичээлээр эхэлж, дараа нь нэмэлт модулиудад суралцан кредит цуглуулан, эцэст нь ахисан түвшний хөтөлбөрт элсэхдээ тооцуулж болно. Энэ шаталсан сургалт нь хүртээмжтэй, насан туршийн суралцахуйг дэмжих дээд боловсролын дэлхий дахины чиг хандлагатай уялдана (OECD, 2021; UNESCO, 2021).

Оролцогч талуудын ярилцлагаас одоо хэрэгжиж буй богино хугацааны сургалтууд гол төлөв зэрэг олгох хөтөлбөрүүдийн хичээлийн агуулгатай ижил байна. СУИС-ийн одоогийн хөтөлбөрийн суралцахуйн үр дүн нь танин мэдэхүйн (мэдлэг, онол, шинжилгээний) хүрээнд илүү тодорхойлогдож, академик ур чадварыг олгодог ч ДИБ-ын бусад хүрээний чадваруудыг тэнцвэртэйгээр олгох зарчмаар боловсруулах хэрэгтэй. Ингэснээр, өөрчлөлтөд чиглэсэн сургалт биш, зүгээр л богино лекцүүдийн цуглуулга болж хувирах эрсдэлээс сэргийлнэ.

Иймээс энэхүү замын зураглалд зэргийн бус хөтөлбөр бүрд төслийн шинжтэй даалгавар болон суралцахуйн үр дүнг хэмжих үйл ажиллагаа (жишээ нь, оюутнууд өөрсдөө семинар зохион байгуулах, төрөл бүрийн аян өрнүүлэх, энх тайвны клуб байгуулах гэх мэт)-г багтаах нь зүйтэй. Энэ нь нийгэм-сэтгэл зүйн болон зан үйлийн хүрээний суралцахуйн үр дүнг маш тодорхой болгож, суралцах үйл явцыг зөвхөн мэдлэгээр хязгаарлалгүй энэрэх сэтгэл, яриа хэлэлцээр, бодит үйлдлүүдэд чиглэнэ (Freire, 2000; Hooks, 1994).

Зураг 4.3-т СУИС-д мөрдөгддөг хөтөлбөр боловсруулах үйл явц – бэлтгэл хангах, төлөвлөх, хэрэгжүүлэх, чанарын баталгаажуулалт хийх болон тогтвортой байдлыг хангах үе шатуудыг зураглав. Энэ нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн загвар биш бөгөөд илүү бодит ажлын процессын загвар юм. Эдгээр үе шат тус бүрийн дэлгэрэнгүй ажлууд, орц ба гарцын жишээг 3-р хавсралтад багтаасан (зөвхөн монгол хувилбарт бий).



Зураг 4.3 Зэргийн бус хөтөлбөр боловсруулах үе шат

Өмнө дурдсан гурван хүрээний суралцахуйн үр дүнгийн тэнцвэргүй байдлыг шийдвэрлэхэд хөгжүүлэлтийн дарааллын үе шат бүрд нотолгооны шалгуур санал болгож байгаа ба энэ нь танин мэдэхүйн суралцахуйн үр дүнд төвлөрсөн байдлыг нийгэм-сэтгэл зүйн болон зан үйлийн суралцахуйн үр дүнтэй системтэйгээр уялдуулах зорилготой. Үе шат болгонд дараах анхаарах зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй. Үүнд:

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

- **Бэлтгэл үе шатанд:** Суралцагчийн хэрэгцээ нь зөвхөн мэдлэгийн зөрүү бус, энэрэх сэтгэл, бусдын байр суурийг ойлгох, иргэний оролцооны хэрэгцээ тусгагдсан эсэхийг тодруулна.

(Нотолгоо: нийгэм-сэтгэл зүйн ба зан үйлийн зорилготой холбогдсон хэрэгцээний судалгааны үзүүлэлтүүд)

- **Төлөвлөлтийн үе шатанд:** Хичээлийн суралцахуйн үр дүн (CLOs) болон үйл ажиллагаа нь ДИБ-ын гурван хүрээтэй уялдсан эсэх.

(Нотолгоо: багадаа нэг нийгэм-сэтгэл хөдлөлийн үр дүн, нэг зан үйлийн үр дүн агуулсан CLO зураглал; рубрикт хэлэлцээний чадвар ба үйлдлийг өрнүүлэх хичээлийн дизайныг хэмжих шалгуур тусгасан байх)

- **Хэрэгжилтийн үе шатанд:** Долоо хоног бүрийн сургалтын төлөвлөгөөнд зөвхөн уншиж ойлгохоор хязгаарлагдахгүй, яриа хэлэлцээр, бүтээлч үйл ажиллагаанд суурилсан оролцоо, мөн үйл явцыг загварчлах, боловсруулах алхам тусгагдсан эсэхийг шалгана.

(Нотолгоо: чиглүүлэх төлөвлөгөө, протокол, "Action Canvas" загвар г.м)

- **Чанарын баталгаажуулалтын үе шатанд:** Суралцагчдын үнэлгээ нь зөвхөн мэдлэг бус, хандлага болон оролцоо, санаачилга гаргах чадавхийн өөрчлөлтийг мөн тусган үнэлж байгаа эсэхийг шалгана.

(Нотолгоо: энэрэх сэтгэл ба оролцооны тухай өмнөх/дараах байдлын асуулга; багшийн тэмдэглэл)

- **Тогтвортой байдлын үе шатанд:** Хичээл дууссаны дараа оролцоо үргэлжлэх боломж (клуб байгуулах, түнш байгууллагатай холбогдох, уран бүтээлийг түгээх) тусгагдсан эсэхийг шалгана.

(Нотолгоо: төгсөгчдийн цахим шуудангийн жагсаалт, жижиг төсөл, тэтгэлэг, грантын зар, үр дүнг олон нийтэд танилцуулах цахим хуудас г.м)

Эдгээр шалгууруудыг системтэй болгох замаар, СУИС нь танин мэдэхүй давамгайлсан уламжлалт хөтөлбөрийг давтах эрсдэлийг бууруулж, ДИБ-ын богино хугацааны, зэргийн бус хөтөлбөрүүдийг өөрчлөлтөд чиглэсэн боловсролын бодит туршлага болгон төлөвшүүлэх боломжтой болно.

4.1.3 Хандлага 3: ДИБ-ын шинэ хичээл бий болгох

ДИБ-ын сэдэвт чиглэсэн бие даасан шинэ хичээл бий болгох нь шинэ хөтөлбөр нээхтэй харьцуулахад харьцангуй бага нөөцөөр дэлхийн иргэний боловсролыг ахисан түвшний сургалтын хөтөлбөрт тусгах боломжтой арга зам юм. Учир нь аль хэдийн батлагдсан нийтлэг журам болон сургуулийн дотоод дүрэм журмын хүрээнд хэрэгжих боломжтой. (Зураг 4.4 ба хавсралтын 3-р хүснэгтийг үз). Энэ хандлагыг амжилттай хэрэгжүүлэх үндэс нь алхам бүрийг баталгаажуулах бус, харин хичээлийн зорилго, нөөц, багш нарын бэлэн байдлыг хэр тодорхой төлөвлөж чадсанд оршино.



Зураг 4.4 Одоогийн сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөнд шинэ хичээл оруулах үе шат

СУИС-ийн хувьд энэхүү хандлага нь онцгой ач холбогдолтой. Учир нь гуравдугаар бүлэгт дурдсанчлан тус их сургууль нь монголчуудын нийтлэг үнэт зүйлсийг илрүүлэн тодорхойлох, бэхжүүлэхэд тууштай анхаарч ажилласан. Эдгээр үнэт зүйлсийг ДИБ-ын хичээлүүдэд шингээх нь СУИС нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх төдийгүй Монголын өв соёлыг дэлхийн иргэншлийн агуулгатай уялдуулан авч үзэх боломжийг нээнэ. Ингэснээр сургуулийн тодорхойлсон төгсөгчийн загварт туссан язгуур соёлын үнэлэмжтэй, ёс зүйтэй, шүүмжлэлт сэтгэлгээтэй, хамтын хариуцлагатай байдлаар дэлхийн хэмжээний сорилтуудыг шийдвэрлэхэд оролцох чадвартай мэргэжилтэн бэлдэнэ гэсэн санаа нь бодит болно. Энэхүү хандлагыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах нөхцөл, урьдчилсан бэлтгэлийг хангах шаардлагатай. Үүнд:

- ДИБ-ын сургалтын арга зүй болон салбар хоорондын заах арга барилын чиглэлээр багш нарыг чадавхжуулах;
- ЮНЕСКО-гийн тодорхойлсон ДИБ-ын гурван хүрээ (танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүй, зан үйл)-г монголчуудын үнэт зүйлсийн судалгаанд тулгуурлан уялдуулсан сургалтын материал боловсруулах;
- Эдгээр ДИБ-ын сэдэвт шинэ сонгох хичээлүүдийг ахисан түвшний оюутнууд төдийгүй, багш, ТББ-ын мэргэжилтэн, соёлын урлагийн ажилтнууд зэрэг насан туршийн боловсролын зорилго бүхий иргэдэд зориулан сурталчлах, хүртээмжийг нэмэгдүүлэх.

ДИБ-ын бие даасан хичээлүүд цар хүрээ жижиг мэт харагдаж болох ч, стратегийн хувьд чухал үүрэгтэй. Эдгээр хичээлүүдийг хэрэгжүүлэх нь зэргийн бус хөтөлбөр (2-р хандлага) болгон системчлэх, одоо байгаа сургалтын төлөвлөгөөг шинэчлэх(4-р хандлага), цаашлаад бие даасан шинжлэх ухааны салбар дундын хөтөлбөр (1-р хандлага)-ийн суурийг тавих ач холбогдолтой. Иймээс 3-р хандлага нь хэрэгжүүлэх бодит боломжтой ба урт хугацааны өөрчлөлтөд чиглэсэн чадамжийг хослуулж, монголчуудын үнэт зүйлсийг дэлхийн иргэншилтэй холбон соёлын болон нийгмийн шинэчлэлд хувь нэмэр оруулах СУИС-ийн эрхэм зорилготой холбогдож чадна.

4.1.4 Хандлага 4: Одоо байгаа хичээлийн агуулгад ДИБ-ыг тусгах


Судалсан таван хандлагаас харахад одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах нь хамгийн шуурхай бөгөөд бага зардалтай хувилбар юм. СУИС-д зааж буй хичээлүүдэд тулгуурлан ахисан түвшний хөтөлбөрийг аажмаар шинэчлэхэд чиглэнэ. Ер нь зааж буй хичээлийн төлөвлөгөө, агуулгад нэмэлт өөрчлөлт оруулах нь тэнхимийн түвшинд хэлэлцэгддэг тул бүрэн хэмжээний хөтөлбөрийн шинэчлэлээс илүү уян хатан, түргэн хэрэгжих боломжтой бөгөөд байгууллагын хэмжээнд том ачаалал үүсгэхгүй.

Одоогийн байдлаар СУИС-ийн ерөнхий суурь хичээлүүд (жишээлбэл, “Шинжлэх ухааны судалгааны арга зүй”, “Оюуны өмчийн эрх зүй” гэх мэт) нь танин мэдэхүйн хүрээний үр дүнг голчилдог. Судалгаа хийх, онолын мэдлэгийг хөгжүүлэхэд үр дүнтэй ч нийгэм-сэтгэл зүйн болон зан үйлийн хүрээний суралцахуйн үр дүнг орхигдуулах талтай байгаа нь сорилт ч гэлээ нөгөө талаас боломж юм. ДИБ-ын агуулгыг хичээлийн агуулгад тусгах нь багш нарт заадаг хичээлийнхээ суралцахуйн үр дүнгийн тэнцвэрт байдлыг эргэн харж, мэдлэг дамжуулахаас өргөн хүрээнд сэтгэх боломжийг олгоно.

Энэхүү хандлага нь багш нарт дараах гурван чиглэлээр ач холбогдолтой. Үүнд:

- **Суралцахуйн хүрээний тэнцвэртэй байдал:** Суралцахуйн үр дүн (CLOs)-г дахин хянаж, энэрэх сэтгэл, соёл хоорондын харилцан яриа, иргэний оролцоог танин мэдэхүйн ур чадвартай хамтад нь авч үзэх.
- **Өөрчлөлтөд чиглэсэн сургалтын арга зүй:** Яриа хэлэлцээр, төсөлд суурилсан сургалт, дүрд тоглох, бүтээлчээр сэтгэх аргуудыг нэгтгэн, суралцагч төвтэй, идэвхтэй сургалтын орчин бүрдүүлэх.
- **Үе шаттайгаар хэрэгжүүлэх боломж:** Хичээлийг бүхэлд нь өөрчлөхөөс өмнө унших материал, кейс судалгаа, даалгавар зэрэг хэсэгчилсэн шинэчлэлээс эхлэх замаар багш нарт ачаалал багатай, бололцоондоо тохируулан нэвтрүүлэх боломж олгох.

ДИБ-ын агуулгыг тусгах үйл явц нь СУИС-ийн хичээлийн агуулгыг сайжруулах процесс (бэлтгэл → баталгаажуулалт/зөвшөөрөл → хэрэгжилт ба чанарын баталгаажуулалт)-оор хэрэгжинэ (Зураг 4.5). Энэ нь багш нарт ДИБ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийг хичээлдээ үе шаттайгаар нэвтрүүлэх, үр дүнг хянах, заах арга барилаа сайжруулах боломжийг олгоно.



Зураг 4.5 Одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах явц

4.1.5 Хандлага 5: ДИБ-ыг хичээлээс гадуурх сургалт, арга хэмжээгээр дамжуулан нэвтрүүлэх

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь ДИБ-ыг туршлагад суурилсан, оролцоонд чиглэсэн, идэвхтэй сургалтын арга хэлбэрээр албан сургалтыг дэмжих үр нөлөөтэй хэлбэр юм. Албан сургалтын танин мэдэхүйд хэт чиглэсэн хандлагыг тэнцвэржүүлж, нийгэм-сэтгэл зүйн болон зан үйлийн зорилтуудаар суралцахуйн үр дүнг өргөжүүлж, ДИБ-ын зарчмуудыг их сургуулийн өдөр тутмын амьдралд уялдуулан ойлгуулна.

СУИС-т энэ хандлагыг хэрэгжүүлэх суурь тавигдсан гэж үзэж болно. Оюутны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд төрөл бүрийн уралдаан наадам, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанууд, соёлын үнэт зүйлсийг нийгмийн хариуцлагатай холбосон оюутны клубуудыг дэмжих зэрэг олон чиглэлийн ажлууд багтсан байдаг. Энэхүү туршлагадаа тулгуурлан ДИБ-ыг дараах хэлбэрээр нэвтрүүлэх боломжтой. Үүнд:

- ДИБ-ын сэдэвт цуврал лекц ба сэдэвчилсэн долоо хоногууд. Жишээлбэл, энх тайван, тогтвортой хөгжил, соёл хоорондын ойлголцлын талаар илтгэгч урих, соёлын ажилтнууд ба оюутнуудын дунд хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулах байж болно. БНСУ-ын их дээд сургуулиудад APCEIU-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг энд дурдаж болно.
- Оюутны манлайлалтай нөлөөллийн төслүүд. ЮНЕСКО-гийн идэвхтэй сургалтын арга зүйгээр, ДИБ-ын үзэл баримтлалаар соёл, нийгмийн асуудлуудыг бодитойгоор шийдвэрлэх жижиг төслүүдийг ахисан түвшний оюутнууд хэрэгжүүлэхэд дэмжиж болно.
- Бүтээлч үйл ажиллагаанд суурилсан нийгмийн оролцооны төслүүд. Тайзны урлаг, дүрслэх урлаг, медиа зэргийг ашиглан энэрэх сэтгэл, хүчирхийллийн эсрэг, оролцоог нэмэгдүүлэх зорилготой үйл ажиллагаануудыг зохион байгуулж болох ба СУИС-ийн мэргэжлийн онцлогийн давуу талыг бүрэн илэрхийлнэ.


4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

- ТББ болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа. Сургалтын цар хүрээг тэлж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 4.7-тэй нийцсэн хөгжлийн хөтөлбөрийн санаачилгыг өрнүүлэх гэх мэт болно.

Энэ хандлагыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэл нь Боловсролын ерөнхий хууль (2023а, шинэчилсэн найруулга)-д албан бус болон насан туршийн боловсролыг боловсролын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох тухай (7.1–7.4 дэх зүйл) болон оюутны сайн дурын болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцох тухай (10.1 дэх зүйл) тодорхой заасан. СУИС-ийн дүрэм, журамд ч ахисан түвшний оюутнуудыг сургалт ба сургуулийн хүрээний нийгэмд чиглэсэн ажилд туслуулах асуудлыг зохицуулсан байдаг нь ДИБ-ын хөтөлбөрийн бус үйл ажиллагаанд тулгардаг хүний нөөцийн хомсдолын асуудлыг шийдвэрлэх бодит арга зам болох боломжтой. Туслах оюутнууд багшийн удирдлага дор зохион байгуулагч, хөтөлбөрийн зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх боломжтой.

Дөрвөн шатлалт процессоор хэрэгжүүлэх боломжтой (Зураг 4.6). Үүнд:

- Бэлтгэл.** Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба багш, оюутнууд хамтран үйл ажиллагааны загварыг гаргана.
- Албажуулалт.** Үйл ажиллагааг албан ёсны оюутны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах.
- Хэрэгжилт.** Хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон түншлэлийг бий болгох.
- Чанарын баталгаажуулалт.** Хяналт-шинжилгээ, үнэлгээ, сайжруулалтыг тогтворжуулах.



Зураг 4.6 ДИБ-ыг хөтөлбөрийн бус сургалт, арга хэмжээгээр дамжуулан нэвтрүүлэх явц

Нэгтгэн дүгнэвэл 5-р хандлага нь СУИС-д хэрэгжүүлэх бүрэн боломжтой, бодит шийдэл юм. Хэдийгээр энэхүү арга зүй нь албан ёсны зэрэг олгох хөтөлбөр эсвэл бие даасан хичээлүүд бий болгохтой харьцуулахад сургалтын нийцлийн түвшин багатай ч, одоо байгаа бүтэц, нөөцийг үр дүнтэй ашиглаж, харьцангуй бага хөрөнгө оруулалт шаардах

ба олон чиглэл, мэргэжлийн оюутнуудыг хамруулснаар хүртээмжийг нэмэгдүүлэх давуу талтай. Иймээс энэ хандлага нь ДИБ-ын үзэл баримтлалыг их сургуулийн хэмжээнд нэвтрүүлэх богино хугацаанд хэрэгжүүлж болохуйц шийдэл байхын зэрэгцээ, урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх нэг арга зам болж чадна.

4.2. Зарим хандлагыг хэрэгжүүлэх хичээлийн жишиг төлөвлөгөө

Өмнөх хэсэгт бид ДИБ-ыг ахисан түвшний сургалтад нэвтрүүлэхэд хэрэглэж болох таван хандлагыг нэг бүрчлэн авч үзсэн. Бие даасан хөтөлбөр боловсруулахаас эхлээд хичээлээс гадуурх санаачилга хэрэгжүүлэх хүртэл судалж, бодлого, эрх зүйн зохицуулалт, урт хугацааны зорилтуудын хүрээнд хэрэгжих боломжийг үнэлсэн. Гэхдээ, эдгээр хандлагууд ангид, оюутны суралцахуйн түвшинд бодитоор хэрхэн буух вэ? гэдэг асуулттай тулгарч байна.

Энэ хэсэгт дээрх асуултад хариулах зорилгоор хичээлийн жишиг төлөвлөгөөнүүдийг танилцуулж байна. Эдгээр нь APCEIU-ээс гаргасан “Сургалтын ерөнхий хөтөлбөрийн гарын авлага (Common Curriculum Guide)” (2023b) -аас жишээ аван боловсруулагдсан бөгөөд багш, сургалтын төлөвлөгөө боловсруулагчдад зориулсан жишиг загвар юм.

Зорилго нь хатуу тодорхой хичээлийн загвар санал болгох бус, харин ДИБ-ын гурван хүрээ (танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүйн, зан үйлийн)-г хичээлийн зорилго, долоо хоногийн сэдэв, сургалтын арга зүй, үнэлгээний системд хэрхэн тусгаж болохыг харуулахад оршино.

ДИБ-ыг шинээр хөгжүүлэх (жишээ нь, шинэ зэргийн бус хөтөлбөр) болон сайжруулах (зарим нэг агуулгаар баяжуулах гэх зэрэг), хичээлээс гадуурх санаачилгыг хэрэгжүүлэх эдгээр жишиг саналууд нь онол, практикийг холбох чухал албах болно. Цаашилбал, нүүдэлчдийн хамтдаа амьдрах соёл, соёлын өвийг хамгаалах, соёл хоорондын харилцаа зэрэг монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг дэлхийн иргэний чадамжуудтай холбох боломжийг тодотгож өгнө. Иймээс дараах хэсгүүдэд гурван хандлагын хүрээнд боловсруулсан хичээлийн жишиг төлөвлөгөөг танилцуулна. Үүнд:

- Зэргийн бус хөтөлбөр (2-р хандлага)
- Байгаа хичээлд ДИБ-ын агуулгыг тусгасан загвар (4-р хандлага)
- Хичээлээс гадуурх санаачилга (5-р хандлага)

Эдгээр жишээ нь бодлогын нийцэл болон хэрэгжилтийн судалгааг бодит сургалтын төлөвлөгөөнд хөрвүүлэхэд бодит баримжаа болж, ДИБ-ыг нэвтрүүлэх процессыг зөвхөн СУИС төдийгүй Монголын бусад дээд боловсролын байгууллагуудын хувьд хэрэгжихүйц алхам болгон тодорхойлох боломжийг нээнэ.

4.2.1 Хандлага 2-ын хичээлийн жишиг төлөвлөгөө: Зэргийн бус хөтөлбөр

Энд танилцуулж буй зэргийн бус хөтөлбөрийн хичээл нь 4.1-т тайлбарласан замын зураглалд тулгуурласан болно. Өмнө дурдсанчлан СУИС-ийн богино хугацааны сургалтууд ихэвчлэн зэрэг олгох хөтөлбөрийн хичээлийн агуулгатай давхцал өндөр тул танин мэдэхүйн хүрээнд хэт төвлөрөх хандлагатай байдаг. Энэ тэнцвэргүй байдлыг засах үүднээс энэхүү жишиг хөтөлбөр нь ДИБ-ын гурван хүрээг (танин мэдэхүй, сэтгэл-зүй, үйл хөдлөл) бүрэн хамруулж, оролцогчид сургалтын төгсгөлд бодит үйл ажиллагаа бүхий манлайллын төсөл хэрэгжүүлэхээр загварчлагдсан. Нэг сарын хугацаатай (3 кредит) энэхүү хичээл нь APCEIU (2023b)-ийн Сургалтын ерөнхий хөтөлбөрийн гарын авлагыг баримталсан болно.

Хүснэгт 4.1 Зэргийн бус хөтөлбөрийн хичээлийн төлөвлөгөө

Хичээлийн нэр	Дэлхийн иргэн байх нь: Манлайлал ба оролцооны ур чадвар			
Кредит цаг	3 кредит (45 цаг танхим ба 90 цаг бие даан суралцах)			
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү нэг сарын эрчимжүүлсэн хичээл нь дэлхийн иргэн гэх ойлголтыг бодит туршлага хэлбэрээр судлахад чиглэнэ. Яриа хэлэлцээр, бүтээлч арга барил, төсөлд суурилсан сургалтын тусламжтайгаар оролцогчид олон соёлын орчинд манлайлах, оролцох, үйлдэл хийх ур чадвараа хөгжүүлнэ. Хичээл нь монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг дэлхийн сорилттой холбох өөрчлөлтөд чиглэсэн манлайлалд төвлөрч, суралцагчдыг төсөөллөөс бодитоор нөлөөлөх чадварт шилжих замаар чадавхжуулна.			
Хичээлийн зорилго	Хичээлийн төгсгөлд суралцагч дараах үр дүнд хүрнэ: 1. Танин мэдэхүй: ДИБ-ын гол онол, хүрээг тодорхойлж, дээд боловсрол болон соёлын салбар дахь манлайлал, түүний ач холбогдлыг тайлбарлах. 2. Нийгэм-сэтгэл зүй: Оролцоонд суурилсан дасгалуудаар энэрэх сэтгэл, яриа хэлэлцээр, соёл хоорондын харилцааны чадварыг бататгана. 3. Зан үйл: Манлайллын ур чадвараа ашиглан жижиг хэмжээний ДИБ-ын үйл ажиллагааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэх			
Долоо хоногийн сэдэв ба үйл ажиллагаа	Долоо хоног	Сэдэв	Суралцахуйн үйл ажиллагаа	Голлох ДИБ-ын хүрээ
	1	Дэлхийн иргэн болох нь	Лекц, хэлэлцүүлэг: “ДИБ гэж юу вэ?” — Хэлэлцүүлгийн сэдэв: “Би дэлхий болон өөрийн нийгэмдээ хэн бэ?”	Танин мэдэхүй + Нийгэм-сэтгэл зүйн
	2	Манлайлал ба оролцооны ур чадвар	“Дарлагдагсдын театр” сургалт, түүх өгүүлэх болон энэрэх сэтгэл төлөвшүүлэх дасгалууд	Нийгэм-сэтгэл зүйн
	3	Ухамсраас үйлдэл рүү	Энх тайвны клуб, бүтээлч ажлууд, уур амьсгалын үйл ажиллагааны кейс судалгаа; багийн төсөл боловсруулах	Танин мэдэхүй + Зан үйл
	4	Бодит үйлдэл	Багийн төслүүдийг танилцуулах; эсээ; санал асуулга, үнэлгээ	Зан үйл + Нийгэм-сэтгэл зүйн

Сургалтын арга зүй	• Хэлэлцүүлэгт суурилсан интерактив лекцүүд • Бүтээлч аргууд (театр, түүх өгүүлэх, бүтээлч илэрхийлэл) • Хамтран суралцах, багийн ажил • Нийгэмд чиглэсэн төсөлд суурилсан сургалт
Үнэлгээ	• Эсээ – 20% • Идэвх оролцоо – 20% • Төсөл – 60%: санаачилга эсвэл үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, танилцуулах (жишээ нь, бүтээлч ажил, сургалт, клуб, нийгмийн санаачилгууд).
Тэмдэглэл	Төслүүд нь хөтөлбөрийн бус оролцооны хэлбэртэй (4.3.3-р хэсгийг үз). Оюутнуудыг энэхүү төслийн ажлаа энх тайвны клуб, бүлгийн хэлэлцүүлэг, бүтээлч аян, хичээлийн дараах нөлөөллийг ажлуудыг үргэлжлүүлэхийг уриална.

Дээрх жишиг хичээл нь ДИБ-ыг зэргийн бус кредитийн сургалтыг богино хугацаанд хэрэгжүүлэх үр дүнтэй загвар юм. Хөтөлбөр нь ДИБ-ын гурван хүрээ (танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүй, зан үйл)-г бүрэн хамарч, суралцагчдыг төслөө амжилттай хэрэгжүүлэхэд чиглүүлнэ. Гэвч ДИБ-ыг СУИС-ийн хэмжээнд хэрэгжүүлэхэд шинэ хичээл бий болгох нь хангалтгүй тул дараагийн хэсэгт одоогийн хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах боломжийг танилцуулна.

4.2.2 Хандлага 4. Хичээлийн жишиг төлөвлөгөө: Одоогийн хичээлүүдэд ДИБ-ыг агуулгыг тусгах

4-р хандлагын жишиг хичээлүүд нь ДИБ-ыг одоо хэрэгжиж буй ахисан түвшний хичээлүүдийн агуулгад тусгах боломжийг харуулж байна. Дэлхийн иргэний боловсрол нь нэмэлт сэдэв бус, сэдвийн хүрээнд оюутны мэдлэг, чадвар, хандлагын төлөвшүүлэх салшгүй хэсэг болно. Жишиг төлөвлөгөө нь олон жилийн туршид тогтвортой хэрэгжсэн хичээлүүдийг ч шинээр загварчилж, соёл хоорондын ойлголцол, нийгмийн оролцоо, монгол ёс заншил, үнэт зүйлстэй тэнцвэртэй хослуулах боломжтойг харуулж байна (Хүснэгт 4.2).

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

Хүснэгт 4.2 ДИБ-ын агуулгыг тусгасан хичээлийн жишиг төлөвлөгөө

Хичээлийн нэр	Соёл хоорондын харилцааны онол ба арга зүй – ДИБ-ын агуулгыг тусгасан хувилбар			
Кредит цаг	3 кредит (48 цаг танхим, 96 бие даасан суралцах цаг) нийт 12 долоо хоног			
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү ахисан түвшний хичээл нь соёл хоорондын харилцааны онол, арга зүйг судлахын зэрэгцээ ДИБ-ын танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүйн болон зан үйлийн хүрээтэй уялдуулна. Суралцагчид соёлын үнэт зүйлсэд суурилсан харилцааг судалж, үүнд монголчуудын зочломтгой зан, нүүдэлчдийн хамтдаа оршихуйн соёл, байгальтай хүндэтгэлтэй харилцах уламжлал зэрэг ойлголтыг олон улсын онол, практик хандлагатай харьцуулан судална. Хичээл нь соёл хоорондын харилцан ойлголцол, ёс зүйн хариуцлага, мөн орчин үеийн дэлхийн сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн ур чадварыг хөгжүүлэхэд онцгойлон анхаарна.			
Хичээлийн зорилго	Хичээлийн төгсгөлд суралцагч дараах үр дүнд хүрнэ: 1. Танин мэдэхүй: Соёл хоорондын харилцааны гол онолуудыг тайлбарлаж, тэдгээрийг дэлхийн болон монголын соёл хоорондын харилцаа, хамтдаа оршихуйн уламжлалтай уялдуулан судлах. 2. Нийгэм-сэтгэл зүй: Монголчуудын зочломтгой зан, эв нэгдэл, ялгаатай байдлыг хүндэтгэх уламжлалыг судалж, энэрэнгүй, хүлээцтэй хандлагыг төлөвшүүлэх. 3. Зан үйл: Бодит болон загварчилсан орчинд соёл хоорондын ойлголцлын ур чадвараа ашиглан, монголын соёлын үнэт зүйлд тулгуурласан шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх.			
Долоо хоногийн сэдэв ба үйл ажиллагаа	Долоо хоног	Сэдэв	Суралцахуйн үйл ажиллагаа	Голлох ДИБ-ын хүрээ
	1	Соёл ба харилцаа	Соёл хоорондын харилцааны танилцуулах лекц: “Миний итгэл үнэмшил ба соёл” хэлэлцүүлэг	Танин мэдэхүй + Нийгэм-сэтгэл зүйн
	2	Соёлын таван хэмжээс (Хофстеде, Холл)	Бүлгээр кейс судалгаанд дүн шинжилгээ хийх; Монгол ба дэлхийн соёлын орчныг харьцуулсан зураглах	Танин мэдэхүй
	3	Соёл хоорондын харилцааны суурь хүчин зүйлс	Мета-онолын семинар; соёлын хэвшмэл ойлголтын талаар хэлэлцэх	Танин мэдэхүй + Нийгэм-сэтгэл зүйн
	4	Өөр соёлын орчинд дасан зохицох	Соёлын шок ба дасан зохицох сэдвээр тоглоомын аргаар суралцах; шүүмж бичих	Нийгэм-сэтгэл зүйн
	5	Соёлын системүүдийн харьцуулсан судалгаа	Мэтгэлцээний сэдэв: “Харилцаа ба соёлын хэв маяг— дижитал эрин үеийн сорилт”	Танин мэдэхүй + Зан үйлийн
	6	Аман болон аман бус харилцаа	Ярианы өнгө аяс ба ойлголцол; дохио зангаа, биеийн хэлэмж; буруу ойлголцлын жишээ судлах	Танин мэдэхүй + Нийгэм-сэтгэл зүйн

Долоо хоногийн сэдэв ба үйл ажиллагаа	7	Соёл хоорондын бизнесийн харилцаа	Соёл хоорондын хэлэлцээр ба зөрчлийг шийдвэрлэхэд суурилсан тоглоомын дасгал	Зан үйлийн
	8	Хэлэлцэл ба Азийн харилцааны философи	Хэлэлцээрийн онолын семинар; шүүмж бичих даалгавар “Дэлхийн иргэний хувиар сонсох нь”	Нийгэм-сэтгэл зүйн
	9	Соёл хоорондын харилцааны судалгаа	Судалгааны арга зүйн лекц; дэлхийн тулгамдсан асуудлыг хөндсөн жижиг судалгааны санал боловсруулах	Танин мэдэхүй + Зан үйлийн
	10	Соёл хоорондын харилцаа ба дэлхийн асуудлууд	Цагаачлал, уур амьсгалын өөрчлөлт, эв нэгдэл сэдвээр кейс судалгаа; байгальтай зохицон амьдрах Монгол уламжлалтай холбох	Бүх гурван чиглэл
	11	Оюутны удирдсан семинарууд	Багаар ажиллан соёл хоорондын харилцааны хэлэлцүүлэг, үйл ажиллагааг зохион байгуулах	Зан үйлийн + Нийгэм-сэтгэл зүйн
	12	Төслийн үр дүнгийн хэлэлцүүлэг	Төслүүдийг танилцуулах; хамтын үнэлгээ хийх; соёл хоорондын харилцаанд хэрхэн суралцсан эргэцүүлэл бичих	Нийгэм-сэтгэл зүйн + Зан үйлийн
Сургалтын арга зүй	• Хэлэлцүүлэг бүхий интерактив лекц, семинар • Кейс судалгаа ба мэтгэлцээн • Тоглоомын арга ба нөхцөл байдлын симуляци • Оюутны удирдсан семинар, сургалт • Бичгийн даалгавар, тэмдэглэл			
Үнэлгээ	• Идэвх оролцоо ба тэмдэглэл – 20% • Бие даалт: Соёл хоорондын харилцааны харьцуулсан судалгаа – 20% • Багийн төсөл: Соёл хоорондын харилцааны талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, сургалт зохион байгуулах – 30% • Төсөл: ДИБ-ын чиглэлээр судалгааны санал боловсруулах – 30%			
Тэмдэглэл	Төслүүд нь хөтөлбөрийн бүс оролцооны эхлэл хэлбэртэй (4.3.3-р хэсгийг үз). Оюутнуудыг энэхүү төслийн ажлаа энх тайвны клуб, хэлэлцүүлгийн бүлэг, бүтээлч аян болгон өргөжүүлж, хичээлийн дараах бодит нөлөөллийг үргэлжлүүлэхийг уриална.			

ДИБ-ын агуулгыг одоогийн хичээлүүдэд тусгах нь дэлхийн иргэний боловсролыг оюутны мэргэжлийн болон зан төлөвшлийн салшгүй хэсэг болгох нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ нь анги танхимыг үндэсний өв соёл дэлхийн түвшний асуудлуудыг шийдвэрлэхэд тохиорсон орчин болгон хувиргаж, оюутнуудыг дотоодын болон олон улсын түвшинд хариуцлагатай оролцох чадвартай болгож бэлдэнэ. Гэвч энэхүү уялдаа нь зөвхөн хичээлийн орчинд хязгаарлагдвал тогтвортой үргэлжлэх боломгүй болох эрсдэлтэй. ДИБ нь бодит үр дүн, хамтын оролцоо, бүтээлч санаачилгаар дамжин тогтвортой үргэлжилнэ. Тиймээс дараагийн хэсэгт хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаагаар ДИБ-ын чадамжийг бодитоор хэрэгжүүлэх боломжуудыг танилцуулна.

4.2.3 Хандлага 5. Жишиг төлөвлөгөө: Хөтөлбөрийн бус үйл ажиллагаа

Өмнөх жишээнүүд нь ДИБ-ыг кредит олгох зэргийн бус хөтөлбөрөөр болон одоогийн ахисан түвшний хичээлд тусгах хэлбэрээр туршин хэрэгжүүлэх боломжтойг харуулсан. Гэвч эдгээр хувилбаруудын үр нөлөөг урт хугацаанд авч явахад оюутны төсөл, хэлэлцүүлгийг танхимын сургалтаас давж сэтгэх шаардлагатай. Хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаа нь энэхүү залгамж холбоог бүрдүүлж, даалгаврын хүрээнд төслийн санаагаа хэрэгжихүйц болгон хөгжүүлэх, соёл хоорондын яриа хэлэлцээрийг бодит болгон хэрэгжүүлэх, оюутнууд ДИБ-ын үнэт зүйлийг өдөр тутмын сургуулийн амьдралд хэвшүүлэх орон зайг бүрдүүлж өгнө.

Энэ чиглэл нь СУИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилийг “Сургалтын хөтөлбөрийн олон талт хэлбэрийг дэмжих жил” болгон зарласан бодлоготой шууд уялдаж байна. Сургуулиас зохион байгуулдаг соёлын наадам, нийгэмд чиглэсэн санаачилгууд, оюутны клубүүдийн үйл ажиллагаа зэрэг нь аль хэдийн олон талт сургалтын хэлбэрийг бүрдүүлж байгаа бөгөөд эдгээрийг Сургалтын ерөнхий хөтөлбөрийн гарын авлага (APCEIU, 2023b)-ын үзэл санаатай уялдуулснаар илүү тодорхой, ДИБ-ын гурван хүрээтэй нийцлийг хангаж, төгсөлтийн баримт бичигт баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Мөн энэхүү жишиг төлөвлөгөө (Хүснэгт 4.3) нь зэргийн бус хөтөлбөрийн хичээл, шинэ болон агуулга шинэчилсэн хичээлүүдтэй уялдах байдлаар боловсруулагдана.

Жишээлбэл, “Дэлхийн иргэн байх нь” (Хүснэгт 4.1) хичээлийг судалсан оюутнууд өөрсдийн төслөө клуб, бүтээлч ажил хэлбэрээр хэрэгжүүлэх бол, “Соёл хоорондын харилцаа” (Хүснэгт 4.2) хичээлийг судалсан оюутнууд хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөө, судалгааны саналаа нийгмийн орчинд бодитоор турших боломж олгоно. Ийнхүү хөтөлбөрөөс гадуурх сургалт нь академик мэдлэг, манлайллын чадвар, нийгмийн оролцоог холбосон гүүр болох боломжтой юм.

Хүснэгт 4.3 Хичээлээс гадуурх үйл ажиллагааны жишиг төлөвлөгөө

Хичээлийн нэр	Дэлхийн шударга ёсны төлөөх урлаг
Хугацаа	6 долоо хоног (долоо хоногт 2 цаг, төслийн ажил)
Хичээлийн тодорхойлолт	Энэхүү хөтөлбөр нь урлаг ба соёлын оролцоогоор дамжуулан дэлхийн иргэний боловсролыг дадлага ажлаар олгох зорилготой. Зургаан долоо хоног үргэлжлэх энэхүү кредит тооцохгүй цуврал сургалт нь оролцоонд суурилсан суралцах арга барил, бүтээлч сэтгэлгээ, оюутны санаачилгыг дэмжинэ. Суралцагчид энх тайван, тогтвортой хөгжил, соёл хоорондын яриа зэрэг дэлхийн асуудлууд нь монголын соёлын үнэт зүйлстэй хэрхэн уялддагийг судална. Ахисан түвшний оюутнууд болон багшийн туслах оюутнууд сургалтын явцыг удирдаж, төслийн загварыг боловсруулахад чиглүүлж өгч болно. Хөтөлбөр нь оюутнуудын санаачлан зохион байгуулах үзэсгэлэн/ тайлангийн арга хэмжээгээр өндөрлөх бөгөөд олж эзэмшсэн мэдлэгээ бодит үйл ажиллагаа болон нийгмийн оролцоонд шууд хэрэгжүүлэх чадвар олгох зорилготой.

Хичээлийн зорилго	● Танин мэдэхүй: ДИБ-ын үнэт зүйлс (энх тайван, тогтвортой хөгжил, соёл хоорондын яриа)-ийг ойлгож, монголын соёлтой холбох. ● Нийгэм-сэтгэл зүй: Бүтээлч үйл ажиллагаагаар дамжуулан хүмүүнлэгийн болон багийн ажиллагаа, соёл хоорондын ур чадварыг олгох. ● Зан үйлийн: ДИБ-ын үнэт зүйлсийг орон нутгийн болон дэлхийн сорилтод чиглэсэн оюутнуудын төслийн хүрээнд хэрэгжүүлэх.			
Суралцахуйн үр дүн (CLOs)	Оролцогчид дараах чадваруудыг эзэмшинэ: 1. ДИБ-ын үзэл баримтлалыг тайлбарлаж, монголын соёлын үнэт зүйлстэй холбон ойлгох. 2. Энэрэх сэтгэл болон соёл хоорондын хамтын ажиллагааг уялдуулах. 3. Бүтээлч ажилд тулгуурласан жижиг хэмжээний нийгмийн оролцооны төслийг боловсруулах, хэрэгжүүлэх. 4. Дэлхийн иргэний хувьд өөрийн өсөлт хөгжилд шүүмжлэлтэйгээр хандах.			
Долоо хоногийн сэдэв ба үйл ажиллагаа	Долоо хоног	Сэдэв	Суралцахуйн үйл ажиллагаа	Голлох ДИБ-ын хүрээ
	1	Танилцуулга: Урлаг ба дэлхийн иргэншил	Танилцуулга, лекц, багийн ажил	Танин мэдэхүй + Нийгэм-сэтгэл зүй
	2	Соёл, урлагаар илэрхийлэгдсэн энх тайван, шударга ёс ба тогтвортой хөгжил	Кейс судалгаа, хэлэлцүүлэг	Танин мэдэхүй
	3	Харилцан яриа ба хүмүүнлэгийн семинар	Соёл хоорондын дүрд тоглох, хамтарсан бүтээлч ажлууд	Нийгэм-сэтгэл зүйн
	4	Загварын лаборатори I	Багууд төслийн төлөвлөгөө боловсруулах	Зан үйлийн
	5	Загварын лаборатори II	Төслийг хэрэгжүүлэх ба хамт олны үнэлгээ	Зан үйлийн + Нийгэм-сэтгэл зүйн
Сургалт ба суралцах үйл ажиллагаа (TLA)	6	Илтгэл ба бодол эргэцүүлэл	Төслийн танилцуулга, хэлэлцүүлэг	Зан үйлийн + Танин мэдэхүй
	● Лекц ба зочин илтгэгчдийн яриа ● Мастер класс семинар, бүтээлч дадлага ● Багийн ажилд зориулсан “Дизайн лаб” ● Тэмдэглэл ба хэлэлцүүлэг			
	● Ирц ба идэвхтэй оролцоо (шаардлагатай) ● Тэмдэглэл (долоо хоног бүр) ● Багийн төсөл (санааны тэмдэглэл + эцсийн танилцуулга) ● Хөтөлбөрийг бүрэн дүүрэн хангаж дүгнүүлсний дараа сертификат олгоно			
	Энэхүү хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаанууд нь бүх салбарын ахисан түвшний оюутнуудад зориулагдсан бөгөөд сонирхсон бакалаврын оюутнууд ч оролцох боломжтой. Үйл ажиллагааг сургалтын зөвлөх багш удирдан чиглүүлж, магистр болон докторын түвшний оюутнууд тус сургуулийн оюутнуудын оролцоог үнэлэх журмаар олгогдсон боломжийг ашиглан оролцогчдыг чиглүүлэн ажиллана (СУИС-ийн магистр, докторын оюутны туслах ажил эрхлэлтийн журмын дагуу).			
	Тэмдэглэл			

4. Соёл урлагийн их сургуулийн ахисан түвшний сургалтад дэлхийн иргэний боловсролыг нэвтрүүлэх нь

Энэхүү загвар хичээлийн хөтөлбөр нь сэдэв болон долоо хоног бүрийн үр дүнг тодорхойлж байгаа ч, амжилт нь хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хэрэгжүүлэхээс ихээхэн хамаарна. “Сургалтын ерөнхий хөтөлбөрийн гарын авлага”-д дурдсанаар ийм төрлийн үйл ажиллагаа нь нэг удаагийн арга хэмжээ бус, тогтвортой байдлыг хангах нь чухал гэсэн байдаг. СУИС-ийн хувьд энэ нь:


- **Үйл ажиллагааг тодорхой хүрээнд төлөвлөх.** Цуврал лекц, лаборатори, бүтээлч ажлын төслийн аль нэг хэлбэрийг сонгож, сургалтын зорилтот үр дүнг тодорхойлох, үйл ажиллагаа бүрийг ДИБ-ын хүрээнүүд болон холбогдох хичээлүүдтэй уялдуулах.
- **Оюутны оролцоог дэмжих.** Тогтоосон журмын дагуу ахисан түвшний оюутнуудыг тухайн бичил төсөл, арга хэмжээнүүдийн зохицуулагчаар томилж, тэднийг зөвхөн зохион байгуулалтын үүрэг хүлээх бус, хамтран орлоцогч, чиглүүлэгчийн байр сууринаас ажиллуулах.
- **Үйл ажиллагааг тогмтолжуулах.** Хагас жилийн хугацаанд дор хаяж зургаан удаагийн уулзалт төлөвлөж, уулзалт бүрийг ДИБ-ын гурван хүрээтэй (танин мэдэхүй, нийгэм-сэтгэл зүй, зан үйл) уялдуулах.
- **Суралцахуйн үр дүнг баталгаажуулах.** Шалгалтын оронд эсээ, төслийн танилцуулга зэргээр үнэлж, сертификат олгох. Эдгээрийг зэргийн бус хөтөлбөрийг төгсөх үед тооцуулах боломжийг судлах.
- **Тогтвортой байдлыг хангах.** Клуб, лабораториудаар дамжуулан хөтөлбөрөөс гадуурх арга хэмжээ дууссаны дараа ч төслөө үргэлжлүүлэхийг нь дэмжих, бүтээлийг цахим орчинд байршуулах зэргээр цаашид үргэлжлүүлэх шаардлагатай эсэхийг баримтаар нотлох.

Дээрх жишээгээр хөтөлбөрөөс гадуурх ДИБ-ын хөтөлбөрийг албан ёсны сургалтын хөтөлбөртэй төстэй байдлаар зохион байгуулж болохоос ба илүү уян хатан, оролцоонд байдлаар зохион байгуулах боломжтойг харуулсан. Ахисан түвшний оюутнуудыг татан оролцуулснаар байгууллагад тулгардаг хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхээс гадна, мэдлэг, сэтгэл, үйлдэл гэсэн суралцахуйн үр дүнгийн тэнцвэрийг хангана. Хамгийн чухал нь, ийм бүтэцтэй хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаа нь бусад ДИБ-ыг нэвтрүүлэх хандлагуудаас илүү уялдаа холбоотой. Жишээ нь зэргийн бус хөтөлбөрийн хүрээнд санаачилсан төслүүд нь үргэлжлэн хэрэгжих эсвэл ДИБ-ын хичээлүүдийн даалгавруудыг бодит амьдралд хэрэгжүүлэх, оюутнууд ДИБ-ын үнэт зүйлсийг СУИС-ийн өдөр тутмын соёл, академик орчинд нэвтрүүлэх боломжтой юм.

5. Дүгнэлт

5.1 Судалгааны гол үр дүнгүүд

5.2. Бодлогын чиглэл ба зөвлөмж



5. Дүгнэлт

Өмнөх бүлгүүдэд СУИС-д хэрэгжиж буй ДИБ-ыг хэрэгжүүлэх үзэл баримтлалын үндэслэл, нөхцөл байдлын шинжилгээ, болон байгууллагын дотоод нөөцөд суурилсан жишээ, онцлогийг авч үзсэн. Тэгвэл энэ бүлэгт өмнөх бүлгүүдийн дүгнэлтүүдийг нэгтгэж, монголын дээд боловсролын салбарт ДИБ-ыг нэвтрүүлэхэд бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон. Түүнчлэн, зөвхөн СУИС-ийн бодит нөхцөл байдалд нийцэх стратегийн чиглэлүүд төдийгүй монголын бусад их, дээд сургуулиудад хэрэгжүүлж болох бодлогын зөвлөмжийг санал болгож байна.

5.1 Судалгааны гол үр дүнгүүд

Энэхүү тайлангийн зорилго нь монголын их, дээд сургуулиудад ахисан түвшний сургалтад ДИБ-ын агуулгыг тусган хэрэгжүүлэх боломжийг судлах бөгөөд СУИС-ийг туршилтын жишээ болгон авч үзлээ. Нэгдүгээр бүлэгт, ДИБ-ыг боловсролыг тойрсон олон улсын хүрээнд авч үзэхийн зэрэгцээ XXI зууны тулгамдсан сорилтуудтай холбон тайлбарлаж, уг судалгааны өргөн хүрээний үндэслэлийг тайлбарласан. ДИБ гэх ойлголт нь хавсарга үзэл баримтлал бус, харин суралцагчдад тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, мөргөлдөөн, нийгмийн хуваагдал зэрэг дэлхийн хэмжээний нарийн төвөгтэй асуудлуудад шийдвэртэй хандах чадамжийг олгоход чиглэсэн загвар болохыг онцолсон. ДИБ нь Тогтвортой хөгжлийн зорилгууд болон ЮНЕСКО-ийн энх тайван, хүний эрхийн боловсролын талаарх зөвлөмж (UNESCO, 2024)-тэй нийцэж байгааг харуулсан. Эдгээрт үндэслэн ДИБ-ын үзэл баримтлалыг монголын их, дээд сургуулиудад нэвтрүүлэх нь дэлхийн боловсролын чиг хандлага болон улсын боловсролын зорилтуудын төлөө цаг үеэ олсон, зайлшгүй шийдэл гэдгийг уг бүлэгт тодорхойлсон.

Хоёрдугаар бүлэгт ДИБ-ыг дээд боловсролд тусгах таван хандлагыг танилцуулж, ойлголт болон хэрэгжилтийн суурь нөхцлийг тодорхойлсон. Эдгээр хандлагууд нь бие даасан хичээл бий болгохоос эхлээд одоо байгаа сургалтын хөтөлбөрт тусгах, хичээлээс гадуурх хөтөлбөр эсвэл төсөлд суурилсан хэлбэрээр зохион байгуулах, салбар дундын сургалтын модуль боловсруулах болон урт хугацааны мэргэжлийн хөтөлбөр боловсруулах зэрэг өргөн боломжийг санал болгож байна. Эдгээр хандлагуудаас монголын их, дээд сургуулиуд байгууллагын оролцооны боломж, нөөцийн хуваарилалт, сургалтын цар хүрээ зэрэг өөрсдийн онцлог, стратегийн зорилттойгоо уялдуулан сонгон хэрэгжүүлэх боломжтой. Түүнчлэн, эдгээр нь тус бүр салангид бус, харин үе шаттайгаар, харилцан нөхөх байдлаар тэлж хэрэгжих боломжтой болохыг онцолсон. Энэ бүлэгт эдгээр хандлагуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх нь байгууллагууд туршилтын модуль эсвэл жижиг төслөөр эхэлж, яваандаа цогц хөтөлбөрийн хэмжээнд хүргэх алхмуудыг төлөвлөх боломжтойг харуулсан. Онолын загварыг тодорхойлсноор олон улсын туршлагыг монголын нөхцөл байдалтай холбон тайлбарлах үнсдийг бүрдүүлсэн. Мөн энэ бүлэгт, БНСУ-ын их дээд сургуулиудад хэрэгжсэн жишээнүүдээр дамжуулан ДИБ-ыг судалгаа, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоотой хэрхэн холбож болохыг харуулсан.

Гуравдугаар бүлэгт СУИС-ийн хувьд ДИБ-ын нөхцөл байдлын шинжилгээг хийж, хөтөлбөрийн шинэчлэлд тулгуур болох бодит дүн шинжилгээний үр дүнг танилцуулсан. Энэхүү шинжилгээ нь боломжит нөхцөл ба хязгаарлалтуудыг хамтад нь тодорхойлсон. Нэг талаас СУИС нь соёл, урлагийн чиг баримжаа, олон улсын түншлэл, инновац ба дэлхийн чиг баримжаатай хөгжих эрмэлзэл зэрэг онцгой давуу талуудтай байна. Эдгээр нь ДИБ-ыг сургалтын хөтөлбөрт СУИС-ийн үнэт зүйлстэй нийцтэй байдлаар тусгах боломжийг бүрдүүлж байна. Нөгөө талаас, ДИБ-ын чиглэлээр мэргэжлийн эсвэл мэргэшсэн багш дутагдалтай, нэвтрүүлэлтэд тусгайлсан байгууллагын түвшний бодлогын тогтолцоо бүрдээгүй, гадаад хэлний болон цахим хэрэглээний бэрхшээл, нөөцийн хуваарилалтын эрэмбэ доогуур байх зэрэг нь хязгаарлах хүчин зүйлс болж байна. Нөхцөл байдлын шинжилгээ нь ДИБ-ыг нэвтрүүлэхэд зөвхөн хөтөлбөрийн шинэчлэлт бус, байгууллагын түвшний дэмжлэг, бодлогын уялдааг шаарддаг болохыг онцолсон. Энэ бүлгээр СУИС-ийн өнөөгийн нөхцөлд тохирсон үе шаттай хэрэгжүүлэх боломжтой загвар шаардлагатай болохыг харуулсан.

Өмнөх бүлгүүдэд тулгуурлан таван хандлагыг СУИС-ийн нөхцөлд нийцүүлэх практик алхмуудыг санал болгосноороо 4-р бүлэг нь энэ тайлангийн хамгийн чухал хэсэг болж байна. Энэ бүлэгт хандлага тус бүрийг монголын нөхцөлд хэрхэн хэрэгжүүлэхийг харуулсан. Жишээ нь, ДИБ-ыг одоо байгаа ахисан түвшний хөтөлбөрт богино модуль эсвэл зэргийн бус хөтөлбөр хэлбэрээр тусгах (Хүснэгт 4.1), соёл, урлагийн хичээлийн сэдвүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах (Хүснэгт 4.2), хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаагаар оюутны манлайлал, нийгмийн оролцоог дэмжих санаачилга боловсруулан (Хүснэгт 4.3) турших замаар алсдаа сургууль, тэнхимүүдийн хамтарсан, салбар дундын хөтөлбөрүүдийг бий болгохыг санал болгосон. Энэ бүлгээр СУИС, эдгээр саналуудыг үе шаттай хэрэгжүүлэх замаар туршилтын түвшнээс тогтвортой төлөвлөлт бүхий ахисан түвшний хөтөлбөр хүртэл өргөжүүлэх стратегийг тодорхойлсон. Үндсэндээ, эдгээр саналууд нь ДИБ-ыг сургалтын хөтөлбөрт тусгах шаталсан замын зураглалтай уялдсан ба байгууллагын одоогийн нөхцөл байдалд хязгаарлагдалгүй, алсдаа хүрч болох түвшнийг харуулсан. Доороос нь буюу хичээлээс гадуурх хөтөлбөр, туршилтын модулиар эхлээд, бүрэн бие даасан ахисан түвшний хөтөлбөрийг бий болгоход чиглэн шат ахиулан хэрэгжүүлэх боломжийг олгож байгаа нь таван хандлагын уян хатан, хэрэглэгдэхүйц байдлыг илтгэж байгаа юм. Энэ шаталсан логик нь тайлангийн гол санаа болох ДИБ-ыг дээд боловсролд нэвтрүүлэх явдал нь нэг удаагийн бус, харин байгууллагын тогтвортой оролцоо, чадамж, бодлогын уялдаа шаардсан тасралтгүй үргэлжлэх үйл явц гэдгийг дахин тодруулж байна. Дөрвөн бүлгийг нэгтгэн харвал ДИБ-ыг монголын дээд боловсролын хөтөлбөрт нэвтрүүлэх алсын хараатай байх ба бодит хэрэгжилтийг хангах асуудал аль аль нь шаардлагатай харагдаж байна. Эхний асуудал нь ДИБ-ыг нэвтрүүлэх өөрчлөлтөд чиглэсэн зорилгуудаар илрэх бол, удаах нь байгууллагын нөхцөл байдалд тохирсон үе шаттай алхмуудаар тодорхойлогдоно. Энэхүү эрмэлзэл ба боломжит байдлын тэнцвэр нь тайлангийн гол үр дүн бөгөөд СУИС-ийн хувьд хөтөлбөрийн инновацыг хэрэгжүүлэх талбар төдийгүй монгол болон бусад их, дээд сургуулиудад жишээ болохуйц загвар сургууль болон хөгжих боломжийг харуулсан гэж итгэж байна.

5.2 Бодлогын чиглэл ба зөвлөмж

Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд ДИБ-ыг хавсарга шинжтэй гэх бус, харин сургалтын үндсэн тэргүүлэх чиглэл гэдэг утгаар нь ойлгож хүлээж авах нь монголын дээд боловсролын салбарт нэвтрүүлэхэд хамгийн чухал юм. СУИС-ийн хувьд ДИБ-ын агуулгатай ахисан түвшний хичээлүүдийг хөгжүүлэх замын зураглалаас бид, байгууллагын хэмжээний зохион байгуулалт төдийгүй үндэсний бодлогын хэмжээний өөрчлөлтийн шаардлага үүсэж байгааг дурдах нь зүйтэй. Зөвлөмжүүдийг бодит нөхцөл байдал болон урт хугацааны зорилттой уялдуулан доорх байдлаар хүргэж байна. Энд дурдаж буй замын зураглал нь зөвхөн СУИС-т ч бус ДИБ-ыг нэвтрүүлэхээр зорьж буй монголын бусад их, дээд сургуулиудад мөн адил ач холбогдолтой гэж үзэж болно.

5.2.1. Байгууллагын засаглал ба стратегийн уялдаа

Нэгдүгээрт, засаглал ба стратеги төлөвлөгөөний уялдаа нь амжилттай хэрэгжих суурь нөхцөл болдог. ДИБ-ыг үр дүнтэй нэвтрүүлэхийн тулд байгууллагын удирдлага ДИБ-ыг сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн хэсэг болгон тодорхойлох шаардлагатай. СУИС-ийн хувьд, хүн төвт боловсролын үзэл баримтлал болон үндэснийхээ дээд боловсролын бодлоготой уялдуулах нь ДИБ-ыг нэвтрүүлэх бодлогын болон зохион байгуулалтын дэмжлэг авах үндэслэл болно. Энд мөн сургалтын үйл ажиллагаа явуулах нөөц, цахим дэд бүтэц, чанарын баталгаажуулалтын өөрийн үнэлгээний тогтолцоог хангах асуудал орно. Монголын бусад их, дээд сургуулиуд мөн адил ДИБ-ыг байгууллагын онцлогтоо тулгуурлан, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэл болон олон улсын үүрэг амлалтуудтай шууд холбох хэрэгтэй. Ийм уялдаа нь хариуцлагыг нэмэгдүүлж, ДИБ-ын санаачилгуудыг түр зуурын бус, харин урт хугацааны төлөвлөлт болгон тодорхойлоход тусална.

5.2.2. Хөтөлбөрийн дизайн ба үе шаттай хэрэгжилт

Хөтөлбөрийн хэрэгжилт нь шат дараалсан, уян хатан хандлагыг шаардаж байна. Хоёр болон дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан таван хандлага нь их, дээд сургуулиуд ДИБ-ыг аажмаар хэрхэн хэрэгжүүлэхийг харуулсан. Одоо байгаа хичээлд ДИБ-ын агуулгыг тусгахаас эхлээд бие даасан хөтөлбөр хүртэл өргөжүүлэх хэрэгжүүлэх талаар дурдсан. СУИС-ийн хувьд богино хугацаанд хэрэгжүүлэх нь зэргийн бус хөтөлбөр болон соёл, урлагийн сургалтын хөтөлбөрт ДИБ-ын агуулгыг нэгтгэх явдал бөгөөд урт хугацаанд салбар дундын ахисан түвшнийг бие даасан хөтөлбөр бий болгох зорилго тавьж болно. Энэ шаталсан хандлага нь цаг алдалгүй хэрэгжүүлэх боломж болон алсын зорилтыг хослуулах ба байгууллагын түвшинд аажмаар тогтвортой хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ. Монголын бусад дээд боловсролын байгууллагууд мөн адил бага зардал, бага эрсдэлтэй хандлага (жишээлбэл, хичээлээс гадуурх лекц, семинар, туршилтын богино хугацааны сургалт) -аар эхэлж, сургуулийн чадамж нэмэгдэхийн хэрээр ДИБ-ын тусгай хөтөлбөр рүү чиглэнэ. Энэ тайланд санал болгож буй замын зураглал нь уян хатан бөгөөд тайланд танилцуулсан таван хандлагын онцлогийг тусгасан ба байгууллага бүр өөрийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх боломжтой юм.

5.2.3. Багшийн хөгжил ба оюутны оролцоо

Сургалтын хөтөлбөрийн ямар ч шинэчлэл багшийн хөгжил, оюутны оролцоонд бодитоор анхаарал хандуулахгүйгээр тогтвортой хэрэгжих боломжгүй. СУИС-ийн хувьд багш нарт зориулсан сургалт, семинар, хамтарсан судалгааны боломжууд нь ДИБ-ын сургалтын арга зүйг боловсруулахад зайлшгүй шаардлагатай. Шүүмжлэлт сэтгэлгээг төлөвшүүлэх заах арга зүй, соёл хоорондын яриа хэлэлцээр, оролцоонд суурилсан сургалтыг хөгжүүлэх нь соёл, урлагийн боловсролыг дэлхийн асуудлуудтай холбох гол түлхүүр болно. Үүнтэй зэрэгцэн хүмүүнлэг, дэлхийн хэмжээнд сэтгэх, иргэний хариуцлагыг үнэлэх үнэлгээний хэрэгсэл боловсруулах нь чухал байна. Гуравдугаар бүлэгт дурдсан “Хичээлийн ДИБ-ын хүрээний агуулгыг үнэлэх рубрик” нь сургалтын үр дүнг ДИБ-ын хүрээтэй уялдуулах нэг бодит хэрэгсэл юм. Энэ мэтчилэн үнэлгээний хэрэгсэл үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх нь байгууллагууд хоорондын уялдаа, чанарын баталгаажуулалт бэхжихэд чухал нөлөөтэй. Түүнчлэн оюутнууд соёл хоорондын харилцан яриа, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаануудад идэвхтэй оролцох боломжтой байх ёстой. Эдгээрийг кредитэл тооцох системтэй холбосноор залгамж чанарыг хадгалахын зэрэгцээ сургалтын чанарыг хангана. Бусад их, дээд сургуулиуд ч багшийн хөгжил болон оюутныг бүтээгчээр татан оролцуулах бодлогыг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх нь чухал нөлөөтэй юм.

5.2.4. Тогтвортой байдлыг хангах түншлэл ба харилцаа холбоо

ДИБ-ыг тогтвортой нэвтрүүлэхэд өргөн хүрээний түншлэл ба хамтын ажиллагааны дэмжлэгтэй үед илүү үр дүнтэй байдаг. СУИС нь өөрийн олон улсын идэвхтэй хамтын ажиллагаагаа ашиглан хамтарсан хичээл ба цахим арга хэмжээ, судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой. Үндэсний хэмжээнд ДИБ-ын үзэл баримтлалыг дэмжсэн их, дээд сургуулиудын сүлжээ байгуулснаар дутагдалтай нөөцүүдээ хамтдаа шийдвэрлэх, бодлогод хамтын оролцоогоор нөлөөлөх боломж бүрдэнэ. ЮНЕСКО, APCEIU зэрэг олон улсын байгууллагууд техникийн дэмжлэг, сургалт, олон улсын хэлэлцүүлгийн талбар олгох зэргээр монголын их, дээд сургуулиудын хүчин чармайлтыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж чадна. Ийм түншлэл нь ДИБ-ыг нэг удаагийн туршилтын хэлбэр бус, харин урт хугацаанд тогтвортой хөгжих хамтын үйл ажиллагаа болгоход чиглэнэ.

Эцэст нь хэлэхэд, энд дэвшүүлсэн бодлогын чиглэлүүд нь алсын хараа болон бодит хэрэгжилтийн тэнцвэрийг хадгалах шаардлагатайг тодотгож байна. СУИС-ийн хувьд зэргийн бус хөтөлбөр, одоо байгаа хичээлүүдэд ДИБ-ын агуулгыг тусгах, хичээлээс гадуурх хөтөлбөрүүдийг тогтвортой хэрэгжүүлэх зэрэг алхмууд ойрын хугацаанд бодитой хэрэгжих боломжтой бөгөөд хамгийн хүртээмжтэй, ач холбогдолтой эхлэл болно. Монголын бусад их, дээд сургуулиуд ч мөн ийм үе шаттай стратегийг сонгосноор өөрийн нөөц бололцоонд нийцүүлэн үр дүнтэй ахиц гаргах боломжтой. Үндэсний хэмжээнд бодлогын манлайлал, багшийн хөгжлийн хөтөлбөр, их, дээд сургуулиудын сүлжээг бүрдүүлэх зэргээр эдгээр санаачилгуудыг өргөн хүрээнд түгээн хэрэгжүүлэхэд анхаарах нь чухал ач холбогдолтой. Санал болгож буй замын зураглалыг авч хэрэглэх нь монголын их, дээд сургуулиудад зөвхөн сургалтаа дэлхийн жишигт нийцүүлэх төдийгүй хариуцлагатай, идэвхтэй, дэлхийн иргэдийг төлөвшүүлэх олон улсын хөдөлгөөний нэг хэсэг болоход тусалж чадна.

НОМ ЗҮЙ

- Amartuvshin, M. (2024). *Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үзэл баримтлал*. СУИС. хуу. 55. Зүгар 1.14
- Andreotti, V.D.O., & de Souza, L.M.T.M. (Eds.). (2012). *Postcolonial Perspectives on Global Citizenship Education* (1st ed.). New York: Routledge.
- Appiah, K. (2006). *Cosmopolitanism: ethics in a world of strangers*. New York: Norton.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2014). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2016). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2017). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2018). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2019). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2020). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2021). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2022). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2023a). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2023b). *Common Curriculum Guide for Peace Education in Northeast Asia*. Seoul: APCEIU.
- Asia-Pacific Centre of Education for International Understanding. (2024). *Final Report of the University GCED Course Development Support Programme*. Seoul: APCEIU.
- Bolormaa, S. (2023). *Promoting Mongolia's esteemed values through independent student work* [Unpublished internal grant project report]. Mongolia National University of Arts and Culture.
- Cohen, J. (1988). *Statistical Power Analysis for the Behavioral Sciences*. New York: Routledge.
- Delors, J. (1996). *Learning: The Treasure within. Report to UNESCO of the International Commission on Education for the Twenty-First Century*. Paris: UNESCO Publishing. Retrieved from <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000102734>

- Erkhemtuugs, J., Bayarmaa, G., & Bayarmunkh, G. (2023). *Evaluating the skills of university graduates with the participation of employees*. Journal of Education Studies, 28(5), 59-68. doi:<https://doi.org/10.56380/v28.5>
- Freire, P. (2000). *Pedagogy of the oppressed* (30th anniversary ed.). Continuum. (Original work published 1970)
- Han, K., Kim, J., Lee, K., and Jho, D. (2015). *Strategies for Global Citizenship Education in the Era of SDGs*. Seoul: APCEIU. <https://www.unescoapceiu.org/post/1829>
- Heater, D. (1996). *World Citizenship and Government: Cosmopolitan Ideas in the History of Western Political Thought*. London: Palgrave Macmillan.
- Heater, D. (1999). *What Is Citizenship?* Cambridge, UK: Polity Press.
- Hooks, B. (1994). *Teaching to transgress: Education as the practice of freedom*. Routledge. London
- Ministry of Education, Culture, Science and Sports. (2020). *Towards Mongolia's long-term development policy Vision 2050: Advancing education equity, efficiency, and outcomes*. Ulaanbaatar: Ministry of Education, Culture, Science and Sports.
- Merryfield, M. M. (1991). Preparing American secondary social studies teachers to teach with a global perspective: A status report. *Journal of Teacher Education*, 42(1). 11-20.
- Merryfield, M. M. (1992). Preparing Social Studies Teachers for the Twenty-First Century: Perspectives on Programme Effectiveness from a Study of Six Exemplary Programmes in the United States. *Theory and Research in Social Education*, 20, 17-46.
- Ministry of Education. (2022). Report of Civic Education Competency Enhancement Programme for Teacher Training Universities (2019–2022). Korean Ministry of Education. Sejong: Ministry of Education.
- Ministry of Education and Science. (2024, 20 March). Order No. A/146: On approval of the list of disciplines and programme names. Mongolian Ministry of Education and Science. Ulaanbaatar: Ministry of Education and Science.
- Ministry of Education. (2025a). *Statistical Yearbook of Education 2024–2025*. Mongolian Ministry of Education. Ulaanbaatar: Ministry of Education.
- Ministry of Education. (2025b, 2 June). Order No. A/287: On revision of the list of disciplines and programme names. Ulaanbaatar: Ministry of Education.
- Ministry of Education, Culture, Science and Sports; Asian Development Bank. (2017a). *Дээд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах гарын авлага* [Curriculum development guide for Mongolian higher education institutions]. Munkhiin Useg LLC. Ulaanbaatar, Mongolia.

- Ministry of Education, Culture, Science and Sports; Asian Development Bank. (2017b). *Хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох арга зүйн зөвлөмж* [Methodological guide for defining program educational objectives, learning goals, and outcomes]. Munkhiin Useg LLC. Ulaanbaatar, Mongolia.
- Mongolian National University of Arts and Culture. (2020). MNUAC Gender-Sensitive Syllabi Manual: Developed with support from United Nations Population Fund [UNFPA], & Swiss Agency for Development and Cooperation [SDC]. Ulaanbaatar: Munkhiin Useg LLC
- Mongolian National University of Arts and Culture. (2020). *Graduate curriculum book: Cultural studies program (E03140101)*. Ulaanbaatar: Mongolian National University of Arts and Culture. (Internal publication).
- Mongolian National University of Arts and Culture. (2021). *An Overview of the Mongolian Esteemed Values*. Ulaanbaatar, Mongolia: Mongolian National University of Arts and Culture.
- Mongolian National University of Arts and Culture. (2025). *Strategic plan 2025–2030* [Unpublished internal draft]. Ulaanbaatar: Mongolian National University of Arts and Culture.
- National Research Institute for Labour and Social Protection. (2021). *Baseline study to identify current and future labour market supply and demand in Mongolia*. Ulaanbaatar: National Research Institute for Labour and Social Protection.
- Nussbaum, M. C., & Cohen, J. (1996). *For Love of Country: Debating the Limits of Patriotism*. Boston: Beacon Press.
- Organisation for Economic Co-operation and Development (2021), “Micro-credential innovations in higher education : Who, What and Why?”, OECD Education Policy Perspectives, No. 39, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/f14ef041-en>.
- Pike, G. (2000). Global Education and National Identity: In Pursuit of Meaning. *Theory into Practice*, 39(2), 64-73. https://doi.org/10.1207/s15430421tip3902_2
- Pike, G., & Selby, D. (1988). *Global Teacher, Global Learner*. London: Hodder & Stoughton.
- Pike, G., & Selby, D. (1995). *Reconnecting from National to Global Curriculum*. Toronto: International Institute for Global Education, University of Toronto.
- ScholarGPS. *Scholarly profile directory and metrics summary*. Retrieved 06 15, 2025, from ScholarGPS: <https://scholargps.com/countries/MN/mongolia>
- Scimago Journal & Country Rank. *Journal rankings: Mongolia 2024*. Retrieved 6 15, 2025, from Scimago Journal & Country Rank: <https://www.scimagojr.com/journalrank.php?country=MN>
- Singer, P. (2002). *One world: The Ethics of Globalization*. New Haven: Yale University.
- State Great Khural of Mongolia. (2020). The State Order Regarding the Approval of Mongolia’s

Long-term Development Policy “Vision-2050”. *Annex 1 to Resolution No. 52 of the State Great Khural of Mongolia (2020): Vision-2050 Long-Term Development Policy of Mongolia*. Ulaanbaatar, Mongolia: Parliament of Mongolia.

State Great Khural of Mongolia. (2022, 17 June). *Law on Licensing*. Ulaanbaatar, Mongolia: Parliament of Mongolia.

State Great Khural of Mongolia. (2023a, 7 July). General Law on Education. *General Law on Education*. Ulaanbaatar: Parliament of Mongolia. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

State Great Khural of Mongolia. (2023b, 7 July). *Law on Higher Education*. Ulaanbaatar, Mongolia: Parliament of Mongolia.

United Nations Education, Scientific and Cultural Organization. (1974). *Recommendation Concerning Education for International Understanding and Cooperation and Peace and Education Relating to Human Rights and Fundamental Freedoms*. Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000234156>

United Nations Education, Scientific and Cultural Organization. (2014). *Global citizenship education: preparing learners for the challenges of the 21st century* Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000227729>

United Nations Education, Scientific and Cultural Organization. (2015). *Global Citizenship Education: Topics and Learning Objectives*. Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000232993>

United Nations Education, Scientific and Cultural Organization. (2022) *Promoting Global Citizenship Education in Arab Universities Proposals for Action*. Paris: UNESCO. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000381929?posInSet=1&queryId=548a8995-0837-4bb7-acec-509c1d15c34d>

United Nations Education, Scientific and Cultural Organization. (2024). *Recommendation on Education for Peace and Human Rights, International Understanding, Cooperation, Fundamental Freedoms, Global Citizenship and Sustainable Development*. Paris: UNESCO. https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000391686_eng

United Nations Secretary-General. (2012). *Global Education First Initiative: An initiative of the United Nations Secretary-General* (36 pp.). New York. Retrieved from <https://www.gcedclearinghouse.org/resources/global-education-first-initiative-initiative-united-nations-secretary-general?language=en>

ХАВСРАЛТ 1.

Асуулгын хуудас

1. Сүүлийн 5 жилд та ямар төрлийн олон улсын төсөл, арга хэмжээнд оролцсон бэ?

- Судалгааны төсөл
- Урлаг, соёлын хамтын ажиллагаа
- Гадаадад болсон бага хурал, уран бүтээлийн резиденц
- Онлайн сургалт
- Хамтарсан сургалтын хөтөлбөр, семинар
- Багшийн хөгжил, солилцооны хөтөлбөр
- Оролцоогүй
- Бусад

2. Би олон улсын болон гадны байгууллагын төсөлд оролцох хүсэлтэй байдаг.

Огт санал нийлэхгүй / Санал нийлэхгүй / Аль нь ч биш / Санал нийлнэ/ Бүрэн санал нийлнэ

3. Би олон улсын хамтрагчидтай хамтарч хичээл заах, судалгаа хийх, эсвэл уран бүтээл хийх үед өөрийгөө бэлтгэгдсэн, өөртөө итгэлтэй байдаг гэж үздэг.

Огт санал нийлэхгүй / Санал нийлэхгүй / Аль нь ч биш / Санал нийлнэ/ Бүрэн санал нийлнэ

4. Таны хувьд олон улсын төсөл, хамтын ажиллагаанд үр дүнтэй оролцох боломжийг нэмэгдүүлэхэд юу хамгийн их тус болох вэ? (хамгийн чухал гэсэн 3 сонголтыг сонгох)

- Цагийн зохицуулалт / ажлын ачааллыг хөнгөлөх
- Санхүүгийн дэмжлэг (томилолтын зардал, материалын зардал гм)
- Гадаад хэлний сургалт эсвэл орчуулгын туслалцаа үзүүлэх
- Төслийн менежмент ба хамтын ажиллагааны сургалт явуулах
- Уран бүтээлч/академик хамтын ажиллагаанд тохирсон жишээ, туршлага солилцох
- Олон улсын түншүүдтэй холбох, мэдээллээр хангах
- Дэмжих дотоод бодлого (урамшууллын тогтолцоо, захиргааны дэмжлэг)
- Сургуулийн түвшинд албан ёсоор дэмжсэн удирдамж, чиглэл өгөх
- Бусад

5. Та олон улсын төсөл, хөтөлбөрийн талаар сонирхож байна уу?

Тийм / Үгүй

6. Та доорх үзэл бодолтой хэр зэрэг санал нийлэх вэ?

- Соёл хоорондын ойлголцлыг дэмжих нь дээд боловсролд чухал ач холбогдолтой.
- Оюутнуудад дэлхийн тулгамдсан асуудлууд (цаг уурын өөрчлөлт, тэгш бус байдал гм)-д анхаарах сэдэл өгөх нь чухал.
- Дээд боловсрол нь нийгмийн хариуцлага, ёс зүйт иргэдийг төлөвшүүлэхэд чиглэсэн байх ёстой.
- Соёлын болон хувь хүний ялгаатай байдлыг хүндэтгэх нь оюутнуудын ирээдүйд тустай.
- Би энх тайван, шударга, ээлтэй дэлхийг бүтээхэд хувь нэмэр оруулах чадвартай оюутнуудыг төлөвшүүлэхийг дэмждэг.

Огт санал нийлэхгүй -1 / санал нийлэхгүй-2 / Аль нь ч биш-3 / Санал нийлнэ -4/ Бүрэн санал нийлнэ-5

7. Таны зааж буй хичээлийн агуулгад доорх ойлголтууд хэр хэмжээнд орсон байдаг вэ?

- Олон улсын харилцан хамаарал ба тогтвортой хөгжил
- Энх тайван ба зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх
- Хүний эрх, хүний эрхэм чанар
- Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль хамгаалал
- Соёлын олон янз байдал ба харилцан ойлголцол
- Хэвлэл мэдээлэл ба дижитал мэдээллийн боловсрол
- Нийгмийн шударга ёс ба тогтолцооны шударга бус байдал
- Ядуурал ба нийгмийн тэгш бус байдал
- Жендэрийн тэгш байдал ба жендерийн боловсрол

Огт тусгагдаагүй -1 / Тусгагдаагүй-2 / Дунд зэрэг тусгагдсан-3 / Сайн тусгагдсан -4/ Маш сайн тусгагдсан-5

8. Та Дэлхийн иргэний боловсрол гэх концепцын талаар хэр хэмжээний мэдлэгтэй вэ?

Заах хэмжээнд мэднэ/ Ерөнхий мэдлэгтэй/ Сонсож байсан / Огт мэдэхгүй

9. GCED-ийг сургалтад нэвтрүүлэхтэй холбоотой таны байр суурь

- Би дэлхийн иргэний боловсролын чиглэлээр мэргэжлийн хөгжлийн сургалтад хамрагдах сонирхолтой байна.
- Миний мэргэжлийн чиглэлд нийцсэн, шууд ашиглах ДИБ-ын хэрэглэгдэхүүн хэрэгтэй.
- ДИБ-ын үзэл баримтлалыг нэвтрүүлэхдээ жижиг төсөл эсвэл сонгох хичээлээр эхлүүлэх нь зөв.
- “ДИБ-ын үзэл баримтлалыг бүх хөтөлбөрт шингээх нь сургуулийн зорилго байх нь зөв.”

10. Сургалт, судалгааны ажилдаа ДИБ-ын агуулгыг тусгахад тулгарч болох бэрхшээлүүдийг нэрлэнэ үү? (хамгийн чухал гэсэн 3 сонголтыг сонгох)

- Цаг хугацаа хүрэлцдэггүй
- Энэ талаарх мэдлэг, туршлага дутагдалтай
- Сургуулийн стратеги, бодлогод тусгагдаагүй
- Хичээлийн хөтөлбөрийн баригдмал байдал
- Миний чиглэлтэй онцгой хамааралгүй
- Онцын саад бэрхшээл байхгүй
- Бусад

11. Харьяа сургууль

- Бүжгийн урлагийн сургууль
- Дүрслэх урлагийн академи
- Театрын урлагийн сургууль
- Хөгжмийн урлагийн сургууль
- Кино, телевиз медиа урлагийн сургууль
- Соёлын сургууль

12. Тэнхим/ газар

13. Хичээл заадаг зэргийн хөтөлбөр

- Бакалавр
- Магистр
- Доктор

14. Багшилсан хугацаа

- 1-3 жил
- 4-6 жил
- 7-10 жил
- 11-20 жил
- 21-ээс дээш жил

15. Заадаг хичээл

- Ерөнхий эрдэм
- Мэргэжлийн суурь
- Мэргэшүүлэх

ХАВСРАЛТ 2.

Зэргийн бус сургалтын хөтөлбөр боловсруулах процесс

Үе шат	Дэд алхам	Оролт	Гаралт
I. Бэлтгэл үе шат	1.1 Хэрэгцээ тодорхойлох судалгаа	Судалгааны асуулга боловсруулах	Судалгааны асуулгын бүтэц, асуултын жагсаалт
	1.2 Зорилтот бүлгийг сонгох	Судалгааны асуулгын үр дүн	Суралцагчдын тодорхой бүлэг (оюутан, багш, олон нийт гэх мэт)
	1.3 Сургалтын баг бүрдүүлэх	Сургалтын зорилго, чиглэл Сонгосон зорилтот бүлэг Мэргэжлийн шаардлага (ДИБ, хүний эрх, тогтвортой хөгжил гэх мэт) Боломжит хүний нөөц (багш, сургагч, зөвлөх)	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх чадвартай бүрэлдэхүүнтэй баг Хамтын ажиллагааны бүтэц
II. Төлөвлөлт	2.1 Сургалтын хөтөлбөр боловсруулах	Сургалтын хөтөлбөр боловсруулах загвар	Богино хугацааны сургалтын хөтөлбөр
III. Хэрэгжүүлэлт	3.1 Нээлт ба мэдээлэл, танилцуулга	Хөтөлбөрийн мэдээлэл	Хөтөлбөрийн мэдээлэл, танилцуулга хэрэглэгчдэд хүрсэн байна.
	3.2 Сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, багшлах боловсон хүчин, сургалтын орчин	Хөтөлбөрөөр амжилттай төгсөгчид
	3.3 Кейс судалгаа, жижиг төсөл	Кейс судалгааны материал, төслийн танилцуулга	Төсөл хэрэгжүүлэх
	3.4 Төгсөгчдөд сертификат олгох	Төгсөгчдийн мэдээлэл	Сертификат, төгсөгчдийн тоо
IV. Чанарын баталгаажуулалт	4.1 Оролцогчдын сэтгэл ханамжийн үнэлгээ	Сургалтын туршид оролцогчдод өгсөн үйлчилгээ, материал, зааварчилгаа	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин (судалгаа, асуулга, үнэлгээний хуудас)
		Сургалтын орчин, багшлах хүчин, хэрэглэсэн технологи	Сургалтын чанар, арга зүйн үр дүнгийн талаарх санал
	4.2 Сургалтын явцын дүгнэлт	Оролцогчдын анхны хүлээлт, урьдчилсан ойлголт	Ирээдүйн сургалтын сайжруулалт, зөвлөмжид ашиглах мэдээлэл
	4.3 Сайжруулалтын зөвлөмж боловсруулах	Сургалтын явцад цуглуулсан мэдээлэл (оролцогчдын идэвх, оролцооны тайлан) Багш, зааварлагчийн ажиглалт, тэмдэглэл, үнэлгээ Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын үеийн үр дүнгийн үзүүлэлт	Сургалтын явцын тайлан, дүгнэлт Сургалтын чанар, арга зүй, үр дүнгийн үнэлгээ
		Сургалтын явцын дүгнэлт, үнэлгээний мэдээлэл Оролцогчдын санал, сэтгэл ханамжийн үр дүн Сургалтын материал, арга зүй, орчинтой холбоотой ажиглалт	Сургалтын сайжруулалтын тодорхой зөвлөмж, аргачлал Ирээдүйн сургалтын төлөвлөгөө, арга зүйн шинэчлэл Сургалтын чанарыг дээшлүүлэх шийдэл, үр дүнгийн баталгаа

V. Тогтвортой байдал	5.1 Сургалтын талаарх мэдээллийг түгээх	Сургалтын материалыг боловсруулах, боловсронгуй болгох мэдээлэл Сургалтын явцын дүгнэлт, үнэлгээ, сайжруулалтын зөвлөмж Мэдээллийг түгээх платформ, сувгийн нөөц (имэйл, вэб портал, хэвлэл, уулзалт)	Оролцогчид болон бусад хамааралтай талуудын мэдлэг, ойлголт дээшилсэн байдал Сургалтын үр дүнгийн нээлттэй хяналт, ил тод байдал Ирээдүйн сургалтын төлөвлөлт, тогтвортой сайжруулалт хийх суурь мэдээлэл
	5.2 Төгсөгчдийн сүлжээ үүсгэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах	Төгсөгчдийн холбоо, харилцааны мэдээлэл (имэйл, нийгмийн сүлжээ, холбоо барих сувгууд) Сүлжээг дэмжих платформ, хэрэгсэл, технологи Сүлжээг хөгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих аргачлал, зааварчилгаа	Төгсөгчдийн идэвхтэй сүлжээ, мэдээлэл солилцоо Хамтын ажиллагаа, төсөл, арга хэмжээний амжилттай хэрэгжилт Төгсөгчдийн туршлага, мэдлэгийг хуваалцах, сургалтын үр дүнг баталгаажуулах боломж
	5.3 Дараагийн шатны сургалт, хөтөлбөр төлөвлөх	Өмнөх сургалтын явцын дүгнэлт, үнэлгээ, сайжруулалтын зөвлөмж Оролцогчдын сэтгэл ханамж, шаардлага, санал хүсэлт Хөтөлбөр боловсруулах нөөц, багшлах хүчин, материал, технологи	Шинэ шатны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө Сургалтын зорилго, үр дүн, суралцагчдын ур чадварын чиглэл тодорхой болсон байдал Ирээдүйн сургалтын чанар, үр нөлөөг баталгаажуулах суурь

Сургалтын хөтөлбөрт шинэ хичээл тусгах процесс

Үе шат	Дэд алхам	Оролт	Гаралт
1. Бэлтгэл үе шат	1.1 Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийх	Одоогийн хөтөлбөрийн дүн шинжилгээ, судалгаа	Судалгааны тайлан, дүгнэлт
	1.2 Хөтөлбөрт оролцогч талын судалгаа авах. /Багш, төгсөгч, суралцагч/	Багш, төгсөгч, суралцагчдаас авах судалгааны арга зүй, асуулгын хуудас	Оролцогч талын хэрэгцээ шаардлага тодорхой болох
	1.3 Салбарын чиг хандлага, олон улсын жишиг судлах	Олон улсад судлагдсан судалгааны материал, статистик, стандарт	Салбарын хөгжил, чиг хандлагыг тодорхойлох
	1.4 Хичээлийн хэрэгцээг нотлох	Судалгааны тайлангийн нэглсэн дүгнэлт, зах зээлийн шинжилгээ	Баримт нотолгоотой үндэслэл
	1.5 РЕО, PLO-д өөрчлөлт оруулах санал	Хөтөлбөрийн одоогийн зорилго, хичээл хоорондын матриц	Хөтөлбөрт орох өөрчлөлтийн санал тодорхой болох

2. Батлуулах үе шат	2.1 Хичээлийн товч тодорхойлолт, зорилго, зорилт боловсруулах	Судалгааны дүгнэлт, хэрэгцээ шардлагад үндэслэх	CLO тодорхой болох
	2.2 Хичээлийн ерөнхий мэдээлэл боловсруулах (нэр, код, улирал, багц цаг, багш, сурах бичиг	Судалгааны дүгнэлт, хэрэгцээ шардлагад үндэслэх Сургалт зохион байгуулах одоогийн нөхцөл байдлыг судлах	Агуулга, үргэлжлэх хугацаа, хичээлийн зохион байгуулалт тодорхой болгох. Багшлах боловсон хүчин, хичээлийн хэрэглэгдэхүүний мэдээлэл тодорхой болох
	2.3 Суралцахуйн үр дүн, агуулга боловсруулах	Одоогийн хөтөлбөрийн зорилго, зорилт хичээл хоорондын холбоос, Шинээр боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн CLO.	Сургалтаар олгох мэдлэг, ур чадварын жагсаалт
2. Батлуулах үе шат	2.4 Сургалтын арга зүй, үнэлгээний зарчим тодорхойлох	Сургалтын арга зүй, үнэлгээний шинэ хэлбэр судлах	Сургалтын арга зүй, үнэлгээний хэлбэр тодорхой болох
	2.5 Хичээлийн хөтөлбөр батлах	Хичээлийн хөтөлбөрийн үлгэрчилсэн загвар	Хичээл орох багш, тэнхим, профессорын багийн гарын үсгээр баталгаажуулсан албан ёсны баримт бүрдэх.
	2.6 Хэлэлцэх	Танилцуулга хийх	Шинэ хичээл нэмэх үндэслэл, шаардлагыг ойлгуулах
	2.7 Тэнхимээс гарсан саналыг хянаж, холбогдох засвар өөрчлөлтийг хийлгэх	Хөтөлбөрийн өөрчлөлт, шинэ хичээлийн хөтөлбөрийн саналын танилцуулга	Санал, зөвлөмж, сайжруулалт
	2.8 Бүтцийн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Хөтөлбөрийн ерөнхий хороонд хүргүүлэх шийдвэр гаргуулах	Хөтөлбөрийн дэд хорооны хурлаас дэмжсэн шийдвэр	Бүтцийн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, дэмжсэн шийдвэр
	2.9 Хэлэлцэх	Хөтөлбөрийн өөрчлөлт, шинэ хичээлийн хөтөлбөрийн саналын танилцуулга	Санал, зөвлөмж, сайжруулалт
	2.10 Саналыг хянаж, холбогдох засвар өөрчлөлтийг хийлгэх	Хөтөлбөрийн өөрчлөлт, шинэ хичээлийн хөтөлбөрийн саналын танилцуулга	СУИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор дэмжсэн шийдвэр
	2.11 Хэлэлцэх	Хөтөлбөрийн ерөнхий хороогоор дэмжигдсэн шийдвэр танилцуулж, хэлэлцэх	Шинэ хичээл нэмэх үндэслэл, шаардлагыг ойлгуулах
	2.12 Захирлын тушаалаар батлах.	СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэр	Батлагдсан тушаал, сургалтын төлөвлөгөө

3. Хэрэгжилт ба чанарын баталгаажуулалт үе шат	3.1 Хөтөлбөрт оролцогч талын судалгаа	Багш, суралцагч, төгсөгчөөс тогтмол хугацаанд давтамжтай судалгаа авах	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин (судалгаа, асуулга, үнэлгээний хуудас) Сургалтын чанар, арга зүйн үр дүнгийн талаарх санал Ирээдүйн сургалтын сайжруулалт, зөвлөмжид ашиглах мэдээлэл
	3.2 Сургалтын явцын дүгнэлт	Багшийн ажиглалт, тэмдэглэл, үнэлгээ, дүн Сургалтын орчин, багшлах хүчин, хэрэглэсэн технологи	Сургалтын явцын тайлан, дүгнэлт Сургалтын чанар, арга зүй, үр дүнгийн үнэлгээ
	3.3 Сайжруулалтын зөвлөмж боловсруулах	Сургалтын явцын дүгнэлт, үнэлгээний мэдээлэл Оролцогчдын санал, сэтгэл ханамжийн үр дүн Сургалтын материал, арга зүй, орчинтой холбоотой ажиглалт	Сургалтын сайжруулалтын тодорхой зөвлөмж, аргачлал Сургалтын чанарыг дээшлүүлэх шийдэл, үр дүнгийн баталгаа

ДИБ-ыг хичээлийн агуулгад тусгах процесс

Үе шат	Дэд алхам	Оролт	Гаралт
1. Бэлтгэл үе шат	1.1 Салбарын чиг хандлага, олон улсын жишиг судлах	Олон улсад судлагдсан судалгааны материал, статистик, стандарт	Салбарын хөгжил, чиг хандлагыг тодорхойлох
	1.2 Хичээлийн шинэчлэгдсэн агуулгын хэрэгцээг нотлох	Судалгааны тайлангийн нэгдсэн дүгнэлт, зах зээлийн шинжилгээ	Баримт нотолгоотой үндэслэл
	1.3 CLO-д өөрчлөлт оруулах санал	Хичээлийн одоогийн зорилго, хичээл хоорондын матриц	Хичээлийн хөтөлбөрт орох өөрчлөлтийн санал тодорхой болох

2. Батлуулах үе шат	2.1 Суралцахуйн үр дүн, агуулга шинэчлэх	Одоогийн хөтөлбөрийн зорилго, зорилт хичээл хоорондын холбоос, Шинээр боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн CLO.	Сургалтаар олгох мэдлэг, ур чадварын жагсаалт
	2.2 Хичээлийн товч тодорхойлолт, зорилго, зорилт боловсруулах санал	Судалгааны дүгнэлт, хэрэгцээ шаардлагад үндэслэх	CLO тодорхой болох
	2.3 Хичээлийн төлөвлөгөөг багш, тэнхимийн эрхлэгчийн гарын үсгээр батлах.	Хичээлийн төлөвлөгөө шинэчилсэн төсөл	Батлагдсан хичээлийн төлөвлөгөө
3. Хэрэгжилт ба чанарын баталгаажуулалт үе шат	3.1 Хөтөлбөрт оролцогч талын судалгаа	Багш, суралцагч, төгсөгчөөс тогтмол хугацаанд давтамжтай судалгаа авах	Оролцогчдын сэтгэл ханамжийн түвшин (судалгаа, асуулга, үнэлгээний хуудас) Сургалтын чанар, арга зүйн үр дүнгийн талаарх санал Ирээдүйн сургалтын сайжруулалт, зөвлөмжид ашиглах мэдээлэл
	3.2 Сургалтын явцын дүгнэлт	Багшийн ажиглалт, тэмдэглэл, үнэлгээ, дүн Сургалтын орчин, багшлах хүчин, хэрэглэсэн технологи	Сургалтын явцын тайлан, дүгнэлт Сургалтын чанар, арга зүй, үр дүнгийн үнэлгээ
	3.3 Сайжруулалтын зөвлөмж боловсруулах	Сургалтын явцын дүгнэлт, үнэлгээний мэдээлэл Оролцогчдын санал, сэтгэл ханамжийн үр дүн Сургалтын материал, арга зүй, орчинтой холбоотой ажиглалт	Сургалтын сайжруулалтын тодорхой зөвлөмж, аргачлал Сургалтын чанарыг дээшлүүлэх шийдэл, үр дүнгийн баталгаа

ХАВСРАЛТ 3.

ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР (СУИС-ийн загвараар)

“Дэлхийн иргэний боловсролын манлайлал ба сургалтын арга зүй”			
	Дэлхийн иргэний боловсролын манлайлал ба сургалтын арга зүй		
Хичээлийн код:	700	Хичээлийн багц цаг:	3
Салбар тэнхим	ХБСТ	Сургууль	Соёлын сургууль
Хичээлийн өмнөх холбоо	-	Хамт судлах хичээлийн код	
БАГШИЙН МЭДЭЭЛЭЛ:			
Багшийн нэр:		Өрөөний дугаар:	
E-mail хаяг:		Утасны дугаар	
Сургалтын нийт цаг:	Нийт: 64 сургалтын цаг. Лекцийн (32 цаг), Семинарын (32 цаг)		
Хичээлийн төрөл:	Сонгон судлах		
Санал болгох улирал:	☐ 1-р улирал ☐ 2-р улирал ☒ Дурын улирал		
ХИЧЭЭЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ			
Энэхүү хичээл нь дээд боловсролын байгууллагад дэлхийн иргэний боловсрол (ДИБ/GCED)-ыг нэвтрүүлэхэд чиглэсэн онол, арга зүй, манлайллын суурь мэдлэг, чадвар олгоно. Суралцагчид GCED-ийн үндсэн үзэл баримтлал, сургалтын арга зүйг эзэмшиж, өөрийн байгууллагад хэрэгжүүлэх боломжтой сургалтын нэгж (модуль) боловсруулах чадвартай болно.			
ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД:			
- ДИБ-ын үндсэн ойлголт, UNESCO/APCEIU-н хүрээ, SDG 4.7-тэй уялдуулан тайлбарлах. - Дээд боловсролын хөтөлбөрт ДИБ-ыг хичээл, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан шингээх аргыг эзэмшүүлэх. - Манлайлал, шийдэлд суурилсан сэтгэлгээг төлөвшүүлэх замаар төгсөгчдийн чадамжийг бэхжүүлэх. - Оюутан, багшийн хамтын ажиллагаа болон бакалавр–магистрын гүүр үүсгэх сургалтын арга барилыг турших			
УНШИХ МАТЕРИАЛ:			
Уншин материалын нэр			Он
- UNESCO (2021). Towards a Common Definition of Micro-credentials			2021
- OECD (2022). Micro-credential Innovations in Higher Education			2022
- APCEIU (2020). Comprehensive GCED Course Development Guide			2020
- Боловсролын ерөнхий хууль			2023
- Дээд боловсролын тухай хууль			2023
- Монгол Улсын Ерөнхий боловсролын тухай хууль			2023
ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГҮҮД (CLO):			
Оюутан * лекцийн * семинарын хичээлийг судалснаар дараах чадварыг эзэмшинэ:			PLO-ын хамаарал
1	ДИБ-ын суурь ойлголт, чиг хандлагыг тайлбарлаж чадна.		
2	Сургалтын арга зүйг (сократ маягийн асуулт, төсөлд суурилсан, урлагийн бүтээлч арга) ДИБ-д хэрэглэж чадна.		

3	Манлайллын шийдэл боловсруулахад чиглэсэн хичээл, модулийн төлөвлөгөө боловсруулна.	
4	Бакалавр болон магистрын түвшний суралцагчдыг холбосон бүтээлч арга зүй зохион байгуулж, туршина.	
5	Өөрийн боловсруулсан модуль/хичээлийг танилцуулж, үнэлгээний аргачлал боловсруулах чадвартай болно.	

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ:

* Лекц, * Семинарын, Лабораторийн хичээлийн агуулга:

Долоо хоног	Хичээлийн сэдэв	Сэдвийн агуулга	Цаг	CLOs-н хамаарал
I	GCED-ийн үндэс ба Монголын нөхцөл	UNESCO/APCEIU хүрээ, төгсөгчийн профайл (doer leader), МУ-ын боловсролын бодлоготой уялдуулах	3	CLO1
II	Сургалтын арга зүй ба урлагийн гүүр	ДИБ-ын сургалтын арга барил (туршлага, уран бүтээлд суурилсан), хамтын оролцоо	3	CLO2
III	Манлайлал ба шийдэлд суурилсан сургалт	Graduate profile-тэй холбох, бакалавр-магистрын хамтын ажиллагааны арга	3	CLO3, CLO4
IV	Capstone: Миний GCED модуль	Суралцагч өөрийн хичээл/модулийн загвар боловсруулж танилцуулах	3	CLO3, CLO5

СУРГАХ, СУРАЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (TLA):

Хичээлд ашиглах сурган заах арга зүй /Pedagogy/	Сургалт явуулах хэлбэр	CLOs хамаарал
- GCED-ийн арга зүй	- Лекц - Семинар - Бие даан гүйцэтгэх	1-5

ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ:

Үнэлгээний аргууд	Үнэлгээ хийх давтамж	Үнэлгээний эзлэх хувь	CLOs хамаарал
Эссэ асуултын даалгавар	7 хоног бүр	20%	1- 3
Суралцахуйн явцын оролцоо, хэлэлцүүлэг	7 хоног бүр	20%	1- 3
Capstone төслийн ажил (GCED модуль/хичээл боловсруулах)	Улирал	60%	1- 3

ШИНЭЧИЛСЭН:

Багш:		Огноо: 2025.09.12	
-------	--	-------------------	--

ХЯНАСАН:

Салбарын эрхлэгч		Огноо: 2025.09.12	
------------------	--	-------------------	--



APCEIU
Asia-Pacific Centre of
Education for
International Understanding



**МОНГОЛ УЛСЫН СОЁЛ
УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ**

ЮНЕСКО-ийн дэргэдэх Олон улсын ойлголцлын боловсролыг дэмжих Ази, Номхон далайн төв
120, Сазмал-ро, Гүро-гу, Сөүл хот, Бүгд Найрамдах Солонгос Улс, 08289
Tel: (+82-2) 774-3956, Fax: (+82-2) 774-3957
www.unescoapceiu.org

Соёл Урлагийн Их Сургууль
Чингэлтэй дүүрэг, Бага Тойруу -26, Улаанбаатар хот, Монгол улс, 210646
Утас: +976-11-325205
<https://en.mnuac.edu.mn>

APCEIU–СУИС хамтарсан судалгаа:

**Монгол Улсын дээд боловсролын
байгууллагуудад Дэлхийн иргэний
боловсролыг нэвтрүүлэх суурь судалгаа**

©APCEIU & MNUAC 2025
ISBN 979-11-93573-52-5
RR-RND-2025-018

Солонгосын судалгааны баг
Жо Дэхүний (Сүншин Эмэгтэйчүүдийн их сургууль)
И Жи Хян (Гёнхи их сургууль)

Монголын судалгааны баг
Дагмидын Одсүрэн (Соёл урлагийн их сургууль)
Балдандоржийн Мандухай (Соёл урлагийн их сургууль)
Дашцэдэний Түмэннаст (Соёл урлагийн их сургууль)
Мягмарсүрэнгийн Амартүвшин (Соёл урлагийн их сургууль)
Чойжилсүрэнгийн Дэлгэрцэцэг (Соёл урлагийн их сургууль)
Биндэрьяагийн Пунсалдулам (Соёл урлагийн их сургууль)

Дижитал хувилбарыг APCEIU-ийн вэбсайтад байршуулав.

APCEIU–СУИС хамтарсан судалгаа:

**Монгол Улсын дээд боловсролын
байгууллагуудад Дэлхийн иргэний
боловсролыг нэвтрүүлэх суурь судалгаа**



9 791193 573525
ISBN 979-11-93573-52-5